

Улсын бүртгэлийн  
дугаар.....

Нууцын зэрэглэл:

Аравтын бүрэн  
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх  
гэрээний дугаар:  
ШуСс\_2020/30

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН  
ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛ: ЯПОН УЛСТАЙ  
ХӨГЖҮҮЛЖ БУЙ ЭДИЙН ЗАСГИЙН  
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮҮРЭГ”**

Суурь судалгааны төслийн тайлан  
2020-2023 он

Төслийн удирдагч: Балсангийн Сэржав  
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн  
эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,  
түүхийн ухааны доктор (Ph.D),  
дэд профессор

Санхүүжүүлэгч байгууллага: Шинжлэх ухаан, технологийн сан

Захиалагч байгууллага: Боловсрол, Шинжлэх Ухааны Яам

Тайлан өмчлөгч: ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн  
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, Баруун сэлбэ 15-р гудамж,  
Цахим хуудас: [www.iiia.ac.mn](http://www.iiia.ac.mn)  
Утас:976-317185

УЛААНБААТАР  
2023 он

Улсын бүртгэлийн  
дугаар.....

Нууцын зэрэглэл:

Аравтын бүрэн  
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх  
гэрээний дугаар:  
ШуСс\_2020/30

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

# “МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛ: ЯПОН УЛСТАЙ ХӨГЖҮҮЛЖ БУЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮҮРЭГ”

Суурь судалгааны төслийн тайлан  
2020-2023 он

Төслийн удирдагч: Балсангийн Сэржав  
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн  
ЭШТА, түүхийн ухааны доктор (Ph.D),  
дэд профессор

Гүйцэтгэгчид: Ц.Баатар ШУА-ийн ОУСХ-гийн ЭШТА,  
шинжлэх ухааны доктор (Sc.D)  
Ц.Батбаяр ШУА-ийн ТУЗХ-гийн ЭШТА,  
академич, шинжлэх ухааны доктор (Sc.D),  
төслийн гэрээт ажилтан  
М.Болормаа ШУА-ийн ОУСХ-гийн ЭШДэдА,  
докторант, япон судлаач  
У.Загдцэсэм ШУА-ийн ОУСХ-гийн ЭШДэдА,  
докторант, япон судлаач  
Б.Саранчимэг ШУА-ийн ОУСХ-гийн ЭШДэдА,  
докторант, япон судлаач  
А.Сосорбурам ШУА-ийн ОУСХ-гийн ЭШДэдА,  
магистр, япон судлаач  
Л.Хайсандай ШУА-ийн ОУСХ-гийн ЭШТА,  
шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

УЛААНБААТАР  
2023 он

## ТӨСЛИЙН КАРТ

Сэдэвт ажлыг баталсан тушаал, огноо: БСШУС-ын Сайдын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/134 тоот тушаал

Сэдвийн тайлангийн бүрэн нэр: “Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Япон Улстай хөгжүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагааны үүрэг” судалгааны төслийн тайлан

Сэдэвт ажлын төрөл: Суурь судалгааны сэдэвт ажил

Сэдвийн захиалагч байгууллага: Боловсрол, Шинжлэх Ухааны Яам

Гүйцэтгэгч байгууллага: ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн

Хэрэгжүүлэх хугацаа: 2020-2023 он

Батлагдсан санхүүжилт: 43,000.0 мянган төг

Гүйцэтгэгч байгууллагын

- Нэр: ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн
- Регистрийн дугаар: РД 9095837
- Дансны дугаар: 100900015480
- Банкны нэр: Төрийн сан
- Хаяг: УБ хот, Чингэлтэй дүүрэг, Баруун Сэлбэ-15,

- Вэб хуудас, И-мэйл:

ШУА-ийн Нэгдсэн II байр  
[www.ii.ac.mn](http://www.ii.ac.mn), [ii@mas.ac.mn](mailto:ii@mas.ac.mn)

Сэдвийн удирдагчийн

- Нэр : Б.Сэржав Олон улс судлалын хүрээлэнгийн

эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D), дэд профессор  
ХМ 57042308  
а: 976-11-317185, гар: 99714655  
[b\\_serjav@yahoo.com](mailto:b_serjav@yahoo.com)

Гэрээний дугаар: ШуСс\_2020/30 2020.05.19

Санхүүжүүлэгч байгууллага: Шинжлэх Ухаан, Технологийн Сан

Сэдэвт ажлын код: 20НН05СС352

Тайлангийн төрөл: Эцсийн тайлан

Нууцын зэрэглэл: Энгийн

Тайланг өмчлөгч байгууллага: ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн  
Сэдэв гүйцэтгэсэн хот: Улаанбаатар

Тайлан бичсэн он: 2024 оны нэгдүгээр сар

## РЕФЕРАТ

Энэ төслийн хүрээнд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008 он), Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010 он) зэрэг баримт бичигт тусгагдсан хөгжлийн стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд үр дүнгээ өгч болохуйц гадаад хүчин зүйлсийн дотроос Японы хүчин зүйлийг сонгон авч, түүнээс Монгол, Японы олон талт хөгжлийн түншлэлийн талаар судлан, цаашид хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг улам хөгжүүлж манай улсын нийгэм, эдийн засгийн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд хэрэг болохуйц судалгааны санал дүгнэлт дэвшүүлэхийг зорилоо. Мөн Тусгай стратегийн түншлэл, эдийн засгийн түншлэлийн харилцааны шатанд Япон Улстай тогтоон хөгжүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, чиг хандлагын талаар судалгаа явуулж, харилцаа хамтын ажиллагааны боломж, шинэ хэлбэрийн талаар эрэлхийлж ажилласан юм. Судалгааны үр дүнг хамтын бүтээл, судалгааны өгүүлэл, илтгэл, зөвлөмж зэрэг хэлбэрээр олон нийтэд хүргэх, төрийн байгууллага, бодлого боловсруулагчдын ажлын хэрэгцээнд тус нэмэр оруулахыг зорив.

Төслийн үр дүнгээр нийтлэгдсэн хамтын бүтээл, судалгааны өгүүлэл, хэлэлцүүлсэн илтгэл зэрэгт Монгол, Японы олон талт хөгжлийн түншлэлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг хоёр орны улс төр, худалдаа, эдийн засаг, аялал жуулчлал, уул уурхай, хөдөө аж ахуй, хөдөлмөрийн салбарын хамтын ажиллагааны чиглэлээр хөндөн авч үзэж, тухайлан эдгээр салбарын хөгжлийн хамтын ажиллагаа нь манай улсад өнөөдөр тулгамдаж буй асуудлыг зохистойгоор шийдвэрлэхэд ач холбогдлоо өгнө гэсэн дүгнэлтэд хүрсэн болно. Мөн хоёр орны хөгжлийн түншлэл тухайлбал, тогтвортой хөгжлийн хамтын ажиллагаа, аялал жуулчлал, мал аж ахуй, хөдөө аж ахуй зэрэг салбарын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага болон Япон Улсын гадаад дотоод бодлого, бүс нутгийн тулгамдсан зарим асуудлын талаар судлаачдын санаа бодлыг тусгасан өгүүлүүд нийтлэгдэж уншигчдын хүртээл боллоо.

## **Төслийн судалгааны үр дүн:**

### **1. Хамтын бүтээл (1 ш, 18.0 х.х.)**

- “Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Монгол, Японы олон талт хөгжлийн түншлэл” (“Битпресс” хэвлэлийн компани, УБ., 2023 он, Редактор Ц.Баатар, хэвлэлд бэлтгэсэн У.Загдцэсэм)

### **2. Нэгэн сэдэвт зохиол (1 ш, 27.3 х.х.)**

- Ц.Батбаяр “Монгол ба Япон ХХ-XXI зуунд: “Гуравдагч хөрш”-ийн харилцааны түүх” (“Бэмби сан” хэвлэлийн компани, УБ., 2022 он, Редактор Б.Сэржав, хэвлэлд бэлтгэсэн У.Загдцэсэм) нэгэн сэдэвт зохиол хэвлэгдэн гарсан.

### **3. Эмхэтгэл (3 ш, 56.5 х.х., 58.0 х.х., 10.0 х.х.)**

- “Монгол Японы харилцаа он дарааллын товчоон: 1972-2022” эмхэтгэл (“Бэмби сан” хэвлэлийн компани, УБ., 2022 он, Редактор Л.Хайсандай, гүйцэтгэгч Б.Сэржав, У.Загдцэсэм, М.Болормаа, А.Сосорбурам),

- “Монгол Японы харилцаа: Баримт бичгүүд 1972-2022” эмхэтгэл (“Соёмбо” хэвлэлийн компани, УБ., 2022 он, Редактор Л.Хайсандай, Ц.Батбаяр, Д.Золбоо, Р.Төрдалай нар, гүйцэтгэгч Б.Сэржав, У.Загдцэсэм, М.Болормаа, А.Сосорбурам нар),

- “Олон улс судлал-2022: Монголын япон судлал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, “Соёмбо” хэвлэлийн газар, УБ., 2023 он (Редактор Р.Төрдалай, хэвлэлд бэлтгэсэн Б.Саранчимэг) тус тус хэвлэгдсэн.

### **4. Нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл (18 ш, 17 х.х., үүнээс гадаадад 5 ш)**

- Манай улсад тусган хэрэгжүүлж болохуйц хөгжлийн туршлага, хоёр орны харилцаа, хөгжлийн түншлэлийн түүх, өнөөгийн байдал, чиг хандлага, бүс нутгийн хамтын ажиллагаа, Япон Улсын гадаад дотоод бодлогын асуудлыг хөндөн авч үзсэн нийт 17 х.х гаруй 18 ширхэг судалгааны өгүүлэл нийтлэгдсэн.

**5. Хэлэлцүүлсэн эрдэм шинжилгээний илтгэл (11 удаа, үүнээс олон улсын хуралд 6 удаа)**

- Сэдвийн судалгааны үр дүнгээр олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд 11 удаа илтгэл хэлэлцүүлсэн.

**6. Зохион байгуулсан олон улсын э/ш хурал (1 удаа, 2022.09.03, Улаанбаатар),**

**дотоодын э/ш хурал (2 удаа, 2022.12.23, Улаанбаатар, 2023.05.27, Улаанбаатар)**

- “Монгол, Японы хоорондын боловсрол, соёл урлаг, эдийн засаг, спортын салбар дахь 50 жилийн хамтын ажиллагааг эргэцүүлэх нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг (Улаанбаатар, 2022.09.03) Соёл эрдэм дээд сургууль, Токиогийн гадаад судлалын их сургуулийн Ази, Африкийн хэл соёл судлалын хүрээлэнтэй хамтран зохион байгуулав. Хуралд монгол, японы 30-аад эрдэмтэд судлаачид илтгэл тавьж хэлэлцүүлэв.

- “Олон улс судлал-2022: Монголын япон судлал” эрдэм шинжилгээний хурлыг (Улаанбаатар, 2022.12.23) зохион байгуулж, нийт 11 илтгэл хэлэлцэв.

- “Монгол-Японы боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны харилцаа, хамтын ажиллагаа” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг (Улаанбаатар, 2023.05.27) Монголын Япон Судлалын Нийгэмлэг, Япон Улсад докторын зэрэг хамгаалсан монгол эрдэмтдийн Хакасэкай Холбоотой хамтран зохион байгуулж, 9 эрдэмтэн судлаачид илтгэл тавьж хэлэлцүүлэв.

**7. Эрдэм шинжилгээний семинар 7 удаа**

- Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл болон Монгол, Японы эдийн засгийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлын сэдвээр эрдэм шинжилгээний семинарыг өөрийн хүрээлэн дээр 7 удаа зохион байгуулан, 12 илтгэл хэлэлцүүлж, төслийн судалгаанд эрдэмтэд, судлаачдын санал бодлыг тусгах талаар анхаарч ажиллав.

## **8. Бодлогын зөвлөмж 2 удаа**

- Б.Сэржав “Бага, дунд сургуулийн Ёс зүйн хичээлийн Сургалтын хөтөлбөрийг сайжруулахад туслах зорилгоор “Японы бага сургуульд ёс зүйн боловсрол олгож буй туршлагаас” сэдвээр Бодлогын зөвлөмж (0,7 х.х.) боловсруулж УИХ-ын ажлын алба, Боловсрол, Шинжлэх ухааны яамны албан хэрэгцээнд зориулан 2021.03 дугаар сард хүргүүлэв.

- Б.Сэржав, Ц.Баатар, У.Загдцэсэм, А.Сосорбурам “Япон Улсын ногоон хөгжлийн бодлого, туршлага, сургамж” сэдвээр Бодлогын зөвлөмж (0,9 х.х.) боловсруулж, УИХ-ын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн, Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн ажлын алба, Эдийн засаг, хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээнд зориулан 2023.12 дугаар сард тус тус хүргүүлэв.

## **9. Шинжлэх ухааныг сурталчлах ажил, хэвлэлийн ярилцлага 2 удаа**

- У.Загдцэсэм “Монгол, Японы улс төрийн харилцаа идэвхжиж байна” (0,5 х.х.), Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Япон Улсад хийсэн албан ёсны айлчлалд зориулж “Өдрийн сонин” 2021.07.30

- У.Загдцэсэм “Ерөнхий сайд Ф.Кишида Японыг шинжлэх ухаан, инновацийн их гүрэн болгох зорилт дэвшүүлсэн” (0,8 х.х.), “Зууны мэдээ” сонин 2021.10.21, №207 (6684)

**Түлхүүр үг:** Японы хөгжлийн туршлага, ногоон хөгжил, бодлого боловсруулалт хэрэгжүүлэлт, стратегийн түншлэл, эдийн засгийн түншлэл, эдийн засгийн хамтын ажиллагаа

**Сэдэвт ажлын гүйцэтгэгчид:**

1. Баатар Ц. - шинжлэх ухааны доктор (Sc.D), эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
2. Батбаяр Ц. - академич, шинжлэх ухааны доктор (Sc.D), эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, төслийн гэрээт ажилтан
3. Болормаа М. - докторант, эрдэм шинжилгээний дэд ажилтан, япон судлаач
4. Загдцэсэм У. - докторант, эрдэм шинжилгээний дэд ажилтан, япон судлаач
5. Саранчимэг Б. - докторант, эрдэм шинжилгээний дэд ажилтан, япон судлаач
6. Сосорбурам А. - магистр, эрдэм шинжилгээний дэд ажилтан, япон судлаач
7. Сэржав Б. - доктор (Ph.D), дэд профессор, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, япон судлаач, төслийн удирдагч
8. Хайсандай Л. - шинжлэх ухааны доктор (Sc.D), эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан



## ГАРЧИГ

1. Нэр томьёо, тайлбар, товчилсон үгсийн жагсаалт .....	8
2. Удиртгал .....	9
3. Сэдвийн судалгааны тойм .....	12
4. Дүгнэлт .....	30
5. Ашигласан материалын жагсаалт .....	32
6. Хавсралт 1.....	39
7. Хавсралт 2 .....	48

## НЭР ТОМЬЁО, ТАЙЛБАР, ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

- |           |  |
|-----------|--|
| 1. АНУ    | Америкийн Нэгдсэн Улс                                |
| 2. БНМАУ  | Бүгд Найрамдах Монгол Ард Улс                        |
| 3. ЗХА    | Зүүн Хойд Ази  |
| 4. ЖАЙКА  | Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага |
| 5. ЖДҮ    | Жижиг дунд үйлдвэр                                   |
| 6. МУИС   | Монгол Улсын Их Сургууль                             |
| 7. НҮБ    | Нэгдсэн Үндэстний Байгууллага                        |
| 8. УИХ    | Улсын Их Хурал                                       |
| 9. ХАА    | Хөдөө Аж Ахуй  |
| 10. ШУА   | Шинжлэх Ухааны Академи                               |
| 11. ЭЗТХ  | Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр                   |
| 12. ЭШДэА | Эрдэм шинжилгээний дэд ажилтан                       |
| 13. ЭШТА  | Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан                 |

## Удиртгал

XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграци өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Нөгөөтээгүүр, улс орнуудын хөгжлийн хурд, түвшин улам бүр ялгарч байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол хийгээд халдварт өвчний тархалт, олон улсын нөхцөл байдлын хямрал зэрэг аюул, сорилт нэмэгдэж, хүн төрөлхтний өнгөрсөнд гаргасан алдаа, сөргөлдөөнөөс сургамж авч аюулгүй, байгаль дэлхийд ээлтэй хөгжил дэвшлийг улс орон, хүн бүр тэгш хүртсэн дэлхий ертөнцийг цогцлоох үүрэг хариуцлага тулгараад байгаа билээ.

Энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үүднээс 2015 онд НҮБ-ын 70 дугаар чуулган “Эх дэлхийгээ өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030” сэдвээр хуралдаж, 2030 он хүртэлх хугацаанд дэлхий нийтээр хэрэгжүүлэхийг зорих хөгжлийн зорилтыг дэвшүүлснээр улс орон бүр хөгжлийн бодлогоо эргэн харж, үндэсний хөгжлийн бодлогоо шинэчлэн гаргаж, үйл ажиллагаагаа явуулж эхлээд багагүй хугацааг өнгөрүүлээд байна.

Эдийн засгийн чадамж сул, хөгжиж буй орнууд дангаараа “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030”-ийн хүрээнд дэвшигдсэн 17 зорилтыг дурдсан хугацаанд амжилттай хэрэгжүүлэхэд хүндрэлтэй бөгөөд хөгжлийн төлөө өндөр хөгжилтэй орнуудтай харилцан ашигтай түншлэлийг хөгжүүлэх нь товлосон хугацаанд зорилтоо хэрэгжүүлэхэд хамгийн зөв зам байх талаар 2002 онд Өмнөд Африкийн Иоханнесбург хотноо зохион байгуулагдсан НҮБ-ын гишүүн орнуудын төр засгийн тэргүүн оролцсон “Даян дэлхийн тогтвортой хөгжлийн чуулган”-аас батлан гаргасан “Улс төрийн тунхаглал” баримт бичгийн 7 дугаар зарчмыг баримтлан “... олон улсын хамтын ажиллагааг өсгөн нэмэгдүүлж, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин гэсэн хоорондоо харилцан хамаарал бүхий бие биеэ тэтгэх тогтвортой хөгжлийн гурван бүрдэл хэсгийг интеграцчилах явдлыг дэмжихэд оршино” хэмээн заасан.

Тэгвэл ардчилсан тогтолцоонд шилжихээс өмнөх хугацаанд геополитикийн гадаад орчноос ихээхэн хамааралтай байхын түүхэн сургамжийг туулж ирсэн,

хоёр их гүрний дунд оршдог манай улсын хувьд тогтвортой хөгжлийн зорилтоо хангахад гадаад хүчин зүйл болох дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудтай харилцааг өргөтгөн гүнзгийрүүлэх, хөгжлийн төлөөх улс орнуудын түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал зайлшгүй шаардлагатай. 2001 оны 12 дугаар сарын 27-нд Монгол Улсын Их Хурлаар батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын тухай” хуулийн 3 дугаар зүйлд ““Үндэсний аюулгүй байдал” гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ” хэмээн заасан. Энэхүү гадаад нөхцөл баталгаатай хангагдахад “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-д заасан “хоёр хөрштэйгөө найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэхийн зэрэгцээ, “гуравдагч” хөрштэйгөө харилцаа, хамтын ажиллагааг боломжит бүхий л салбарт өргөжүүлэн хөгжүүлэх” зорилтын хүрээнд манай улсын Япон Улстай хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаа чухал байр суурь эзэлнэ.

Хоёр улсын тус тусын ашиг сонирхол хийгээд харилцан идэвхтэй хүчин чармайлт гаргасны үрээр Монгол Улсын олон тулгуурт, бие даасан гадаад бодлогын хүрээнд Монгол, Японы харилцаа 1990 оноос хойш богино хугацаанд олон салбарыг хамран гүнзгийрч 1997 онд “Иж бүрэн түншлэл”-ийн харилцаа”-нд шилжиж, 2010 онд бусад гуравдагч хөрш орнуудаас түрүүлэн “Стратегийн түншлэлийн харилцаа”-нд дэвшиж, 2016 онд манай улсын хувьд гадаад улс орнуудтай байгуулсан анхны эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр болох “Монгол, Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр”-ийг байгуулсан бөгөөд 2022 онд “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай Стратегийн түншлэл”-ийг байгуулж буйгаа зарласан нь эдүгээ гуравдагч хөрш орнуудтай манай улсын тогтоон хөгжүүлж буй түншлэлийн харилцааны дээд шат болж байна.

Хоёр орон хөгжлийн түншлэлийн харилцааг хөгжүүлж ирсэн өнгөрсөн хугацаанд Япон Улсаас манай улсад үзүүлж ирсэн тусламж, хөгжлийн хамтын ажиллагааны бодлого нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтөд зохих хувь нэмрээ оруулсаар байгаа бөгөөд дэлхийн хөгжлийн хандлагатай нягт уялдаж ирснийг энд онцлон тэмдэглэе.

Иймд дэлхийн олон улсын хөгжил дэвшлийн өнөөгийн чиг хандлага, бүсчлэл, интеграцчиллын үйл явцын бодит нөхцөл байдалтай уялдуулан, манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлэх гадаад олон хүчин зүйлийн эерэг, сөрөг асуудлыг тал бүрээс системтэй нарийвчлан судлах шаардлага

тулгамдсаар ирсэн бөгөөд энэ асуудал цаашид ч тавигдсаар байх нь зайлшгүй. Тийм ч учраас ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажлын Дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд манай хөрш орнууд болон өндөр хөгжилтэй гуравдагч хөрш орнуудын судалгааг суурь судалгааны түвшинд гүнзгийрүүлэн судалж байхаар заасан. Энэ хүрээнд тус хүрээлэнд Монгол Улсаас Япон Улстай тогтоон хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагааны түүх, өнөөгийн байдал, хэтийн төлөвийн талаарх судалгааг тасралтгүй явуулах, уг судалгааг улсын хөгжлийн бодлого, улс оронд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлэх чиглэлтэй уялдуулан хэрэгжүүлж байх бодлогыг баримталж ирсний дагуу судалгаа хийж “Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Монгол Японы олон талт хөгжлийн түншлэл” хамтын бүтээлийг судалгааны багийн хамт олон туурвилаа.

Энэ судалгаа нь манай улсын хөгжлийн бодлогын удаа дараагийн баримт бичигт тодорхойлогдсон стратеги зорилтыг хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх, ард түмний аж амьдралын түвшинг дээшлүүлэхэд зохих хувь нэмрээ оруулж буй Монгол, Япон хоёр орны хөгжлийн түншлэлийг танилцуулах, бодлого боловсруулах байгууллагын ажлын хэрэгцээнд зориулсан санал зөвлөмж бэлтгэх зорилго тавьсан шинэлэг ажил болсон гэж үзнэ. Энэхүү судалгааны төслийн үр дүн манай улсад эдийн засаг, нийгмийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалсан хөгжлийн бодлогоо гүнзгийрүүлэхэд, түүнчлэн сургалт судалгааны байгууллагын үйл ажиллагаа, үйлдвэрлэл эрхлэгчид, өргөн олон уншигчдын хэрэгцээнд бүрэн нийцнэ хэмээн үзэж байна.

## **Сэдвийн судалгааны тойм**

Манай улсын урт, дунд хугацааны хөгжлийн стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд тус нэмэр үзүүлэх олон хүчин зүйлсийн дотроос Япон Улсын хүчин зүйл, тухайлан, манай улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжиж, хөгжлийн түншлэлийг хөгжүүлж ирсэн хүчин зүйлийг тодруулан судлах, цаашид хоёр орны хөгжлийн төлөөх түншлэлийг өргөжүүлэн гүнзгийрүүлэх боломжийг танилцуулах оролдлогыг энэхүү судалгааны хүрээнд хийсэн болно. Нэгэн зэрэг Монгол Улсаас Япон Улстай тогтоон хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагааг шинэ түвшинд урагшлуулах, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх, манай улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, ард түмний аж амьдралыг дээшлүүлэхэд тус дөхөм үзүүлэхүйц хамтын ажиллагааны арга хэлбэрийн талаар судалгааны эрэл хайгуул хийж, шинэлэг санаа дүгнэлт дэвшүүлэх зорилго тавьж ажиллалаа.

Япон Улс нь манай гадаад бодлогын хүрээнд гуравдагч хөрш хэмээн тодорхойлогддог, Тусгай стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлж буй орон. Монгол Улс, Япон Улсын хооронд 2015 онд Эдийн засгийн түншлэлийн Хэлэлцээр байгуулагдаж, 2016 оноос хэрэгжиж байгаа. Япон Улстай тогтоон хэрэгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаа нь манай улсын ардчилсан хөгжлийн шатанд эдийн засгийг тогтворжуулах, бэрхшээлийг даван туулахад олон талаар чухал ач холбогдлоо өгсөөр ирсэн. Хоёр талын Тусгай стратегийн түншлэлийг гүнзгийрүүлэн хөгжүүлэх чиг зорилго бүхий “Монгол, Японы Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэлийг хөгжүүлэх хамтарсан мэдэгдэл”-ийг 2022 онд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Япон Улсад хийсэн албан айлчлалын үеэр гаргасан юм. Өнгөрсөн хугацаанд хоёр орны өндөр дээд хэмжээний айлчлалуудын үеэр баталж гаргасан хоёр орны харилцааны баримт бичгүүдэд манай улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн төсөл хөтөлбөр, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйл ажиллагаанд өргөн хүрээтэй дэмжлэг тусламж үзүүлэх, туршлага солилцохоос эхлээд төрөл бүрийн салбарын хамтын ажиллагааг шинэ шатанд хөгжүүлэхээр харилцан тохиролцсон. Хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны шинэ ахиц дэвшил, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага нь манай улсын хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд Японы хүчин зүйлсийн учир холбогдлыг улам нэмэгдүүлж, нөгөө талаар хамтын ажиллагааны боломж

хэлбэрийн талаар судалгааны түвшинд эрэл хайгуул явуулах шаардлагыг ч бий болгосоор байна.

Япон Улс өнгөрсөн зууны сүүлийн хагаст эдийн засгийн эрчимтэй хөгжлөөр дэлхийн тэргүүлэх орны эгнээнд жагсч “Японы гайхамшиг”-ийг таниулж, дэлхийн хөгжлийн хандлагатай өөрийн орны эдийн засгийн хөгжлийг уялдуулан хөгжиж ирсэн орон. Тийм ч учраас манай улсад байгаль орчинд ээлтэй, үр ашигтай үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтөөр ард түмний аж амьдралыг эрс сайжруулах явдал нэн тэргүүний шаардлага болоод буй өнөөгийн нөхцөлд Япон Улстай тогтоон хөгжүүлж ирсэн олон талт хөгжлийн түншлэлийг танилцуулж, санал зөвлөмж боловсруулахад бидний ажил чиглэсэн юм.

Энэ судалгааны дагуу хийгдсэн ажлын тоймоос дурдвал:

**1. “Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Монгол, Японы олон талт хөгжлийн түншлэл”** (18 х.х. “Битпресс” хэвлэлийн компани, УБ., 2023 он, Редактор Ц.Баатар, эмхэтгэсэн У.Загдцэсэм) хамтын бүтээл. 3 бүлэг, 9 зүйл бүхий энэ хамтын бүтээлийн **“Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл” эхний бүлэгт** (доктор (Sc.D) Ц.Баатар, докторант У.Загдцэсэм, магистр А.Сосорбурам нар) манай улсын хөгжлийн гадаад хүчин зүйлс, Монгол Японы олон талт хөгжлийн түншлэлийн өнгөрсөн, одоо, ирээдүй, тухайлбал, хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар авч үзсэн.

Аливаа улс орны хөгжлийн асуудал дотоод хүчин зүйлстэй салшгүй холбоотой хэдий ч монголчууд бид 30 гаруй жилийн өмнө улс орноо парламентын ардчилал руу, төвлөрсөн төлөвлөгөөт дэглэмээс зах зээлийн эдийн засаг руу шилжүүлэх түүхэн шилжилтийг донор орнууд, олон улсын хөгжлийн институтүүдийн тусламж, хөнгөлөлттэй зээлийн дэмжлэгээр даван туулсан. Тиймээс өнгөрсөн хугацаанд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хөгжлийн гадаад хүчин зүйлсийн нэгэн тулгуур болсон олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагууд, хөгжлийн түнш орнуудтай тогтоосон хамтын ажиллагаа, хөнгөлөлттэй зээл, хөгжлийн тусламж түүний гүйцэтгэсэн түүхэн үүрэг, ололт амжилт, дутагдалтай талууд, түүний хэрэгжилтийн байдал, хамтын ажиллагааны хэлбэр, зорилго, ач холбогдол, үр өгөөжийг хэрхэн дээшлүүлэх талаар санал дэвшүүлж, олон нийтэд ойлголт өгөхөд зориулан товч танилцуулав.

Сүүлийн үед дэлхий нийтээр хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас зайлсхийж, хүний хөгжлийн асуудалд онцгой анхаарал хандуулж байна. Улс үндэстний гол баялаг, хөгжлийн хүч, ирээдүйг тодорхойлогч үнэт зүйл бол тухайн улсын иргэд байдаг талаар, хүний хөгжил гэдэг бол товчхондоо хүн төвтэй хөгжил-үйл явц хийгээд үр дүн бөгөөд өөрөөр хэлбэл, хүнийг хөгжүүлэх, хөгжлийг хүнд зориулах, хүний өөрсдийнх нь оролцоотойгоор хөгжлийг хангах нь чухал талаар авч үзэв. Энэ зорилгын үүднээс НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго”-ыг албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжүүлж эхэлсэн өнгөрсөн хугацаанд манай улсад хөгжлийн түншүүдээс үзүүлж ирсэн тусламж дэмжлэг нь үндсэндээ хүний хөгжлийг бүх талаар дэмжихэд чиглэж ирсэн болохыг тэмдэглэв.

Япон Улс өндөр хөгжилтэй орны хувьд хөгжиж байгаа орнуудад НҮБ-аас дэвшүүлсэн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад нь бүх талаар хүчин чармайлт гаргаж, туслан дэмжиж ирсэн. Нэг бүс нутгийн, ардчилал, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, эрх зүйт төр хэмээх нийтлэг үнэт зүйлстэй, хамгийн ойрын гуравдагч хөрш, хөгжлийн түнш Япон Улс манай улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд шаардагдах нийгэм, эдийн засгийн суурь нөхцөлийг судалгаа, шинжилгээний үндсэн дээр судлан тогтоож, хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны чиглэлийг эрэмбэ дараатай тогтоож, эдийн засгийн тулгуур болсон ХАА, аж үйлдвэр, аялал жуулчлалын салбарт суурь судалгаа хийж, давын өмнө энэ салбаруудад ажиллах орчин үеийн өндөр техник, технологи ашиглах ур чадвар эзэмшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг дэмжих зэргээр тал бүрээр туслан дэмжиж, хамтран ажиллаж ирсэн талаар танилцуулав. Хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа идэвхжсэн сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд Япон Улс манай улсын нийгэм-эдийн засгийн бүх салбарт олон чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, үнэтэй хувь нэмэр оруулж ирсэн болохыг дараах байдлаар авч үзэв.

- Япон Улсаас манай нийгэм-эдийн засгийн салбарт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийг Техникийн хамтын ажиллагаа, Шинжлэх ухаан технологийн хамтын ажиллагаа, Иений хөнгөлөлттэй зээл, Буцалтгүй тусламж, ЖДҮ эрхлэгчдийн бизнесээ өргөжүүлэхийг дэмжих хамтын ажиллагаа, Өвсний үндэс техникийн хамтын ажиллагаа болон Суурь судалгааны хэлбэрээр тал бүрийн тусламж дэмжлэг тасралтгүй үзүүлсээр ирсэн,



- Монгол, Японы олон талт хөгжлийн түншлэл нь тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай, харилцан хамааралтай эдийн засаг, нийгэм, байгаль орчны салбарын тэнцвэртэй хөгжлийг хангахад төвлөрч ирснээрээ онцлогтой бөгөөд Японы тал үүнийгээ “Монгол Улсын иргэн бүр үр шимийг нь хүртэж чадах эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн” хэмээн тодорхойлсон,
- Хөгжлийн гадаад хүчин зүйлийн дотор томоохон байр эзлэх Япон Улстай манай улс олон талт түншлэлийн хүрээнд 2015 онд Монгол Улсын Засгийн газар Япон Улсын Засгийн газрын хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ) байгуулсан нь хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа эрчимтэй өргөжин хөгжих, байгаль орчинд ээлтэй Японы дэвшилтэд техник технологи манай улсад нэвтрэн технологийн шинэчлэл хийх өргөн боломж нээж өгсөн талаар авч үзэв.

Хоёр орны харилцаанд цаашид анхаарах зүйлсийн талаар авч үзэхдээ:

- ЭЗТХ-ийг тус улстай байгуулж, олонх барааны худалдаанд гаалийн татваргүй орчин бүрдүүлсэн боловч хоёр орны худалдаанд Японы экспорт дийлэнх хувийг эзэлсэн хэвээр байгаа,
- ЭЗТХ байгуулснаас хойш Япон Улсаас Монгол Улстай хийсэн импортын хэмжээ хоёр дахин нэмэгдсэн бол Монгол Улсаас Япон Улс руу хийгдсэн экспортын хэмжээ төдийлөн өсөөгүй 20 сая ам.долларт хүрээгүй хэвээр байгаа бөгөөд Япон Улстай хийж буй худалдааны алдагдал 600 сая ам.долларт хүрсэн нь чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан манай талын хувьд үнэхээр чамлахаар үзүүлэлт болохыг,
- ЭЗТХ-ийн хүрээнд цаашид Японы зах зээлд зориулсан шинэ бүтээгдэхүүн бий болгох, Японы хэрэглэгчдийн чанарын шаардлага, эрэлт нийлүүлэлтийг хангаж, Монголын бараа бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх замаар худалдааг өргөжүүлэх, Японоос үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмж, нарийн мэргэжлийн багаж хэрэгсэл авах, Японы компаниудыг Монголд хөрөнгө оруулахад уриалан ажиллах шаардлагатай гэсэн санааг дэвшүүлсэн байна.

**“Хоёр орны харилцан бие биеэ нөхсөн түншлэл”** хэмээх II бүлэгт (магистр А.Сосорбурам, докторант Б.Саранчимэг нар) манай улсаас Япон Улстай тогтоон хөгжүүлж буй зарим салбарын хамтын ажиллагаа тухайлбал, Японы ажиллах

хүчний бодлого ба энэ салбарт хамтран ажиллаж буй хоёр орны хөгжлийн түншлэлийн талаар танилцуулав. Япон Улс XXI зуун гарсаар ажиллах хүчний хомсдолоо нөхөхийн тулд гадаад ажилчдыг “шинэ ажлын хүч” болгон авах бодлого хэрэгжүүлж эхэлсэн. Цаашид ч тус улс цагаачлалын бодлогодоо томоохон өөрчлөлт оруулах хандлага бий болж байгааг танилцуулаад хоёр улсын хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд олон зуун монгол иргэдийг Япон Улсад дадлагажуулан өндөр технологи, техникийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлж байгаа нь манай орны хөгжилд үзүүлж буй ихээхэн дэмжлэг, тусламж, хамтын ажиллагааны нэгэн үр өгөөжтэй чухал хэлбэр болж буйг тэмдэглэв.

Япон Улсын дэвшилтэт техник, технологийг Монголд нэвтрүүлж нутагшуулах, Японы шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хоёр орны хооронд байгуулсан хөдөлмөрийн салбар дахь хамтын ажиллагааны санамж бичгүүд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд цаашид хамтран ажиллах өргөн боломжийг нээж өгч байна хэмээн дүгнэв.

Мөн Япон Улсын зөөлөн хүчний бодлого Монгол Улсад хэрхэн явагдаж буй талаар танилцуулж, олон улсын харилцааны нөхцөл байдал нарийн төвөгтэй, геополитикийн өрсөлдөөн ширүүсэж буй өнөө үед их гүрнүүдийн зөөлөн хүчний бодлогын үүрэг улам бүр нэмэгдэж, геополитик, гео-эдийн засгийн нөлөөллөө хүчирхэгжүүлэх үр нөлөөтэй арга хэрэгсэл болж байгаа талаар дурдаад ялангуяа хөгжиж буй манай улсад ямар элементээр илэрч, ямар арга замаар хэрхэн хэрэгжиж байгааг судлах нь эерэг ба сөрөг нөлөөллийг тогтооход зайлшгүй судлах чухал сэдэв хэмээн үзэж, Монгол Улсын соёл, боловсролын салбар Японы зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх чухал талбар болж, хоёр улсын соёл боловсрол дахь хамтын ажиллагаа нь хоёр орны харилцааг бэхжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна хэмээн дүгнэв.

**“Эдийн засгийн зарим салбар дахь Монгол, Японы хөгжлийн түншлэл” хэмээх III бүлэгт** (докторант У.Загдцэсэм, доктор (Ph.D) Б.Сэржав, доктор (Sc.D) Ц.Баатар, докторант Б.Саранчимэг нар) Япон Улсын аж үйлдвэрийн соёл түүнээс суралцах талаар, уул уурхай, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбар дахь хоёр орны хөгжлийн түншлэлийн талаар авч үзэв.

Дэлхийд аялал жуулчлалаараа тэргүүлж буй Япон Улсын туршлага ялангуяа эко аялал жуулчлалыг хөгжүүлж буй тэдний туршлагыг бид загвар болгож, туршлага судалж, өөрийн улсад нэвтрүүлэх нь Монгол Улс аялал

жуулчлалын индексээ урагшлуулах боломж болох нь дамжиггүй гэж үзээд тал нутаг бүхий нүүдэлчин уламжлалтай Монгол, орчин үеийн инновацийн гайхалтай хослолыг шингээсэн Японтой аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах арвин их боломжийг ашиглах нь бат бэх харилцаа, соёлын гүн хэлхээ, ард түмний харилцан ойлголцлыг улам гүнзгийрүүлэх, аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгох, “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилтуудыг биелүүлэхэд тус дөхөм болно хэмээн үзэв.

Эдүгээ манай улс аж үйлдвэрлэлийн салбарын бүтцийн зохистой харьцааг богино хугацаанд сэргээж, эдийн засгийг төрөлжүүлэх шаардлагатай тулгарч буй бөгөөд өндөр хөгжилтэй орнуудын туршлагаас суралцах асуудал зүй ёсоор урган гарч, өнгөрсөн хугацаанд Монгол, Япон хоёр орны соёлын харилцааны салбарт шинээр төлөвшиж үр ашгаа өгч байгаа чиг хандлагад аж үйлдвэрийн соёл, компанийн соёл, менежмент зүй ёсоор орж байна. Японы соёлоос суралцахдаа шууд хуулбарлах бус, өөрийн орны түүх соёл, зан заншил, уламжлал, өөрийн үнэт зүйл, онцлогийг харгалзан үзсэний үндсэн дээр нутагшуулан авч ашиглах, Азийн бусад улс орнуудад нэвтрүүлж хөгжилд хүрсэн туршлагыг ч хамтад нь авч үзэх шаардлагатай гэсэн санал дэвшүүлэв.

Японы ЖАЙКА байгууллага манай улсын малын гаралтай түүхий эдэд эцсийн боловсруулалт хийх үйлдвэр хөгжүүлэх зэрэг асуудлыг цогц байдлаар судлах суурь судалгааны олон төсөл хөтөлбөрийг хоёр талын эрдэмтэн судлаачид, энэ чиглэлийн ажил мэргэжлийн хүмүүстэй хамтран хэрэгжүүлж, туршилт, судалгаа хийж, энэ салбарт Японы өндөр техник, технологийг нутагшуулах чиглэлээр тал бүрийн хүчин чармайлт тавьж байгаа нь “Алсын хараа 2050”-ын хүрээнд хөдөө аж ахуйн салбарыг судалгаанд суурилж, шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэхэд ихээхэн чухал ач холбогдолтой, үнэ цэнтэй судалгаанууд болсныг дурдав.

Монгол Улс сэргээгдэх эрчим хүч нийлүүлэгч орон болж, дэлхийн хөгжил, хүн төрөлхтний эрүүл амьдралын хэв маягт хувь нэмрээ оруулах боломжтой гэж Японы хөрөнгө оруулагчид үзэж хамтран ажиллах сонирхолтой байгааг дурдаад, уул уурхайн салбарыг хөгжүүлэх үндсэн суурь бэлтгэл болох тээвэр логистик, мэдээлэл технологийн дэд бүтцийг хөгжүүлэхгүйгээр энэ салбарт шууд хөрөнгө оруулах нь эрсдэлтэй гэж тэд үзэж байгааг тэмдэглэв.

Япон Улсын хөгжлийн хамтын ажиллагаа, аливаа төсөл хөтөлбөр бүр судалгаанд суурилсан, чанарт анхаардаг, нийгмийн хэрэгцээг мэдэрсэн байдаг онцлогтойг цохон тэмдэглээд ил харагдаж байгаа хөгжлийн төсөл хөтөлбөрөөс гадна нүдэнд үзэгдэхгүй ч ирээдүйд асар их баялаг болох оюуны хөрөнгө оруулалтыг харамгүй хийсээр буйг энд дурдав. Тухайлбал, техникийн хамтын ажиллагааны хүрээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах, 1000 инженер бэлтгэх төсөл зэрэг нь манай улсын аж үйлдвэрийн суурь нөхцөлийг бүрдүүлж аль болох богино хугацаанд эдийн засгийн тусгаар тогтнолоо олоход нэгэн чухал хүчин зүйл болох хүний хөгжлийг дэмжих явдал бөгөөд үүгээрээ бусад хөрөнгө оруулагчдаас ялгарах онцлогтой, хөгжлийн урьдач суурь нөхцөлийг хангахад чиглэж байна хэмээн дүгнэв.

Монгол, Японы харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн ололт амжилтын суурь нь улс төрийн харилцан итгэлцсэн, найрсаг харилцаанд тулгуурлан эрчимтэй өрнөн хөгжиж, манай улсын тогтвортой хөгжлийн зорилтоо хэрэгжүүлэхэд томоохон хүчин зүйл болж байна. Түүнчлэн Монгол Улсын ардчилал, эдийн засгийн шинэчлэлтийг хоёр талын харилцааны болон олон улсын тавцанд эхнээс нь тууштай дэмжиж, манай улсын эдийн засгийн төрөлжилт, тогтвортой хөгжлийн төлөө идэвхтэй хамтран ажиллаж ирсэн бүс нутгийн чухал түнш Япон Улстай хэрэгжүүлж буй хөгжлийн төлөө түншлэл нь манай улсын урт хугацааны хөгжлийн зорилтоо хангахад эерэг нөлөө үзүүлэх гадаад хүчин зүйлүүдийн дотор томоохон байр суурь эзэлж, хоёр орны олон талт хөгжлийн түншлэл нь эдүгээ манай нийгэм, эдийн засгийн бүх салбарт өрнөн хөгжиж, хоёр орны харилцаа Азийн бүс нутгийн нэгэн жишиг түншлэлийн харилцаа болж тэлэн өргөжсөөр байна хэмээн дүгнэв.

**2. Академич Ц.Батбаяр “Монгол ба Япон XX-XXI зуунд: “Гуравдагч хөрш”-ийн харилцааны түүх”, “Бэмби сан” хэвлэлийн компани, УБ., 2022 он, 27.3 х.х., Редактор доктор (Ph.D) Б.Сэржав. Энэхүү нэгэн сэдэвт зохиолд Богд хаант Монгол Улс Японтой харилцан гуравдахь хөршөө болгох гэсэн хүсэл эрмэлзэл, бодит алхамууд, Япон Азийн эх газрын бодлогынхоо хүрээнд “Гадаад Монгол”, цаашилбал БНМАУ-ыг сонирхох болсон, 1930-аад онд БНМАУ, Манжгогийн хооронд болсон шууд яриа хэлэлцээ, Халхын голын дайныг тойрсон цэрэг-дипломатын зөрчил, Зөвлөлт-Японы хооронд 1941 онд байгуулсан төвийг сахих гэрээнд БНМАУ-ын статусыг хэрхэн хөндсөн, БНМАУ 1945 онд Японд дайн зарласан зэрэг XX зууны эхэн хагасын түүхийн ээдрээтэй олон асуудлын учир**

шалтгаан, тайлалыг Зүүн Азийн олон улсын харилцааны өргөн дэвсгэр дээр гаргасан байна. Түүнчлэн дэлхийн II дайны дараа Монгол ба Япон хэрхэн бие биеэ шинээр нээсэн, 1972 онд албан ёсоор дипломат харилцаа тогтоохын тулд “хүйтэн дайн”-ы ямар бэрхшээл сорилтыг хоёр талаас туулсан, дипломат харилцаа тогтоосны дараа ч харилцаа хязгаарлагдмал орчинд байсныг, 1990 оноос Монголд эхэлсэн ардчилсан өөрчлөлтийн үр дүнд хоёр орны харилцаанд зарчмын цоо шинэ үе эхэлж, сүүлийн 30 жилд хоёр орны харилцаа “иж бүрэн түншлэл”-ээс “стратегийн түншлэл”-д дэвшсэнийг академич, япон судлаач Ц.Батбаяр Монгол, Японы архивын баримт сэлт, судалгааны хэрэглэгдэхүүн, хувийн баялаг архивдаа түшиглэн задлан шинжилж, шинэ шинэ гаргалгаанууд хийсэн байна.

Дэлхийн II дайны дараагаас өнөөг хүртэлх Монгол-Японы харилцааг зохиогч нийт таван дэд үед хуваан авч үзсэн юм. Эхний үе нь дайны дараах хоёр орон бие биеэ цоо шинээр танин мэдэх, түүхээс үлдсэн ээдрээтэй хэдэн асуудлын шийдлийг олох гэсэн үе байв. Монгол-Японы хооронд дипломат харилцаа тогтоох үйл явц 1970-аад оны эхэн хүртэл сунжирсан явдал нь дайны төлбөр, Монголд байсан Японы олзны цэргүүдийн асуудал зэрэг маргаантай хэд хэдэн асуудлаас үүдэлтэй. Эдгээр асуудал нь 1946 оноос эхлэн тавигдсан бөгөөд хоёр тал тодорхой шийдлийг олтол олон жил болсон юм. 1960 он орчмоос 1972 он хүртэлх хоёр орны хооронд хэвийн, дипломат харилцаа тогтоосон улс төрийн түүх нь хоёр орны дотоод улс төрийн байдлаас гадна тухайн “хүйтэн дайн”-ны үеийн олон улсын байдал, Тайваны хүчин зүйл, АНУ-ын байр суурь, Япон-Зөвлөлт, Япон Хятадын харилцаанаас хамаарч байв. Монгол, Япон хоёр орон нь 1972 оны 2 дугаар сард албан ёсны дипломат харилцаа тогтоосноор ХХ зуунд анх удаа олон улсын жишгээр бие биеийг хүлээн зөвшөөрч, бүрэн эрхт тусгаар тогтносон улсуудын хувьд улс төр, эдийн засаг, соёл боловсрол зэрэг бүхий л салбарт харилцааг хөгжүүлэх нэн таатай нөхцөлийг бүрдүүлсэн хэмээн үзжээ. Гуравдахь дэд үе нь дипломат харилцаа тогтоосноос хойших 20-иод жилийн харилцаа болно. Хэдийгээр хоёр орон олон салбарт харилцааг эрчимтэй хөгжүүлэх хүсэл эрмэлзэл байсан боловч Зөвлөлт-Японы харилцааны хүчин зүйлээс хамаарч харилцааны эрх зүйн үндсийг тавих, эдийн засгийн хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлэх, соёл боловсролын хэлхээ холбоог хязгаарлагдмал орчинд хөгжүүлэхээс өөр аргагүй байв. 1980-90 оны заагаас Монголын нийгэмд гарч байсан дотоод гадаад өөрчлөлтүүд Монгол Улсын гадаад

бодлогод, түүн дотор Японтой харилцах хоёр талын харилцаанд ч эрс дорвитой өөрчлөлтүүд авчирч, Япон Улс Монголын ардчилсан, зах зээлийн өөрчлөлтийг анхнаас нь тууштай дэмжиж, шилжилтийн үеийн бэрхшээл сорилтуудыг даван туулах, ардчилал, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйт төрийг байгуулах үйлсэд “Монголыг дэмжих бүлэг”-ийг удирдан зохион байгуулж, томоохон хандивлагч орны үүргийг гүйцэтгэсэн хэмээн дүгнэв. 1996 оноос хоёр орон харилцан ойлголцож, харилцан итгэмжилсэн улс төрийн харилцаа; тэгш эрх, харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа; соёл боловсрол, шинжлэх ухаан, технологи, хүмүүнлэгийн өргөн хүрээтэй хамтын ажиллагаа; улс төрийн яриа хэлэлцээг идэвхжүүлэх, батлан хамгаалах, аюулгүй байдлын асуудлаар зөвлөлдөх, олон улсын талбарт, түүний дотор олон улсын байгууллагад хамтран ажиллах гэсэн дөрвөн үндсэн чиглэлээр “Иж бүрэн түншлэлийн харилцаа”-г өргөжүүлэхээр тохиролцож, XXI зуун гарсаар хоёр орны харилцаа дээд, өндөр түвшний яриа хэлэлцээний давтамж нэмэгдэж, агуулга өргөжиж, 1997 оноос хойш Япон Улстай хөгжүүлсэн “Иж бүрэн түншлэлийн харилцаа”-г шат ахиулж, “Стратегийн түншлэл”-ийн түвшинд хөгжүүлэхээр 2010 онд тохиролцсон нь түүхэн чухал алхам болсон юм хэмээн хоёр орны харилцааны энэ үеийг дүгнэсэн байна.

**3. Тус төслийн хэрэгжилтийн үр дүнд дотоод, гадаадын хэвлэлд 18 удаа судалгааны өгүүлэл (нийт 17.0 х.х. гаруй) нийтлүүлж, олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хуралд 11 илтгэл тавьж хэлэлцүүлэв. Мөн өнгөрсөн 3 жилийн хугацаанд төслийн гүйцэтгэгч нар Олон улс судлалын хүрээлэн дээр сэдэвт ажлын хүрээнд 7 удаа семинар зохион байгуулж 12 илтгэл хэлэлцүүлсэн. Эдгээр өгүүлэл, илтгэлд:**

- Япон Улсад хэрэгжүүлж ирсэн эдийн засаг, нийгмийн хөгжил болон хүрээлэн буй орчны тэнцвэртэй байдлыг хадгалсан хөгжлийн бодлогын түүх, өнөөгийн чиг хандлага хийгээд манай улсад авч ашиглаж болох туршлагын талаар,
- Монгол, Японы харилцаа, хамтын ажиллагааны түүх, өнөөгийн байдал, чиг хандлагын талаар болон манай улсын ногоон хөгжлийн стратеги зорилгыг хэрэгжүүлэхэд Япон Улстай тогтоон хөгжүүлж буй хамтын ажиллагааны хүчин зүйлсийг ашиглах боломжийн талаар,

- Япон Улсын гадаад, дотоод бодлого болон бүс нутгийн зарим асуудлын талаар хөндөн авч үзсэн болно. (Судалгааны өгүүлэл, илтгэлийн нэрсийг Хавсралтад жагсаав.)

#### **4. Зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал 3 удаа, семинар 7 удаа**

- **“Монгол, Японы хоорондын боловсрол, соёл урлаг, эдийн засаг, спортын салбар дахь 50 жилийн хамтын ажиллагааг эргэцүүлэх нь”** Улаанбаатар, 2022.09.03 олон улсын эрдэм шинжилгээний хурал.

Соёл эрдэм дээд сургууль, Токиогийн гадаад судлалын их сургуулийн Ази, Африкийн хэл соёл судлалын хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан энэ хуралд монгол, японы 30-аад эрдэмтэд судлаачид илтгэл тавьж, хэлэлцүүлэг явуулсан. Хурлыг зохион байгуулсан 2022 онд Монгол, Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиосон бөгөөд энэхүү тэмдэглэлт ойн жилд хоёр улс, боловсрол, соёл урлаг, эдийн засаг, спортын салбаруудын хооронд олон жилийн хамтын ажиллагаа өрнөснийг эргэцүүлэн бодож, алдаа оноо, амжилт ололтоо дүгнэн ярилцахад тус хурал чиглэгдсэн юм. Энэ хуралд Япон Улсын Токиогийн гадаад судлалын их сургуулийн Ази, Африкийн хэл, соёл судлалын хүрээлэн, Эм судлалын их сургууль, Токиогийн их сургуулийн профессорууд болон Монголын эрдэмтэд, судлаачид оролцсоны дотор тус сэдэвт ажлын гүйцэтгэгч, доктор (Ph.D) Б.Сэржав “Монгол, Японы харилцааны хөгжилд энх тайвны хөдөлгөөний гүйцэтгэсэн үүрэг”, докторант У.Загдцэсэм “Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх шаардлага, Япон Улсын аж үйлдвэрийн соёлоос суралцах нь”, магистр А.Сосорбурам “Монгол, Японы худалдааны өнөөгийн байдал: Харилцан нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний бүтцийн жишээгээр” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлэв.

- **“Олон улс судлал-2022: Монголын япон судлал”** Улаанбаатар, 2022.12.23 эрдэм шинжилгээний хурал. Тус хуралд ШУА, МУИС, Хүмүүнлэгийн их сургууль, Монголын ЗХА-ийн аюулгүй байдал, стратегийн хүрээлэн, Батлан хамгаалах их сургууль зэрэг манай улс дахь япон судлалаар судалгаа шинжилгээ эрхэлдэг байгууллагуудын төлөөлөл оролцож, Монгол дахь япон судлалын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар нийт 11 илтгэл хэлэлцүүлж, санал бодлоо солилцсон юм. Энэхүү хуралд

доктор (Ph.D) Б.Сэржав, докторант У.Загдцэсэм нар “Олон улс судлалын хүрээлэнгийн Япон судлалын судалгааны чиглэл: Уламжлал, шинэчлэл” сэдэвт илтгэлийг хэлэлцүүлэв.

- “**Монгол-Японы боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны харилцаа, хамтын ажиллагаа**” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг (Улаанбаатар, 2023.05.27) Монголын Япон Судлалын Нийгэмлэг, Япон Улсад докторын зэрэг хамгаалсан монгол эрдэмтдийн Хакасэкай Холбоо, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн хамтран зохион байгуулж, мал эмнэлэг, физик, сансрын технологи, анагаах ухаан, түүх, боловсрол, олон улсын харилцаа болон археологийн салбар дахь Монгол, Японы хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжиж буй сүүлийн үеийн судалгаа, дадлага туршлагын талаар 9 эрдэмтэн судлаачид илтгэл тавьж хэлэлцүүлсэн бөгөөд төслийн гүйцэтгэгч, докторант У.Загдцэсэм “Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд Япон Улсын хүчин зүйл: Улс төр, олон улсын тавцан дахь хамтын ажиллагааны жишээн дээр”, докторант Б.Саранчимэг “Японы аюулгүй байдлын бодлого: Уламжлал, шинэчлэл” сэдэвт илтгэлийг тус тус хэлэлцүүлэв.

- Монгол, Японы харилцаа, хөгжлийн түншлэл, Япон Улсын гадаад дотоод бодлого, туршлага сэдвээр **эрдэм шинжилгээний семинар 7 удаа, нийт 12 илтгэл** (1.“Япон Улсын гаднаас ажиллах хүч авах бодлогын өөрчлөлт ба Монгол Улс” 2021.04.21, 1 илтгэл, 2. “Монгол, Японы зарим салбарын хамтын ажиллагаа” 2022.05.11, 2 илтгэл, 3. “Япон Улсын гадаад бодлого” 2022.05.18, 1 илтгэл, 4. “Монгол Улс, Япон Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хэрэгжилт” 2022.12.07, 1 илтгэл, 5. “Монгол-Японы худалдааны өнөөгийн байдал” 2023.04.26, 1 илтгэл, 6. “Монгол-Японы улс төр, аюулгүй байдлын салбарын өнөөгийн байдал” 2023.05.24, 1 илтгэл, 7. “Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Монгол, Японы олон талт хөгжлийн түншлэл” 2023.12.11, 5 илтгэл) зохион байгуулж, төслийн судалгааны үр дүнгээс хэлэлцүүлж, эрдэмтдийн саналыг тусгав.

**5. Төслийн судалгааны хугацаанд дараах эмхэтгэлийг нийтлүүлж, уншигчдын хүртээл болгов.**

1. “**Монгол Японы харилцаа: Он дарааллын товчоон (1972-2022)**”, “Бэмби сан” хэвлэлийн компани, УБ., 2022 он, 56.5 х.х., Редактор Л.Хайсандай, Д.Золбоо, Р.Төрдалай, хэвлэлд бэлтгэсэн У.Загдцэсэм. Монгол Улс, Япон Улсын



хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан тус бүтээлд БНМАУ, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосон 1972 оны 2 дугаар сарын 24-ний өдрөөс 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд өрнөсөн хоёр улсын улс төр, эдийн засаг, гадаад харилцаа, батлан хамгаалах, боловсрол, шинжлэх ухаан, соёл, спорт, хүмүүнлэг зэрэг салбарын гол үйл явдлыг он цагийн дарааллын дагуу хамруулан авч үзэж, хагас зууны туршид Монгол, Японы харилцаа, хамтын ажиллагааны салбарт хоёр орны харилцааг хөгжүүлэх үйлсэд хүч бололцоогоо дайчлан идэвх зүтгэлтэй ажиллаж, өнөөгийн түвшинд хүргэсэн үе үеийн төр засгийн тэргүүн нар, дипломатчид, хоёр орны найрамдлын нийгэмлэгийн төлөөлөгчид, эрдэмтэд, ард иргэдийн олон талт эгэл жирийн хийгээд түүхэн үйл хэргийг он дарааллаар товчоолон гаргаж, үүгээрээ энэ салбарт тогтоон хөгжүүлж буй найрамдалт харилцааны түүхийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд томоохон хувь нэмэр оруулж чадахуйц анхны цогц эмхэтгэл болсон.

Тус эмхэтгэлийг Монгол Улсын Үндэсний төв архив, Гадаад харилцааны төв архив дахь эх сурвалжууд, Үндэсний төв номын сан, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн баримт хэрэглэгдэхүүн болон урьд өмнө нийтлэгдсэн судалгааны бүтээлүүд, эрдэм шинжилгээний сэтгүүл, тогтмол хэвлэл, япон, англи, орос, бусад хэлээрх цахим хуудас, мэдээллийн бусад сурвалжид тулгуурлан туурвисан. Энэхүү товчоон нь хоёр орны харилцааны түүх, орчин үеийн чиг хандлага, Монгол Улсын түүх, гадаад харилцаа судлаач, улс төр, дипломат, эрдэмтэн багш, оюутан, сонирхогчдын эрэлт хэрэгцээнд нийцэж, мэдлэгийн хүрээг нь тэлэхэд өгөөжтэй бүтээл болсон гэж үзнэ. “Монгол Японы харилцаа: Он дарааллын товчоон (1972-2022)” номыг бүтээх ажлыг: 197-1983 он Б.Сэржав (доктор (Ph.D), дэд профессор, төслийн удирдагч), 1984-1996 он У.Загдцэсэм (докторант, төслийн гүйцэтгэгч), 1997-2008 он А.Сосорбурам (магистр, төслийн гүйцэтгэгч), 2009-2022 он М.Болормаа (докторант, төслийн гүйцэтгэгч) нар хариуцан гүйцэтгэв.

2. **“Монгол Японы харилцаа: Баримт бичгүүд (1972-2022)”**, “Соёмбо принтинг” хэвлэлийн компани, УБ., 2022 он, 58.0 х.х., Редактор Л.Хайсандай, Ц.Батбаяр, Д.Золбоо, Р.Төрдалай, хэвлэлд бэлтгэсэн У.Загдцэсэм. Монгол Японы харилцааны түүхийн судалгааны салбарт анх удаа нийтлэгдсэн энэхүү баримт бичгийн эмхэтгэл нь хоёр орны хагас зуун жилийн харилцааны хөгжил дэвшлийг илэрхийлсэн баялаг түүхэн үйл явдлуудыг гэрчлэх албан ёсны баримт

бичгүүд, тухайлан хоёр улсын үе үеийн Ерөнхийлөгч, Засгийн газар, Ерөнхий сайд нарын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээр, төрийн дээд хэмжээний айлчлалуудын албан мэдээ, хамтарсан мэдэгдэл, Япон Улсын Засгийн газраас удаа дараа үзүүлсэн зээл тусламж, томоохон бүтээн байгуулалттай холбоотой баримт бичгүүд, салбарын яам, газруудын хамтын ажиллагааны баримт бичиг зэрэг нийт 280 гаруй баримтыг он цагийн дарааллын дагуу байрлуулж нийтэлсэн. Тус эмхэтгэлийг бүтээхэд Монгол Улсын Үндэсний төв архив, Гадаад харилцааны төв архивын эх сурвалжууд, Үндэсний төв номын сан, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн судалгааны баримт хэрэглэгдэхүүн, цахим хуудас, мэдээллийн бусад эх сурвалжид тулгуурлав. Баримт бичиг хэвлэн нийтлэх зарчмын дагуу баримт бичгийг ихэвчлэн бүрэн эхээр нь сонгон авч, архивын баримтын баталгаат хуулбарын хувийг голлон оруулсан. Мөн зарим баримт бичгийн эмхэтгэлийн агуулгад холбогдолгүй хэсгийг нь хасч товчлох, эмхэтгэгчдийн зүгээс тухайн баримтын утга агуулга, нэр төрлийг тодорхойлсон гарчиг үйлдэж нийтлэх аргыг ашиглав. Ихэнх баримт бичгийн хувьд баримтын гарчгаар нь оруулсан. Түүнчлэн баримт бичиг болгоны ард архивын нэр, хөмрөг, данс, хадгаламжийн нэгж, хуудасны дугаарыг бичиж оруулахын зэрэгцээ, сүүлийн үеийн баримт бичгүүдэд уг баримтыг нийтэлсэн тогтмол хэвлэл, цахим хуудас, мэдээллийн бусад эх сурвалжийг тодорхой зааж өгөх талаар анхаарч ажилласан.

“Монгол Японы харилцаа: Баримт бичгүүд 1972-2022” эмхэтгэлд хамрагдсан эдгээр баримт бичгүүд нь дурдан буй үеийн хоёр орны харилцааны хөгжлийн түүх, өнөөгийн байдал хийгээд цаашдын чиг хандлагын талаарх судалгааны чухал эх сурвалж мөн бөгөөд манай улсын гадаад харилцааны түүх, бодлого, хэрэгжилтийн талаар судалгаа шинжилгээний ажил хийх эрдэмтэд судлаачид, оюутан залуус, тус сэдвийг сонирхогч хэн бүхний хэрэгцээ шаардлагыг байнга хангаж байх үнэт чухал хэрэглэгдэхүүн мөн гэдгийг энд цохон тэмдэглэе.

“Монгол Японы харилцаа: Баримт бичгүүд 1972-2020” эмхэтгэл нь ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн “Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Япон Улстай тогтоон хөгжүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагааны үүрэг (2021-2023)” сэдэвт төслийн судалгааны хүрээнд гүйцэтгэсэн ажлын нэг юм. Тус эмхэтгэлийг бүтээхэд 1972-1983 он Б.Сэржав (төслийн удирдагч, доктор (Ph.D), дэд профессор), 1984-1996 он У.Загдцэсэм (төслийн оролцогч, докторант),

1997-2008 он А.Сосорбурам (төслийн гүйцэтгэгч, магистр), 2009-2022 он М.Болормаа (төслийн гүйцэтгэгч, магистр) нар хариуцан ажиллав.

3. **“Олон улс судлал-2022: Монголын япон судлал”** эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. “Соёмбо принтинг” хэвлэлийн компани, УБ., 2023 он, 13.0 х.х., Редактор Р.Төрдалай, Ш.Догмийчойдон, эмхэтгэсэн Б.Саранчимэг. Тус эмхэтгэлд 2022 оны 12 дугаар сард зохион байгуулсан “Олон улс судлал-2022: Монголын япон судлал” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд Япон Улсын улс төр, аюулгүй байдал, гадаад бодлого, эдийн засаг, аж үйлдвэрийн соёл, гамшгийг даван туулах чадамж, дээд боловсролын онцлог шашин, гүн ухаан, тус улсын зөөлөн хүчний бодлого түүний Монгол дахь нөлөө мөн хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, хоёр орны худалдааны өнөөгийн байдал, Олон улс судлалын хүрээлэнгийн Япон судлалын судалгааны чиглэл зэрэг сэдвээр манай улсад Япон судлалаар судалгаа явуулдаг голлох байгууллагууд болох ШУА, МУИС-ийн Ази судлалын тэнхим, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургууль, Монголын Зүүн Хойд Азийн аюулгүй байдал, стратегийн хүрээлэн, Зэвсэгт хүчний 311-р ангийн удирдлага, япон судлалын чиглэлээр дагнан судалгаа хийдэг эрдэмтэд судлаачдын хэлэлцүүлсэн илтгэл өгүүллийн хэлбэрээр нийтлэгдэж, Монголын Япон орон судлалын нэгэн үеийн хөгжлийн түвшинг илтгэн харуулахуйц бүтээлүүд багтсан болохыг онцолж байна. Тухайлбал, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, манай улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд Япон Улстай тогтоон хөгжүүлж буй хамтын ажиллагааны шинэ нөөц боломжийг олж ашиглах, тухайлан Японы дээд боловсрол, аж үйлдвэрийн соёл, гамшгийн менежментээс хэрхэн суралцах талаарх асуудлыг хөндөн, байр сууриа илэрхийлж, шинэлэг санаа дэвшүүлсэн өгүүллүүд нийтлэгдсэн.

## 6. **Бодлогын зөвлөмж 2 удаа**

1. УИХ-ын ажлын алба, Боловсрол, Шинжлэх ухааны яаманд (“Бага, дунд сургуулийн Ёс зүйн хичээлийн Сургалтын хөтөлбөрийг сайжруулахад туслах зорилгоор **“Японы бага сургуульд ёс зүйн боловсрол олгож буй туршлагаас”** сэдвээр Бодлогын зөвлөмж (0,9 х.х.), 2021.03 сард)

Тус хүрээлэн дээр хийгдэж ирсэн япон орон судлалын судалгаанд үндэслэн Япон Улсад урт удаан хугацааны турш тогтвортой хэрэгжиж, эдийн засаг, нийгмийн үсрэнгүй хөгжлийг бүтээн байгуулагч хүч - япон иргэдийг сурган

хүмүүжүүлж, төлөвшүүлж ирсэн боловсролын тогтолцоон дундаас Ёс зүйн сургалтын туршлагын зарим хэсгийг сонгон товч танилцуулав.

Манай улсад боловсролын тогтолцооны шинэчлэл хэрэгжүүлэх, сургалтын хөтөлбөр, агуулгыг улам боловсронгуй болгох, ёс зүйтэй, бүтээлч ажилсаг залуу үеийг өсгөн хүмүүжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд, өнөөгийн нөхцөлд Япон Улсын боловсролын бодлого, Ёс зүйн сургалтын агуулга, арга туршлагыг судлах, авах гээхийн ухаанаар хандаж, түүнээс суралцах нь ач холбогдолтой байх болно гэдэг үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Япон Улсын боловсролын бодлогод түүний дотор бага, дунд боловсролын бодлогод хүүхдэд мэдлэг олгох, зөв хүн болгон төлөвшүүлэх хоёр асуудал эн тэнцүү тавигдаж хэрэгждэг туршлагыг сайтар судлан, өнөөгийн нөхцөлд манай улсад авч хэрэглэж болохоор зохистой туршлагаас оновчтой сонгон авч хэрэгжүүлбэл манай хүүхэд залууст ёс суртахууны зөв төлөвшил олгоход үр дүнгээ өгнө хэмээн үзэв.
- Японд нийгмийн гишүүн хувь хүнийг өсгөн төлөвшүүлэх үндэс суурийг ёс зүйн хичээлээр олгохоор бүх ангид цаг тогтоодог. Энэ хичээлийг орчин үеийн боловсролын тогтолцоо үүссэн тэр цагаас, өөрөөр хэлбэл 140 гаруй жилийн турш тогтвортой байлгах бодлого барьж, гэр бүл, сургууль, нийгмийн орчинг нэгдмэл байдлаар тусгаж, эцэг эх, сургууль, орон нутгийн холбоог чухалчлан авч үзэж иржээ. Ингэхдээ хүүхдийг сургуулийн орчинд орсон цагаас нь 1. өөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалдаа анхаардаг, эрүүл саруул иргэн байхын чухлыг ойлгуулж, нягт нямбай, ажилсаг, шулуун шударга, хүсэл тэмүүлэлтэй, нээлттэй зан чанарыг эрхэмлэн үздэг болгохын зэрэгцээ, 2. Бусадтай хэрхэн харьцах, 3. Байгаль дэлхий, ариун дагшин зүйлтэй хэрхэн харьцах, 4. Хамт олон, нийгэмтэй хэрхэн харьцах гэх мэтээр хувь хүн, байгаль, нийгмийн амьдралын бүхий л хүрээг орхигдуулалгүй авч үзэж, ёс суртахууны ойлголтыг энгийнээс улам өргөн хүрээнд гүнзгий рүү шилжүүлж, цогц байдлаар эзэмшүүлэх бодлогыг хэрэгжүүлдэг аж. Хичээлийн хөтөлбөр боловсруулахаас эхлээд заах аргын талаар, хичээлийн хэлбэр, сургалтын материал, бусад хичээлүүдтэй холбогдох уялдаа холбоо, эцэг эх, орон нутгийн хүчин зүйл, хамтын ажиллагаа, тусламж дэмжлэгийг авах зэрэг сургалтын хөтөлбөр тусгай зүйлээр нарийвчлан зааж өгдөг аж. Түүнчлэн эх орныхоо соёл, уламжлалд элэгсэг дотно хандах, эх орноо

хайрлахын чухлыг, мөн орчин үеийн дэлхий дахины хөгжлийн чиг хандлагад зохицон гадаад хүн, гадаадын соёл, дэлхий дахины олон янз байдлыг сонирхох, хүндэтгэлтэй хандаж сурах асуудлыг Ёс зүйн хичээлээр хамруулан үзэж байгаа зэрэг нь ч манай улсын бага, дунд сургуулийн Ёс зүйн хичээлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажилд тусган авч ашиглавал үр дүнгээ өгөх болов уу.

- Ёс зүйн сургалтын үйл ажиллагаанд гэр бүл, сургууль, нийгмийн хөгжлийн хандлагын талаарх нарийн судалгааг иш үндэс болгодог, өөрөөр хэлбэл улс орны хөгжлийн стратеги, цаашдын төлөв байдлыг нухацтай харгалзан, тусгаж хэрэгжүүлдэг юм байна. Бага, дунд, ахлах сургууль дахь сургалтын энэ үйл ажиллагаа нь дараагийн шатны сургуулиар дамжин, улмаар жижиг дунд, том үйлдвэр компани дахь хөдөлмөр зохион байгуулалт, бүх төрлийн хууль журам, япон маягийн менежмент, энэ бүхэнтэй уялдан холбогдож, улс орны нийгэм соёлын бүтээн байгуулалтад очиж үр дүнгээ өгдөг бүхэл цикль маш нарийн тогтолцоот үйл ажиллагаа гэдэг нь ойлгомжтой. Чухам ийм бүхэл бүтэн циклийн гол асуудлыг бага дунд сургууль дээр хэрхэн уялдуулан авч үздэг туршлага нь өнөөгийн манай нөхцөлд судлан үзэж, авч ашиглах ёстой асуудал мөн гэж үзэв.

2. УИХ-ын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн, Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн ажлын алба, Эдийн засаг, хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газарт (**“Япон Улсын ногоон хөгжлийн бодлого, туршлага, сургамж”** сэдвээр Бодлогын зөвлөмж (0,9 х.х.), 2023.12 сард) Манай улсын хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлэхэд тусган авч хэрэглэж болох туршлагын талаар тодорхой саналыг дэвшүүлэхийг зорьж Япон Улсад эдийн засаг, нийгмийн хөгжлийг байгаль орчны тогтвортой байдалтай тэнцвэртэй авч үзэж ирсэн туршлагыг эдийн засгийн хөгжлийн үе шатуудад хэрэгжүүлсэн аж үйлдвэржүүлэх бодлого болон бүс нутгийн хөгжлийн бодлого, хот төлөвлөлт, ногоон инновацийн чиг хандлага, хог хаягдлын менежмент, байгаль экологийн боловсролын бодлогын талаар товч танилцуулав.

Япон Улсын хурдацтай хөгжлийн туршлагыг судлан оновчтой туршлагыг өөрийн орны онцлогт тохируулан, судалгаанд үндэслэн урт, дунд хугацааны

хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх явцад нутагшуулан авч ашиглах нь хөгжилд түлхэц үзүүлэх чухал хүчин зүйл байх нь маргаангүй. Энэ үүднээс Япон Улсад эдийн засаг, нийгмийн урт, дунд хугацааны хөгжлийг чиглүүлэн удирдаж ирсэн бодлого, төлөвлөлт, төрийн зохицуулалт болон байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийн олон үзүүлэлтээр дэлхийд тэргүүлэх орны эгнээнд хүрсэн туршлага, сургамж нь манай улсын хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой хүчин зүйлийн нэг хэмээн үзэж байна.

Япон Улсад төрийн бодлогын залгамж шинж, нэгдмэл цогц байх зарчим чанд үйлчилдэг, бодлого боловсруулах, төлөвлөх үйл явцыг цаг хугацааны дэс дараалалтай, экологийн хүчин зүйлтэй нягт уялдуулан удирдан зохион байгуулдаг, түүнийг нийгмийн бүхий л салбарт нарийн эмх цэгцтэй, үе шаттайгаар хэрэгжүүлдэг, нэгэнт тогтоосон хууль, журмыг иргэд нь аж амьдралдаа тууштай мөрдөн хэвшүүлдэг зэрэг туршлага тодруулан хэлбэл, орчин үеийн нийгэмд ногоон хөгжил хэмээн томъёолж буй эдийн засаг, нийгэм, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангасан, хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийг хөгжүүлсэн туршлагыг бид бодлого, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнтэй холбоотой дараах хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

*Хөгжлийн бодлогын тухайд:*

- Хөгжлийн талаар тууштай залгамж шинжтэй төрийн бодлого хэрэгжүүлэх,
- Тодорхой салбарыг төрийн бодлогоор дэмжин тухайн салбарын бараа бүтээгдэхүүнийг экспортын стандарт шаардлага хангахуйц болтол өсгөн хөгжүүлэх,

*Бүс нутгийг хөгжүүлэх бодлого, хот төлөвлөлтийн тухайд:*

- Хүн амын нутагшилт суурьшлын ерөнхий төлөвлөлтөнд бүс нутгийн онцлог, хүн ам, дэд бүтэц, эрдэс баялаг, хөрш орны хил орчмын бүс нутгийн хөгжлийн онцлог зэрэг хүчин зүйлүүдийг тооцсон, үр ашигтай үйлдвэр байгуулах замаар ажлын байрыг бий болгож, нийслэлийн хүн амын нягтралыг сааруулах бодлогыг хэрэгжүүлж, тухайн бүс нутгийн онцлог бүхий хөгжлийг дэмжин дэд хотуудыг хөгжүүлэх,
- Бүс нутгийн дэд бүтцийг хөгжүүлэхдээ алслагдсан бүс хөрш орны хил орчмын дэд бүтэцтэй хэрхэн уялдаж, хөгжих боломж нөхцөлийг судалгааны үндэслэлтэй тодорхойлох,

- Бүс нутгийн хүн амын нийгмийн хэрэгцээг бүрэн хангахуйц дэд бүтцийг бүтээн байгуулахын хамт чанартай төрийн үйлчилгээг үзүүлснээр хот хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах,

*Хог хаягдлын менежментийн тухайд:*

- Уул уурхай, үйлдвэрийн гаралтай химийн хортой бодисын ашиглалт хэрэглээнд төрөөс хатуу хяналтыг цаг алдалгүй тавьж мөрдүүлэх,

- Импортоор орж ирж буй бараа бүтээгдэхүүн болон дотоодод үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүний байгаль орчинд үзүүлэх эерэг сөрөг байдалд үнэлгээ хийж, дахин боловсруулж болдог эсэхэд анхаарах, байгальд хоргүй задардаг эсэхэд хяналт тавих,

- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь нэн яаралтай ангилж, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах,

*Байгаль, экологийн боловсролын тухайд:*

- Залуу, хойч үеийн байгаль экологийн боловсролд анхаарч, цэцэрлэг, сургуулийн хичээлийн агуулга, сургалтын программд тусгаж амьдралын зөв хэв маягт эртнээс сурган хэвшүүлэх,

- Иргэд, аж ахуйн нэгжийг оршин суугаа орон нутгийнхаа хог хаягдал боловсруулах аргыг судалж, хог хаягдлыг баялаг гэдэг талаас нь ойлгож ашигладаг болгох дадал хэвшил олгоход анхаарах, сургалт сурталчилгаа, энэ талын мэдлэг мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга тасралтгүй түгээн дэлгэрүүлэх, торгох, урамшуулах зэрэг эдийн засгийн аргыг хүчтэй, оновчтой ашиглах зэрэг цогц арга хэмжээг тууштай хэрэгжүүлж, нийгмийн хяналтыг бүх шатанд тавьж хэвшүүлж хэрэгжүүлэх хэрэгтэй хэмээн үзэв.

## **7. Шинжлэх ухааныг сурталчлах үйл ажиллагаа**

1. У.Загдцэсэм “Монгол, Японы улс төрийн харилцаа идэвхжиж байна” (0,5х.х.), Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Япон Улсад хийсэн албан ёсны айлчлалд зориулж “Өдрийн сонин” 2021.07.30,

2. У.Загдцэсэм “Ерөнхий сайд Ф.Кишида Японыг шинжлэх ухаан, инновацийн их гүрэн болгох зорилт дэвшүүлсэн” (0,8х.х.), “Зууны мэдээ” сонин 2021.10.21, №207 (6684) төвийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд 2 удаа ярилцлага өгч нийтлүүлэв.

## Дүгнэлт

Олон улс судлалын хүрээлэнгийн Япон судлалын багийн 2020-2023 онд гүйцэтгэж ирсэн “Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Япон Улстай хөгжүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагааны үүрэг” хэмээх энэхүү судалгааны төслийн хүрээнд гүйцэтгэсэн ажил нь:

- Манай улсын эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал, хөгжлийн зорилт, чиг бодлоготой уялдуулан хөгжлийн гадаад хүчин зүйлсийн дотроос Япон Улсын хүчин зүйл, нөлөөг тодруулан судлах; Монгол Улс, Япон Улсын эдийн засгийн хамтын ажиллагааны боломжид эрэл хайгуул хийх, хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд судалгааны үр дүнгээр тус дөхөм үзүүлэх талаар өмнөө тавьсан зорилгодоо хүрсэн хэмээн үзэж байна.
- Тус төслийн үр дүнгийн даалгавар төлөвлөгөөний дагуу хугацаандаа бүрэн биелэгдсэн болно. Төслийн хүрээнд нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нэгэн сэдэвт бүтээл, хамтын бүтээл зэрэгт Япон Улстай тогтоон хөгжүүлж буй эдийн засгийн салбарын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, манай улсын эдийн засгийг олон тулгууртайгаар хөгжүүлэх, Япон Улсын тэргүүний технологи, арга менежментийг нутагшуулан ашиглахад чиглэсэн санааг хөндөн, судлаачдын санал дүгнэлтийг дэвшүүлж ирснээрээ онцлог талтай. Мөн тус төслийн судалгааны хүрээнд бэлтгэн боловсруулж, төр засгийн удирдах байгууллагад хүргүүлсэн Бодлогын зөвлөмжид тухайлан улс орны хөгжлийн стратеги бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хүний хөгжлийн асуудлыг нухацтай авч үзэж, өсвөр насны хүүхдээс эхлээд хүн амын бүх давхаргыг хамарсан цэгцтэй бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байгааг, мөн эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад Япон Улстай тогтоосон бүх талын хамтын ажиллагааны боломж, Японы ногоон хөгжлийн туршлагаас манай улсад ашиглах боломжтой туршлагыг эрж хайж, ул суурьтай судалгааны үндсэн дээр нутагшуулан ашиглах санааг дэвшүүлснээрээ шинэлэг бөгөөд эдгээр зөвлөмжийн утга санаа нь төр засгийн бодлого боловсруулах байгууллагын ажлын хэрэгцээнд тус дөхөм үзүүлнэ хэмээн үзэж байна. Монгол, Японы харилцааны өнгөрсөн 50 жилийн түүхэн үйл явдлын агуулгыг бүрэн хамруулахыг зорьж бэлтгэсэн 2 эмхэтгэл болон эрдэм



шинжилгээний хурлын эмхэтгэл нь тус хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны түүх, өнөөгийн байдлын талаарх олон талын судалгаанд тулгуур материал болж бүрэн чадах эрдэм шинжилгээний болон практикийн ач холбогдолтой хэмээн үзэж байна.

- Эцэст нь манай улсын олон тулгуурт гадаад бодлогод чухал байр суурьтай гуравдагч хөршийн гол орнуудын нэг, Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан Япон Улстай тогтоон хөгжүүлж буй харилцаа хамтын ажиллагааны түүх, өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын судалгааг өөрийн орны эрх ашгийг харгалзан тасралтгүй шинжтэй, залгамж чанартай, гүнзгийрүүлэх чиглэлээр хэрэгжүүлэхийг зорьж буй тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилд түлхэц өгөх, судалгааны багийн чадавхыг дээшлүүлэхэд ч энэ удаагийн төслийн судалгаа зохих үр дүнгээ өгснийг тэмдэглэж байна.

Тайлан бичсэн Сэдэвт ажлын удирдагч

Б.Сэржав ШУА-ийн  
Олон улс судлалын хүрээлэнгийн  
эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан,  
доктор (Ph.D), дэд профессор

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал,
2. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011 он,
3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 он,
4. Шинэ сэргэлтийн бодлого. <https://www.nrpa.gov.mn/mn/new-recovery-policy>
5. “Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээр” Монгол Улсын Гадаад харилцааны Яам  
<URL://www.mfa.gov.mn/wpcontent/uploads/2015/02/>
6. Монголын экспортыг нэмэгдүүлэх, аж үйлдвэрийг төрөлжүүлэх зорилго бүхий Эрч нэмэх санаачилга, Токио, 2014.07.22,
7. “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2017-2021 он)” 2017.03.29 Токио,
8. “Монгол, Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөр (2013-2017 он)” 2013.09. Токио,
9. Монгол, Японы хамтын ажиллагааны 10 жилийн үндсэн хөтөлбөр.  
<https://www.mn.emb-japan.go.jp>
10. Монгол Улс, Япон Улсын найрамдал, хамтын ажиллагааны тухай Хамтарсан мэдэгдэл. 1998.05.14. Токио хот.
11. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль,
12. Монгол Улсын Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль,
13. Аялал жуулчлалын тухай Монгол Улсын хууль,
14. Аялал жуулчлалын сэргээх стратеги төлөвлөгөө. Инбаунд аялал жуулчлал 2022-2024. БОАЖЯ.
15. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо, <URL://www.1212.mn/> /2012-2020 оны эмхэтгэлүүд/
16. Гаалийн Ерөнхий газрын гадаад худалдааны барааны статистик мэдээлэл, Гаалийн цахим үйлчилгээний систем, <URL://www.gaali.mn>
17. “Монгол-Японы харилцаа: Баримт бичгүүд 1972-2022”, Олон улс судлалын хүрээлэн, УБ., 2022 он, “Соёмбо принтинг” хэвлэлийн компани,
18. “Монгол-Японы харилцаа: Он дарааллын товчоон 1972-2022”, Олон улс судлалын хүрээлэн, УБ., 2022 он, “Бэмби сан” хэвлэлийн компани,
19. Монгол Японы хооронд “Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр” байгуулах хэлэлцээ зарчмын тохиролцоонд хүрсэн болон Япон Улс, Монгол Улсын

- хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх тухай Хамтарсан мэдэгдэл, Токио хот, 2014.07.22.
20. “Монгол Улс Япон Улсын Энхтайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай Стратегийн түншлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн Хамтарсан мэдэгдэл” 2022.11.29. Токио.
  21. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийн танилцуулга. УБ., 2022 он,
  22. Ц.Батбаяр “Монгол ба Япон ХХ-ХХI зуунд: “Гуравдагч хөршийн харилцааны түүх”, “Бэмби сан” хэвлэлийн компани, УБ., 2022
  23. Ц.Батбаяр “Монгол ба Япон ХХ зуунд”, “Бэмби сан” хэвлэлийн компани, УБ., 2012 он.
  24. “Японы менежмент, жижиг дунд үйлдвэр: хөгжлийн туршлага” Ред. Доктор Ц.Даваадорж, “Тод бичиг” хэвлэлийн компани, УБ., 2014 он,
  25. “Японы ногоон хөгжлийн туршлага”, Ред. Доктор (Sc.D) Ц.Баатар, “Тод бичиг” ХХК УБ., 2017 он,
  26. Б.Сэржав “Монгол Японы харилцаа: ХХ зууны сүүлийн хагаст”, “Өргөө хэвлэлийн газар”, УБ., 2003 он,
  27. “Монгол Японы дипломат харилцаа: Гүнзгийрэл, чиг хандлага”, Б.Сэржав, “Олон улс судлал” сэтгүүл, 2017 он, №1(107)
  28. Б.Сэржав “Монгол-Японы соёлын харилцааны хэлэлцээр, түүний түүхэн ач холбогдол” Олон улс судлал сэтгүүл, 2018 он, №1(108)
  29. Д.Салдан “Монгол Японы эдийн засгийн хамтын ажиллагааг үүсгэн хэрэгжүүлсэн түүхэн зурвас (1973-1985)” УБ., 2008 он,
  30. “Аж үйлдвэрээр овоглосон төрийн сайд П.Дамдин” УБ., 2010 он,
  31. “Монгол Улсын хөгжлийн бодлого ба Японы хүчин зүйл (1990 оноос хойш)” У.Загдцэсэм, “Ази Номхон далайн геополитик ба Монгол Улс” Эрдэм шинжилгээний бага хурлын материал, МУИС, УБ., 2016 он,
  32. “Тогтвортой хөгжил: Монгол Японы хамтын ажиллагаа” У.Загдцэсэм, “Олон улс судлал” сэтгүүл, 2017 он, №1(107),
  33. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт ба Японы хүчин зүйл (Техник, технологийн хамтын ажиллагааны жишээн дээр)” У.Загдцэсэм, “Олон улс судлал” сэтгүүл, 2020 он, №1(110),

34. “Гадаад худалдаа дахь тарифын болон тарифын бус зохицуулалт” ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, “Соёмбо принтинг” хэвлэлийн компани, УБ., 2022 он,
35. Д.Баярсайхан “Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээрийн гарал үүслийн дүрэм”, УБ., 2019 он,
36. “Зөөлөн хүчний бодлого: Монгол-Оросын харилцаа” ОУСХ, УБ., 2022 он. Хэвлэлийн газар “Бэмби сан” хэвлэлийн газар,
37. “Олон Улсын харилцаан дахь зөөлөн хүчний бодлого ба Монгол Улс судалгаа, дүн шинжилгээ” УБ., 2021 он, “Соёмбо принтинг” хэвлэлийн компани,
38. З.Бжезинский “Шатрын аварга хөлөг: Америкийн оройлол, геостратегийнх нь зайлшгүй шаардлага” УБ., 2022 он,
39. “Монгол Улсын хөгжил олон улсын түвшинд харьцуулсан судалгаа”, УБ., 2020 он,
40. Монгол дахь үйл ажиллагааны тойм. Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд [https://www.jica.go.jp/Resource/mongolia/mon/activities/activity\\_01.html](https://www.jica.go.jp/Resource/mongolia/mon/activities/activity_01.html)
41. “Үндэсний Статистикийн Хороо, Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга”, УБ., 2022 он,
42. “Монгол Улсын Бүсчилсэн Хөгжлийн Нэгдсэн Судалгаа” Эцсийн тайлан. JICA 2016 он,
43. “Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын суурь судалгаа”, Эцсийн тайлан, 2017 он,
44. “Монгол Улс Аялал Жуулчлалын тогтвортой хөгжлийн талаарх Бодит мэдээ мэдээлэл тоо баримтыг цуглуулж, нөхцөл байдлыг нэгтгэн дүгнэх судалгаа”. Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага. 2021 он,
45. “Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд” түүвэр судалгааны үр дүн-2019. Монгол банк, Аялал жуулчлалын хөгжлийн төв. 2019 он,
46. Ногоон хөгжлийн бодлого. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам. Global Green Growth Institute. УБ., 2015 он,
47. “Тогтвортой хөгжил ба аялал жуулчлал”. УБ., 2006 он,
48. Ч.Мөнхжаргал “Соёлын аялал жуулчлал”, “Амар пресс” ХК., УБ., 2017 он,
49. Ч.Мөнхжаргал “Орхоны хөндийн аялал жуулчлал”, “Амар пресс” ХК., УБ., 2017 он,

50. “Мөнгө, санхүү, баялаг” эдийн засгийн судалгаа, шинжилгээний сэтгүүл, “Монгол-Японы хамтын ажиллагаа 50 жилд” олон улсын эрдэм шинжилгээний хуралд зориулсан дугаар, Монгол Банк, 2022 №31, мөн сэтгүүлийн 2023 оны дугаар,
51. “Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын судалгаа-тоо баримт” МҮХАҮТ,
52. “Тусгай ур чадварын ажилтан хүлээн авах тогтолцооны тухай гарын авлага” Immigration Service Agency of Japan 出入国在留管理庁 [guidebook.pdf](https://www.ssw.go.jp/guidebook.pdf) ([ssw.go.jp](https://www.ssw.go.jp))
53. “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын судалгаа”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Яам, 2017 он, [9e9b6e0a5b174e7a24cfadbb2c47db1565ec26ac.pdf](https://mlsp.gov.mn/9e9b6e0a5b174e7a24cfadbb2c47db1565ec26ac.pdf) ([mlsp.gov.mn](https://mlsp.gov.mn))
54. “Шинээр ирж буй гадаад ажиллах хүчнийг хүлээн авах ба нийгэмшүүлэх нийгмийн төлөөх үйл ажиллагаа” Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар (出入国在留管理庁) [930005605.pdf](https://www.moj.go.jp/930005605.pdf) ([moj.go.jp](https://www.moj.go.jp))
55. [“Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан ажиллах хүч”, Статистикийн Нэгдсэн мэдээллийн сан, 1212.mn](https://www.1212.mn/statistics/1212-2022-09-10)
56. “Монгол, Японы харилцаа: эрт, эдүгээ” 2001, Монгол - Японы харилцааг дэмжих нийгэмлэг, УБ., 2003 он
57. “Зөөлөн хүчний бодлого хэрэгжүүлсэн Азийн зарим орны туршлага, Монгол Улсын боломж” Л.Бямбаханд, Стратегийн судалгаа, УБ., (2015) No 70,
58. “Зөөлөн хүчний бодлого ба Монгол Улс” Ш.Батболд, “Рах Mongolica” сэтгүүл. 2016 он, №2
59. “Монгол-Японы соёлын харилцааны түүхэн тойм” Б.Боргилмаа, “Рах Mongolica”, 2017 он, №2.
60. “Монголд хувь хүн маш мундаг, Японд багаараа чадвараа хөгжүүлдэг” Япон Улсаас Монгол Улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд М.Такаока-тай хийсэн ярилцлага [zaluu.com](http://www.zaluu.com). 2018.10.18.
61. Удо Б.Баркманн. Монгол-Японы шилжилтийн үеийн жилүүдийн харилцааны тухайд <http://www.baabar.mn/article/mongol-yapony-shiljiltiin-ueiin-jiluudiiin-khariltsaany-tukhaid> 2022.09.10

62. Joseph S. Nye (2004). Soft power: The means to success in world politics. Public affairs.
63. “Japan, Mongolia and the potential of Ecotourism” Micheal Sutton [https://www.ritsumei.ac.jp/ir/isaru/assets/file/journal/21-1\\_03Sutton.pdf](https://www.ritsumei.ac.jp/ir/isaru/assets/file/journal/21-1_03Sutton.pdf)
64. Travel & Tourism Development Index 2021. World economic forum. 2022
65. Japanese Tourism Organization (JNTO) Departure Data, 2011-2020.

#### Япон хэлээрх эх сурвалж

1. 「我が国の政府開発援助」 外務所, 1990 年、 (“Манай улсын Засгийн газрын хөгжлийн албан ёсны тусламж”) Японы Гадаад хэргийн яамны хэвлэл, 1990 он,
2. 『観光白書』 令和 5 年 (Аялал жуулчлалын цагаан ном. 2023 он)
3. 『観光立国推基本進法』 (Үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх суурь хууль)
4. 『観光立国推進基本計画』 (Үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх суурь төлөвлөгөө)
5. 『生物多様性国家前略 2012-2020 の構成』 (Япон Улсын Биологийн олон янз байдлын стратеги төлөвлөгөө 2012-2020 он)
6. 『エコツーリズム推進法』 /平成十九年六月二十七日法律第百五号 / (“Экотуризмыг хөгжүүлэх тухай хууль” 2007.06.27. 105-р заалт)
7. 『エコツーリズム推進基本方針』 /平成 20 年 6 月 6 日閣議決定 (“Экотуризмыг хөгжүүлэх үндсэн чиглэл” 2008 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн Япон Улсын Засгийн газрын тогтоол)
8. 『日本におけるエコツーリズムの取組について』 (Япон дахь Экотуризмын үйл ажиллагааны тайлан)
9. 『在留外国人統計 (旧登録外国人統計) 統計表』 出入国在留管理庁 Immigration Services Agency of Japan [https://www.moj.go.jp/isa/policies/statistics/toukei\\_ichiran\\_touroku.html](https://www.moj.go.jp/isa/policies/statistics/toukei_ichiran_touroku.html)
10. 『日本の将来推計人口 (令和 5 年推計) 結果の概要—令和 3(2021)年～令和 52(2070)年—』 国立社会保障・人口問題研究所、2023 年 [pp2023\\_gaiyou.pdf \(ipss.go.jp\)](https://www.ipss.go.jp/pp2023_gaiyou.pdf)

11. 『日本の地域別将来推計人口－平成 27～57 年－（平成 30 年推計）』（人口問題研究資料第 340 号）
12. 菅野雅人「日本の深刻な労働問題とその改善に向けて」経済政策研究第 14 号 2018 年 3 月, The Journal of Economic Policy Studies, Kagawa University
13. 金明中「日本における外国人労働者受け入れの現状と今後の課題」、ニッセイ基礎研究所報 Vol.64, July 2020 NLI Research Institute [https://www.nli-research.co.jp-files/topics/63059\\_ext18\\_.pdf?site=nli](https://www.nli-research.co.jp-files/topics/63059_ext18_.pdf?site=nli)
14. 総務所「国勢調査」「人口推計」国立社会保障・人口問題研究所「日本の将来推計人口」
15. 『日本の将来推計人口』国立社会保障・人口問題研究所（人口問題研究資料第 336 号平成 29 年）
16. 『労働市場の未来推計 2030』パーソル総合研究所・中央大学、2019 年 3 月
17. [http://rc.persol-group.co.jp/news/files/future\\_population\\_2030\\_3.pdf](http://rc.persol-group.co.jp/news/files/future_population_2030_3.pdf)
18. 横内成人「労働人口減少下の日本における望ましい外国人労働者政策」経済政策研究第 15 号 2019 年 3 月 The Journal of Economic Policy Studies, Kagawa University
19. 磯山友達「「なし崩し」で増え続ける外国人労働者」2018 年 2 月 23 日「日経ビジネス」  
<https://business.nikkei.com/atcl/report/16/021900010/022200062/?P=3>
20. ERINA REPORT「北東アジア動向分析」2020、2021 年号版
21. JETRO 日本貿易振興機構（ジェトロ）URL:[://www.jetro.go.jp](http://www.jetro.go.jp)
22. 岩田 伸人「日本・モンゴル EPA の経緯と課題」国際貿易投資研究所、青山学院大学 <https://www.iti.or.jp/kikan104/104iwata.pdf>
23. 「日本とモンゴルの関係と EPA 締結に向けた課題」平成 22 年度自由貿易協定等情報調査分析検討事業モンゴルにおける農林水産業と農林水産政策等の調査・分析プロマーコンサルティング  
[https://www.maff.go.jp/j/budget/yosan\\_kansi/sikkou/tokutei\\_keihi/seika\\_h22/kokusai\\_ippan/pdf/60100014\\_08.pdf](https://www.maff.go.jp/j/budget/yosan_kansi/sikkou/tokutei_keihi/seika_h22/kokusai_ippan/pdf/60100014_08.pdf)

**Архивын эх сурвалжууд**

Монгол Улсын Гадаад харилцааны Төв Архив

## **Тогтмол хэвлэл**

Засгийн газрын мэдээ

“Ардын эрх” сонин

“Өдрийн сонин”

## **Вэб сайт**

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны цахим хуудас  
[www.mlsp.gov.mn](http://www.mlsp.gov.mn)

Монгол Улсын Гадаад Харилцааны Яамны албан ёсны вэб сайт  
<https://www.mfa.gov.mn>

Япон Улсын Гадаад Хэргийн Яамны албан ёсны вэб сайт  
<https://www.mofa.go.jp/mofaj/area/mongolia/index.html>

Япон Улсын Элчин сайдын яамны цахим хуудас [www.mn.emb-japan.go.jp](http://www.mn.emb-japan.go.jp)

МОНЦАМЭ, <https://www.montsame.mn/>

ЖАЙКА, <https://www.jica.go.jp/mongolia/mon/>

<https://www.mongolbank.mn/>

<https://www.1212.mn/>

<https://www.japanguide.mn/>

<https://www.palament.mn/>

<https://eagle.mn>

<https://news.mn/>

<https://legalinfo.mn/>

<https://ctsolutions.mn/>

<http://www.monshibasaki.com/>

<https://www.worldbank.org/mn/>

[http://open\\_jicareport.jica.go.jp/pdf/12284618.pdf](http://open_jicareport.jica.go.jp/pdf/12284618.pdf)

<http://mlsp.gov.mn/>

[www.econ.tohoku.ac.jp](http://www.econ.tohoku.ac.jp)

[www.jstage.jst.go.jp](http://www.jstage.jst.go.jp)

<https://mongolianeconomy.mn/>

<https://www.newspress.mn/>

<https://www.undp.org/mn/>



**“Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Япон Улстай хөгжүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагааны үүрэг” (2020-2023 он)**

сэдэвт ажлын үр дүнгээр нийтлүүлсэн бүтээлийн жагсаалт

**Хамтын бүтээл**

“Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Монгол, Японы олон талт хөгжлийн түншлэл” (“Битпресс” хэвлэлийн компани, УБ., 2023 он, 18 х.х., Редактор Ц.Баатар, хэвлэлд бэлтгэсэн У.Загдцэсэм)

**Нэгэн сэдэвт зохиол**

Ц.Батбаяр “Монгол ба Япон XX-XXI зуунд: “Гуравдагч хөрш”-ийн харилцааны түүх” (“Бэмби сан” хэвлэлийн компани, УБ., 2022 он, 27,3 х.х., Редактор Б.Сэржав)

**Судалгааны эмхэтгэл 3ш**

1. “Монгол Японы харилцаа он дарааллын товчоон: 1972-2022” эмхэтгэл (“Бэмби сан” хэвлэлийн компани, УБ., 2022 он, 56,5 х.х., Редактор Л.Хайсандай, гүйцэтгэгч Б.Сэржав, У.Загдцэсэм, М.Болормаа, А.Сосорбурам)
2. “Монгол Японы харилцаа: Баримт бичгүүд 1972-2022” эмхэтгэл (“Соёмбо” хэвлэлийн компани, УБ., 2022 он, 58,0 х.х., Редактор Л.Хайсандай, Ц.Батбаяр, Д.Золбоо, Р.Төрдалай нар, гүйцэтгэгч Б.Сэржав, У.Загдцэсэм, М.Болормаа, А.Сосорбурам нар)
3. “Олон улс судлал-2022: Монголын япон судлал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл (“Соёмбо” хэвлэлийн газар, УБ., 2023 он, 10 х.х., Редактор Р.Төрдалай, хэвлэлд бэлтгэсэн Б.Саранчимэг)

**Нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл 18 ш 17 х.х, үүнээс гадаадад 5 ш**

1. Б.Сэржав, У.Загдцэсэм “ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн япон судлалын түүх, өнөөгийн байдал, цаашдын зорилт” (0.8 х.х.), БНХАУ, Евразийн судалгааны нийгэмлэг, “Зүүн Хойд Ази судлал” цахим сэтгүүлд 2021.06 сар

[essra.org.cn](http://essra.org.cn)

作者：波.瑟日扎布 (Б.Сэржав) 蒙古科学院国际关系研究所 博士；

乌.扎格都澈瑟木 (У.Загдцэсэм) 蒙古科学院国际关系研究所研究员

2. Б.Сэржав “Монгол-Японы харилцааны хөгжилд энх тайвны хөдөлгөөний гүйцэтгэсэн үүрэг” 吳人徳司編『日本・モンゴル両国の教育、文化、スポーツの分野で共に歩んだ 50 年を振り返って』、東京外国語大学アジア・アフリカ言語文化研究所、日本ルート印刷出版株式会社 2023 年 3 月、187-196 頁 (Эмх. Токүсү Күрэбито “Япон-Монголын хоорондын боловсрол, соёл, урлаг, эдийн засаг, спортын салбар дахь 50 жилийн хамтын ажиллагааг эргэцүүлэх нь”, Токиогийн Гадаад судлалын Их сургуулийн Ази, Африк хэл соёлын хүрээлэн, Токио, 2023, 187-196-р тал.)
3. Б.Сэржав, У.Загдцэсэм “ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Япон судлалын судалгааны чиглэл: Уламжлал, шинэчлэл” (0.5 х.х.), “Олон улс судлал-2022: Монголын Япон судлал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, “Соёмбо принтинг” хэвлэлийн газар, УБ., 2023 он, 12-18-р тал,
4. Л.Хайсандай “Олон улсын харилцаа ба үндэсний эрх ашгийн харилцан хамаарал ба Монгол Улсын гадаад бодлого” (0.5 х.х.), “Олон улсын харилцааны тулгамдсан асуудлууд одоо, ирээдүй” Их засаг их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл, УБ., 2022 он, 9-13-р тал,
5. Ц.Баатар “Монгол Улсын гадаад орчин: Олон талт дипломат хамтын ажиллагаа” (1,2 х.х.), “Азийн бүс нутгийн байгууллагууд ба Монгол Улс” эмхэтгэлд, УБ., 2020 он, 22-40-р тал,
6. Ц.Баатар “Эрчим хүчний салбарын дижитал шилжилтийн чиг хандлага” (3.0 х.х.), “Дижитал эдийн засаг” хамтын бүтээл, “Соёмбо принтинг” хэвлэлийн газар, УБ., 2023 он, 87-152-р тал,
7. Ц.Батбаяр “Монгол ба Японы хооронд 1972 онд дипломат харилцаа тогтоосон нь: 50 жилийн өндөрлөгөөс нягтлан шинжихүй” (0,9 х.х.), “Олон улс судлал” сэтгүүл 2022 он, Vol.45, № 114, 1-14-р тал,

8. У.Загдцэсэм “Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт ба Японы хүчин зүйл (Техник, технологийн хамтын ажиллагааны жишээн дээр)” (1,0 х.х.), “Олон улс судлал” сэтгүүл 2021 он. №1 41-55-р тал,
9. У.Загдцэсэм “Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх шаардлага, Япон Улсын аж үйлдвэрийн соёлоос суралцах нь” (0.6 х.х.), “Олон улс судлал-2022: Монголын Япон судлал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, “Соёмбо принтинг” хэвлэлийн газар, УБ., 2023 он, 111-122-р тал,
10. У.Загдцэсэм (2023). “External Factors Affecting Sustainable Development of Mongolia” pp.951-956, Linggui Wang “China's Development and the Construction of the Community with a Shared Future for Mankind” Springer, Singapore, <https://link.springer.com/book/10.1007/978-981-19-7423-6>, <https://doi.org/10.1007/978-981-19-7423-6>, 06 May, 2023 (“Монгол Улсын тогтвортой хөгжилд нөлөөлж буй гадаад хүчин зүйлс” 951-956-р тал, Linggui Wang “Хятадын нийгмийн хөгжил ба хүн төрөлхтний ирээдүйд оруулж буй хувь нэмэр” Springer Singapore),
11. М.Болормаа “Монгол Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилт боловсрол, шинжлэх ухааны салбарын жишээн дээр”, МУИС-ийн “SIRPA Forum 2019” хурлын эмхэтгэл, УБ., 2020 он, 139-158-р тал,
12. М.Болормаа “Эдийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улсын хоорондын хэлэлцээр (EPA)-ийн хэрэгжилт”, (1,5 х.х.), МУИС-ийн “SIRPA Forum Ковид-19 дэлхийн шинэ дэг журам” Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл №04, УБ., 2021 он, 274-295-р тал,
13. А.Сосорбурам “Япон Улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” (0,6 х.х.), SIRPA Forum: “Бүс нутгийн хамтын ажиллагаа ба Монгол Улс” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2020 он, 305-312-р тал.
14. А.Сосорбурам “Монгол-Японы эдийн засгийн хамтын ажиллагаа: Хоёр талын худалдааны өнөөгийн байдал” (0,6 х.х.), “SIRPA Forum: Ковид-19 Дэлхийн шинэ дэг журам” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл № 4, УБ., 2021 он, 80-90-р тал,

15. А.Сосорбурам “Япон Улсын гаднаас ажиллах хүч авах бодлогын өөрчлөлт” (0.5 х.х.), БНХАУ-ын “Зүүн хойд Азийн судалгаа мэдээллийн товхимол онлайн сэтгүүл (苏素日步拉玛: 日本对外劳工政策变化研究, 东北亚研究通讯, 2022-07-11, 北京苏素日步拉玛: 日本对外劳工政策变化研究 (qq.com)). (2022.07 сар, хятад хэлээр),
16. А.Сосорбурам “Монгол Японы худалдааны өнөөгийн байдал: Харилцан нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний бүтцийн жишээгээр” (0.6 х.х.), “Олон улс судлал-2022: Монголын Япон судлал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, “Соёмбо принтинг” хэвлэлийн газар, УБ., 2023 он, 123-132-р тал,
17. А.Сосорбурам 「モンゴル・日本間貿易の現状：輸出入品構造分析を通じて」 論文、呉人徳司編『日本・モンゴル両国の教育、文化、スポーツの分野で共に歩んだ 50 年を振り返って』、東京外国語大学アジア・アフリカ言語文化研究所、日本ルート印刷出版株式会社 2023 年 3 月、171-178 頁 (“Монгол, Японы худалдааны өнөөгийн байдал: Харилцан нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний бүтцийн жишээгээр” өгүүлэл, Эмх. Токүсү Күрэбито “Япон-Монголын хоорондын боловсрол, соёл, урлаг, эдийн засаг, спортын салбар дахь 50 жилийн хамтын ажиллагааг эргэцүүлэх нь”, Токиогийн Гадаад судлалын Их сургуулийн Ази, Африк хэл соёлын хүрээлэн, Токио, 2023 он, 171-178-р тал.),
18. Б.Саранчимэг “Японы зөөлөн хүчний бодлогын Монгол дахь нөлөө (Монгол-Японы соёлын харилцааны жишээн дээр)” (0.6 х.х.), “Олон улс судлал-2022: Монголын Япон судлал” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, “Соёмбо принтинг” хэвлэлийн газар, УБ., 2023 он, 133-144-р талд тус тус нийтлүүлэв.

### **Зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурал 3 удаа**

1. “Монгол Японы хоорондын боловсрол, соёл урлаг, эдийн засаг, спортын салбар дахь 50 жилийн хамтын ажиллагааг эргэцүүлэх нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг (Улаанбаатар, 2022.09.03) Соёл эрдэм дээд сургууль, Токиогийн гадаад судлалын их сургуулийн Ази, Африкийн

хэл соёл судлалын хүрээлэнтэй хамтран зохион байгуулав. Хуралд монгол, японы 30-аад эрдэмтэд судлаачид илтгэл тавьж хэлэлцүүлэв.

2. “Олон улс судлал-2022: Монголын япон судлал” эрдэм шинжилгээний хурлыг (Улаанбаатар, 2022.12.23) зохион байгуулж, нийт 11 илтгэл хэлэлцэв.
3. “Монгол-Японы боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны харилцаа, хамтын ажиллагаа” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг (Улаанбаатар, 2023.05.27) Монголын Япон Судлалын Нийгэмлэг, Япон Улсад докторын зэрэг хамгаалсан монгол эрдэмтдийн Хакасэкай Холбоотой хамтран зохион байгуулж, 9 эрдэмтэн судлаачид илтгэл тавьж хэлэлцүүлэв.

### **Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл 11 илтгэл**

1. Б.Сэржав “Олон улсын харилцааны хүрээлэнд хэрэгжиж буй Япон судлал, Монгол Японы харилцаа, Японы хөгжлийн туршлагын талаарх судалгааны ажил, цуврал бүтээлүүдийн талаарх танилцуулга”, УИХ-ын Тамгын газарт (2021.04.07),
2. Б.Сэржав “Сурагчдад ёс зүйн боловсрол олгоход Японы туршлагаас суралцах нь” “Үндсэн хуулийн шинэчлэл, Монголын хөгжлийн загвар, Японы туршлага” сэдэвт олон улсын цахим хэлэлцүүлэгт (УБ., 2021.04.14),
3. Б.Сэржав “Монгол Японы харилцааны хөгжилд энх тайвны хөдөлгөөний гүйцэтгэсэн үүрэг” илтгэлийг “Монгол Японы хоорондын боловсрол, соёл урлаг, эдийн засаг, спортын салбар дахь 50 жилийн хамтын ажиллагааг эргэцүүлэх нь” олон улсын эрдэм шинжилгээний хурал (Улаанбаатар, 2022.09.03),
4. Б.Сэржав, У.Загдцэсэм “Олон улс судлалын хүрээлэнгийн Япон судлалын судалгааны чиглэл: Уламжлал, шинэчлэл” илтгэлийг “Олон улс судлал-2022: Монголын япон судлал” эрдэм шинжилгээний хуралд (Улаанбаатар, 2022.12.23),
5. Ц.Баатар “Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага” илтгэлийг “Монголын энх тайван ба түүхэн туршлага” сэдэвт олон улсын монголч эрдэмтний XII их хурлын “Монголчуудын гадаад ертөнц ба харилцаа” салбар хуралдаанд (УБ., 2023.08.09-14),

6. Л.Хайсандай “Чингис хааны төрийн алтан аргамжийн бодлого ба түүний Монгол Улс дахь судлалын тухайд” “Монголын энх тайван ба түүхэн туршлага” сэдэвт олон улсын монголч эрдэмтний XII их хурал (УБ., 2023.08.09-14),
7. У.Загдцэсэм “Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх шаардлага, Япон Улсын аж үйлдвэрийн соёлоос суралцах нь” илтгэлийг “Монгол Японы хоорондын боловсрол, соёл урлаг, эдийн засаг, спортын салбар дахь 50 жилийн хамтын ажиллагааг эргэцүүлэх нь” олон улсын эрдэм шинжилгээний хурал (Улаанбаатар, 2022.09.03),
8. У.Загдцэсэм “Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд Япон Улсын хүчин зүйл: Улс төр, олон улсын тавцан дахь хамтын ажиллагааны жишээн дээр” илтгэлийг Монголын Япон Судлалын Нийгэмлэг, Япон Улсад докторын зэрэг хамгаалсан монгол эрдэмтдийн Хакасэкай Холбоо, ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан “Монгол-Японы боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны харилцаа, хамтын ажиллагаа” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд (УБ., 2023.05.27),
9. М.Болормаа “Монгол Японы стратегийн түншлэлийн дунд хугацааны хоёр дахь хөтөлбөрийн боловсролын салбар дахь хэрэгжилт, үр дүн” илтгэл, МУИС-ийн SIRPA FORUM-2021 эрдэм шинжилгээний хуралд (УБ., 2021.12.04),
10. А.Сосорбурам “Монгол Японы худалдааны өнөөгийн байдал: Харилцан нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний бүтцийн жишээгээр” илтгэлийг “Монгол Японы хоорондын боловсрол, соёл урлаг, эдийн засаг, спортын салбар дахь 50 жилийн хамтын ажиллагааг эргэцүүлэх нь” олон улсын эрдэм шинжилгээний хурал (УБ., 2022.09.03),
11. Б.Саранчимэг “Японы аюулгүй байдлын бодлого: Уламжлал, шинэчлэл” илтгэлийг Монголын Япон Судлалын Нийгэмлэг, Япон Улсад докторын зэрэг хамгаалсан монгол эрдэмтдийн Хакасэкай Холбоо, ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан “Монгол-Японы боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны харилцаа, хамтын ажиллагаа” сэдэвт эрдэм шинжилгээний хурал (УБ., 2023.05.27)-д тус тус хэлэлцүүлэв.

**Зохион байгуулсан эрдэм шинжилгээний семинар нийт 7 удаа, 12 илтгэл**

1. “Япон Улсын гаднаас ажиллах хүч авах бодлогын өөрчлөлт ба Монгол Улс” Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний семинар (УБ., 2021.04.21),
  - А.Сосорбурам “Япон Улсын гаднаас ажиллах хүч авах бодлогын өөрчлөлт” илтгэл,
2. “Монгол, Японы зарим салбарын хамтын ажиллагаа” Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний семинар (2022.05.11)
  - М.Болормаа “Японд инженер технологийн мэргэжлээр их дээд сургууль төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал” илтгэл,
  - А.Сосорбурам “Монгол, Японы хоёр талын харилцан нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний судалгаа” илтгэл,
3. “Япон Улсын гадаад бодлого” Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний семинар (2022.05.18)
  - У.Загдцэсэм “Ковидийн дараах Япон Улсын гадаад бодлого” илтгэл,
4. “Монгол Улс, Япон Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хэрэгжилт” Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний семинар (2022.12.07)
  - М.Болормаа “Монгол Улс, Япон Улс хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хэрэгжилт ба зарим асуудал” илтгэл,
5. “Монгол-Японы худалдааны өнөөгийн байдал” Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний семинар (2023.04.26)
  - А.Сосорбурам “Монгол-Японы экспортын боломж ба тулгамдаж буй асуудал: Чацарганы экспортын жишээгээр” илтгэл,
6. “Монгол-Японы аюулгүй байдлын салбарын өнөөгийн байдал” Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний семинар (2023.05.24)
  - Б.Саранчимэг “Японы аюулгүй байдлын бодлогын шинэчлэл” илтгэл,
7. “Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Монгол, Японы олон талт хөгжлийн түншлэл” эрдэм шинжилгээний семинар (2023.12.11)
  - Ц.Баатар “Монгол Улс: Хөгжлийн гадаад хүчин зүйлс” илтгэл,

- У.Загдцэсэм “Монгол Японы олон талт хөгжлийн түншлэлийн өнгөрсөн одоо, ирээдүй” илтгэл,
- Б.Сэржав “Монгол-Японы хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагаа” илтгэл,
- Б.Саранчимэг “Монгол-Японы аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагаа” илтгэл,
- А.Сосорбурам “Япон Улсын гаднаас ажиллах хүч авах бодлого ба Монгол-Японы хөдөлмөрийн салбар дахь хамтын ажиллагаа” сэдэвт илтгэлийг тус тус хэлэлцүүлэв.

### **Бодлогын зөвлөмж 2 удаа**

- 1.Б.Сэржав “Бага, дунд сургуулийн Ёс зүйн хичээлийн Сургалтын хөтөлбөрийг сайжруулахад туслах зорилгоор “Японы бага сургуульд ёс зүйн боловсрол олгож буй туршлагаас”” сэдвээр Бодлогын зөвлөмж боловсруулж (0,7 х.х.) УИХ-ын ажлын алба, Боловсрол, Шинжлэх ухааны яамны албан хэрэгцээнд зориулан хүргүүлэв. 2021.3-р сард
- 2.Б.Сэржав, Ц.Баатар, У.Загдцэсэм, А.Сосорбурам “Япон Улсын ногоон хөгжлийн бодлого, туршлага, сургамж” сэдвээр Бодлогын зөвлөмж (0,9 х.х.) боловсруулж УИХ-ын тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн, Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн ажлын алба, Эдийн засаг, хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээнд зориулан 2023.12 дугаар сард тус тус хүргүүлэв.

### **Социологийн судалгаа**

Төслийн судалгааны баг “**Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйл: Япон Улстай хөгжүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагааны үүрэг**” (2021-2023 он) сэдэвт ажлын хүрээнд манай улсаас олон улстай тогтоон хөгжүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагаа, түүний дотор Монгол Японы эдийн засгийн хамтын ажиллагааны талаар олон нийтийн санаа бодлыг тандах зорилгоор түүврийн аргаар 21-65 насны 350 хүнээс 2023 оны 6 дугаар сард социологийн судалгаа авч дүгнэв.



## **Хэвлэлийн ярилцлага 2 удаа**

1. У.Загдцэсэм “Монгол, Японы улс төрийн харилцаа идэвхжиж байна” (0,5 х.х.), Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Япон Улсад хийсэн албан ёсны айлчлалд зориулж “Өдрийн сонин” 2021.07.30
2. У.Загдцэсэм “Ерөнхий сайд Ф.Кишида Японыг шинжлэх ухаан, инновацийн их гүрэн болгох зорилт дэвшүүлсэн” (0,8 х.х.), “Зууны мэдээ” сонин 2021.10.21, №207 (6684)

**ЯПОНЫ БАГА СУРГУУЛЬД ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ  
ОЛГОЖ БУЙ ТУРШЛАГААС  
(Санал зөвлөмж)**

ШУА-ийн ОУСХ-гийн Гуравдагч хөрш орон судлалын салбар,  
Япон судлалын секторын эрхлэгч, доктор (Ph.D) Б.Сэржав  
Докторант У.Загдцэсэм, докторант М.Болормаа  
ЭШДэА, магистр А.Сосорбурам

Улс орон бүрийн хөгжил дэвшлийн хувь заяанд тухайн нийгмийн гишүүдийн ёс суртахууны түвшин, өөрөөр хэлбэл иргэн бүр нь зөв хүн болж, зөв ёс суртахуунаар төлөвшиж чадаж байна уу, үгүй юү гэдэг асуудал чухал үүрэгтэй байдаг. Тийм ч учраас улс үндэстэн бүр үр хүүхэд, залуу хойч үеэ зөв ёс суртахуунтай хувь хүн болгож өсгөн төлөвшүүлэх өөр өөрийн уламжлалт арга барилтай байдаг, түүнийгээ үргэлжлүүлж хөгжүүлж авч явахад ач холбогдол өгч, бодлогын түвшинд чухалчлан үзэж иржээ.

Манай улсын боловсролын бодлогод ч хүүхдийг багаас нь зөв хүн болгон сургаж хүмүүжүүлэх, монгол үндэснийхээ дэвшилтэт ёс заншил, соёлыг эзэмшсэн, эх оронч, хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлэх талаар тодорхой ахиц дэвшил гарч, БСШУ-ны сайдын тушаалаар батлагдсан сургалтын хөтөлбөрөөр бага, дунд ангид Иргэний боловсрол, Хүн ба байгаль зэрэг хичээл, мөн Ёс суртахууны хичээл орж байгаа нь цаашид зөв монгол хүн төлөвшиж, Монгол Улсынхаа хөгжил дэвшилд үүрэг нөлөөгөө үзүүлэх нь дамжиггүй. Бидний амьдарч буй XXI зуун нь улс орон бүрийн өмнө мэдлэгт суурилсан нийгмийг бүтээн байгуулах шаардлага, мөн глобалчлалын үйл явцад өөр соёл, өөр иргэншлийн дунд, олон улсын харилцан хамаарлын нөхцөлд оршин тогтнохтой холбогдсон цөөн бус сорилтыг тулгасаар байна. Ийм нөхцөлд манай улсын хөгжил дэвшил, тусгаар тогтнолын эрх ашгийн үүднээс залуу хойч үеэ баттай мэдлэг, өгөөмөр уужим эх оронч сэтгэл, эрүүл чийрэг бие бялдрыг цогцлоосон өв тэгш иргэн болгож өсгөн төлөвшүүлэхэд улам илүү анхаарах хэрэгтэй болж байна.

Манай улсын төрийн байгууллага, хөгжлийн бодлогын судлаачид эрдэмтэд, зарим улс төрчид сүүлийн үед Монгол Улсын хөгжлийн чиг хандлагыг Японы хүчин зүйлтэй холбон үзэх явдалд өмнөхөөс илүү ач холбогдол өгөх болж, Япон Улсын хөгжлийн загварыг харгалзан үзэх, улс орны эдийн засгийн бодлого төлөвлөлтөд Японы туршлагаас ашиглах, улмаар “Япон лугаа адил хөгжих”

санал санаачилга дэвшүүлж, Монгол Улсынхаа хөгжилд хэрэг болох туршлагыг олж судлах, нэвтрүүлэн ашиглахад анхаарал хандуулж эхлээд байна. Мөн “боловсролын реформыг боловсролын салбарт эрх зүйн цогц шинэчлэл хийх замаар хэрэгжүүлэх, ...боловсролын зорилгоо алсын хараатай тодорхойлох, сургалтын хөтөлбөр, агуулгаа сургахаас суралцахуй руу чиглэсэн байхаар шинэчлэх...”<sup>1</sup> зорилтыг дэвшүүлэн тавьж байна.

Иймээс тус ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн судалгааны баг өмнөх жилүүдэд хэрэгжүүлж ирсэн Япон Улсын хөгжлийн туршлагын судалгаа, боловсролын тогтолцооны судалгааны ажлын үр дүнд тулгуурлан, Япон Улсад бага сургуулийн шатнаас сурагчдад ёс зүйн боловсрол олгож буй арга туршлагыг хичээлийн хөтөлбөрийн жишээгээр товч танилцуулж, түүнийг шууд хуулбарлан хэрэглэх бус, оновчтой гэж үзсэн зарим зүйлсийг өөрийн орны онцлог, хөгжлийн стратеги, монгол хүний мөн чанарт зохицуулан, нарийн тооцоо судалгааны үндсэн дээр авч ашиглахыг санал болгож байна.

Япон Улсад орчин үеийн сургуулийн тогтолцоо 1872 онд (Мэйжийн 5 он) анх суурь нь тавигдаж эхэлсэн тэр цагаас Японы “Боловсрол олгох журам”-д бага сургуульд заавал үзэх хичээлийн тоонд Унших, Бичих, Тоо, Газар зүй, Түүхийн хичээлтэй эн зэрэгцэн Ёс зүйн хичээлийг оруулахаар тогтоосон байдаг. Түүнчлэн Япон улсын түүхийн үе шат бүрд (Мэйжи үе 1868-1911, Тайшөо үе 1911-1925, Шёова үе 1925-1989, Хэйсэй үе 1989-2019, Рэйва үе 2019 оноос) улс орны өмнө тавигдаж ирсэн нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтын агуулга, чиг хандлагыг талаар Ёс зүйн хичээлийн хөтөлбөрийн агуулгад уялдуулан тусгаж, хэрэгжүүлж ирсэн нь харагддаг.

Одоо ч Япон Улсын бага, дунд, ахлах сургуулийн бүх ангид Ёс зүйн хичээлийг заавал үзэх хичээлийн тоонд багтаан тусгай цагаар оруулж байна. Тусгай цагаар хичээллээд зогсохгүй сургалтын удирдамжид сургуулийн үйл ажиллагаа бүхэлдээ сурагчдад ёс суртахууны боловсрол төлөвшүүлэхэд чиглэгдэх ёстойг тодорхойлсон байдаг. Өнөөгийн байдлаар Ёс зүйн хичээл бага, дунд сургуулийн бүх ангид жилд 35 цаг (бага ангийн хичээлийн жил 34 долоо хоног, бага сургуульд хичээлийн нэг цаг 45 мин, дунд сургуульд 50 мин), 7 хоногт 1 цаг байхаар зохицуулан хичээллэж байна.

---

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврыг чуулганыг нээж, УИХ-ын дарга Г.Занданшатарын хэлсэн үг. 2021.03.15

Япон Улсад “Боловсролын суурь хууль (教育基本法)”, “Сургуулийн боловсролын хууль (学校教育法)” зэрэг боловсролын салбарын хууль дүрэм харьцангуй удаан хугацаагаар тогтвортой хэрэгждэг бөгөөд улс орны дотоод, гадаад бодлого, эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги зорилт, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн үе шат, дэлхийн дахины хөгжлийн чиг хандлага зэргийг нарийн тооцоолсны үндсэн дээр зайлшгүй шаардлагатай үед хууль эрх зүйн баримт бичгийг шинэчилдэг, зарим үед зөвхөн хэсэгчилсэн шинэчлэл хийдэг. Үүнийг дагалдан “Бага, дунд сургуулийн сургалтын удирдамж”, “хичээлийн хөтөлбөр” ч ихээхэн тогтвортой, уламжлалаа хадгалсан шинжтэй байдаг. Одоо хэрэгжиж буй “Бага сургуулийн сургалтын хөтөлбөр (小学校 学習指導要領)”<sup>2</sup> –ийн III бүлэгт “Ёс зүй”-н хичээлийг авч үзэж, тус бүлгийн I зүйлд Ёс зүйн хичээлийн зорилго, II зүйлд хичээлийн агуулга, III зүйлд хичээлийн төлөвлөгөө боловсруулалт, заах арга зүйг нарийвчлан заажээ.

Тус хөтөлбөрт Ёс зүйн хичээлийн зорилгыг ирээдүйн сайн сайхан амьдралд бат суурь болж өгөх ёс суртахууныг эзэмшүүлэхийн тулд, ёс зүйн үнэ цэнийн тухай ойлголтыг суулгасны үндсэн дээр бага сургуулийн сурагчдад өөрийгөө хянаж, аливаа зүйлийг олон талаас нь олон өнцгөөс тунгаан бодох, цаашдын аж амьдралынх нь тухай гүн гүнзгий бодож эрэгцүүлж сургах явдал... хэмээн тэмдэглэсэн байна. Энд бага, дунд сургуульд “ёс суртахууны үнэт зүйл”-ийн талаар илүү гүнзгий ойлголт өгөх шаардлагатайг онцлон авч үзжээ. Тухайлбал, Ёс зүйн хичээл нь бусад хичээлүүдээр олгож буй ёс суртахууны хүмүүжлийн дутууг нөхөх, гүнзгийрүүлэх, нэгдсэн системтэй мэдлэг болгож эзэмшүүлэх үүргийг гүйцэтгэх, тухайлан ёс суртахууны боловсролыг зангидах гол үүргийг гүйцэтгэх ёстойг цохон тэмдэглэжээ. Өөрөөр хэлбэл Ёс зүйн хичээл нь ёс суртахууны үнэт зүйлийн цаад агуулга болох хүн гэдэг утгаар зөв амьдрах ухааныг ойлгуулахад утга учир нь орших тухай, мөн энэ хичээлийг явуулахдаа зөвхөн сургалтын материал дээр ярилцах биш, төрөл бүрийн боломжийг ашиглаж, хичээлийн учир холбогдолтой уялдуулан сайтар боловсруулж, өргөн утга агуулгаар заах хэрэгтэй, ёс суртахууны үнэ цэнийг ойлгож ухаарах субъект нь

---

<sup>2</sup> 小学校学習指導要領 (平成 29 年告示) “Бага сургуулийн сургалтын хөтөлбөр Хэйсэйн 29 он” [mext.go.jp/component/a\\_menu/education/micro\\_detail/\\_icsFiles/afieldfile/2018/09/05/1384661\\_4\\_3\\_2.pdf](http://mext.go.jp/component/a_menu/education/micro_detail/_icsFiles/afieldfile/2018/09/05/1384661_4_3_2.pdf) 165-172-р тал

сурагчид өөрсдөө байх бөгөөд багшийн зүгээс ёс зүйн ойлголтыг нэг талаас тулган хүлээлгэх асуудал байх ёсгүй”<sup>3</sup>-г цохон тэмдэглэжээ.

Ёс зүйн хичээлийн агуулгыг

1. Өөрийн биед хамаарах зүйлс
2. Бусадтай харьцахтай холбоотой зүйл
3. Байгаль болон ариун дагшин зүйлтэй харьцахтай холбоотой зүйл
4. Хамт олон, нийгэмтэй харьцахтай холбоотой зүйл

гэсэн ерөнхий 4 хэсэг агуулгад багтаан тодорхойлж, бага сургуулийн 1, 2 дугаар ангид 16 багц сэдэв, 3, 4 дүгээр ангид 18 багц сэдэв, 5, 6 дугаар ангид 22 багц сэдэв (Ёс зүйн хичээлийн агуулгыг орчуулан хавсаргав) үзэхээр ангилан тусгасан байна. Энд өгүүлж буй ерөнхий 4 хэсэг агуулга нь өөр хоорондоо гүн холбоотой, бие хүн, нийгмийн биеэ даасан гишүүн болохын хувьд, 1.-д дурдаж буй агуулгад өөрөөр хэлбэл өөрийн биед хамаарах зүйлсийг сурч эзэмшсэний үндсэн дээр бусад 3 хэсэгт хамаарах ёс суртахууны мэдлэг чадварыг олж авах, түүнээсээ 1-ийн агуулга буюу өөрийн биед хамаарах мэдлэг чадварт буцаж уялдах гэсэн тасралтгүй цикл үйл явцаар хүний ёс суртахууны харьцааны үйл явц үргэлжилж хэрэгждэг гэдэг ойлголтод тулгуурладаг байна. Мөн 2.-т дурдаж буй агуулгаар олж авсан хүмүүжлийн үндсэн дээр 4.-д дурдагдаж буй агуулгад хамаарах ёс суртахууныг олж авдаг. Улмаар 1. болон 2.-т дурдагдаж буй сэдвийн дагуу сурагчид өөрийгөө гүнзгий ойлгож чадвал, 3.-т дурдагдсан агуулгыг улам гүнзгийрүүлж эзэмшиж чаддаг. Улмаар 3.-т дурдсан агуулгыг эзэмшиж чадсаны үндсэн дээр 4.-ийн агуулга бие хүнд улам гүнзгийрэн сууж өгөх боломж бүрддэг<sup>4</sup> хэмээн үзэж сургалтыг хэрэгжүүлж иржээ.

Дээрх залгамж хамаарлыг анги тус бүрийн шатанд нарийн авч үзсэний үндсэн дээр Ёс зүйн мэдлэг олгох асуудлыг сургуулийн бүх үйл ажиллагаатай уялдуулж удирдан явуулдаг, өөрөөр хэлбэл анги тус бүрийн үе шат, тухайлан бага сургуулиас, дунд сургуульд, дунд сургуулиас ахлах сургуульд гэсэн үе шатанд дээрх ерөнхий 4 хэсэг агуулга нарийн уялдаа, залгамж холбоотой, ахиц дэвшилтэй, гүнзгийрсэн чиглэлтэй, нэгдмэл цогц агуулгатай байж хувь хүний ёс

<sup>3</sup> 小学校学習指導要領（平成 29 年告示）“Бага сургуулийн сургалтын хөтөлбөр Хэйсэйн 29 он” [mext.go.jp/component/a\\_menu/education/micro\\_detail/\\_icsFiles/afieldfile/2018/09/05/1384661\\_4\\_3\\_2.pdf](http://mext.go.jp/component/a_menu/education/micro_detail/_icsFiles/afieldfile/2018/09/05/1384661_4_3_2.pdf) 165-172-р тал

<sup>4</sup> 小学校学習指導要領解説 道徳編（Бага сургуулийн сургалтын удирдамж, тайлбар, Ёс зүйн хичээл） [edu.city.suzuka.mie.jp/shido/cos/el120\\_moral.pdf](http://edu.city.suzuka.mie.jp/shido/cos/el120_moral.pdf)

суртахууны суурь үндсийг бүрдүүлдэг учир энд онцгой анхаарал ач холбогдол өгч хандаж иржээ.

Шинэчлэгдсэн хөтөлбөрийн өмнө хэрэгжиж байсан удирдамжид ч ёс суртахууны хүмүүжил олгох зорилтыг “Хүнийг хүндэтгэх сэтгэл зүйтэй, гэр бүл, сургууль, нийгмийн бодит амьдралын бүх хүрээнд амь амьдралыг эрхэмлэн дээдлэх үзэл бодлоор ханддаг, сэтгэл санаагаар баян, өөрийн өвөрмөц соёлыг бүтээн байгуулахад болон ардчилсан нийгэм, төр улсын хөгжлийн төлөө хүчин зүтгэдэг, улмаар олон улсын энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж чадах бие даасан япон иргэнийг өсгөн төлөвшүүлэхэд суурь нь болж өгөхүйц ёс суртахуунаар хүмүүжүүлэх явдлыг зорилго болгоно”<sup>5</sup> хэмээн тодорхойлсон байдаг.

Эдгээр заалтын дагуу Бага сургуулийн сургалтын үе шат бүрийн онцлогтой зохицуулан нутаг орныхоо соёл, зан заншил, ахуй амьдралыг танин мэдэх, түүнд хайр хүндэтгэлтэй хандах, сайн болон саар зүйлийг ялгаж салгаж чаддаг болох, Япон хүн болж төрсний учир утга, Япон Улсын иргэн байхын бахархал, амьдралын баяр баяслыг мэдэрдэг, амь амьдралын үнэ цэнэ, үнэт зүйлийг ойлгодог болох, байгаль болон ариун дагшин зүйлийг эрхэмлэн хүндэлж биширдэг болох зэрэгт чиглэсэн агуулгаас эхлээд цааш улам гүнзгийрэх, өргөжих агуулгаар сургалтыг хэрэгжүүлж иржээ.

Японы бага, дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт ёс зүйн хичээлийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хүүхдийн нас бие, оюун санааны өсөлтийн онцлогт тааруулан сургалт явуулах, сургуульд олсон мэдлэгийг насан туршийн дадал хэвшил болгож суулгах, хувь хүний ёс суртахуун бүрэлдэн төлөвшихөд сургууль, багш, гэр бүл, орон нутаг, нийгэм хэрхэн нөлөөлж, ямар үүрэг гүйцэтгэх зэргийг тусгаж, асуудлыг бүхэл цогцоор нь авч үздэг, түүний агуулгыг сургалтын хөтөлбөрт нарийвчлан тусгасан байдаг.

Японы Боловсролын яамнаас баталж, сургуулиудад хэрэгжүүлж буй сургалтын удирдамжийн ёс зүйн хичээлийн агуулга нь, залуу үеийн боловсролын талаар үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий Боловсролын төв Зөвлөл (中央教育審議会), Японы боловсрол судлалын нийгэмлэг (日本教育学会), Засгийн газрын

---

<sup>5</sup> 小学校学習指導要領 道徳編『史料 道徳教育を考える』(“Бага сургуулийн сургалтын хөтөлбөр Ёс зүйн хичээл “Түүхийн материал, Ёс зүйн боловсролын тухай эрэгцүүлэх нь”) 改訂版、北樹出版、2008.10, p.116

хүүхэд залуучуудын асуудал эрхлэх Зөвлөл ( 青少年問題審議会 ) зэрэг байгууллагуудын зөвлөмж, саналд тулгуурлан тогтоогддог бөгөөд тухайн үеийн хүүхэд, залуу үеийн ахуй байдал, аж амьдралд үүсч буй асуудлууд, улмаар нийгэмд тулгарч буй асуудлын нарийн судалгаанд үндэслэж, цаашдын чиг хандлагыг тусгасан байдаг.

1990-ээд оноос Японд сургууль дээр хүүхэд бие биеэ шоглох дэглэх явдал, хүүхэд залуусын дундах гэмт хэрэг, насанд хүрээгүй хүүхдийн амиа хорлох явдал, оюун санааны доройтол, амьдралаас уйдах, эцэг эх багшаас хүсэн хүлээсэн итгэл найдлага нь хөсөрдөх, өөрийгөө нээж чадаагүйгээс үүдэлтэй элдэв асуудал хурцдах хандлага илэрч, түүнтэй холбогдон ёс суртахууны боловсролын үүрэг зорилгын асуудал хөндөгдөн яригдах болсон юм.

Засгийн газрын “Залуу үеийн асуудал эрхлэх Зөвлөл”-өөс гаргасан “Залуучуудын бие даах чадвар болон насанд хүрэгсдийн нийгмийн хариуцлага” сэдэвт Зөвлөмжид зүй бус хэрэгт холбогдож буй хүүхдийн сэтгэхүйн онцлогийг

1. Нийгмийн хэв журмыг хүндэтгэн дагаж мөрдөх ухамсар дутмаг
2. Амин хувиа хичээх үзэлтэй, сайн мууг ялгаж салгах талаар дутагдалтай, хувийн хүсэл бодол, үйл ажиллагааг хянах чадвараар хомс
3. Асуудлыг яриа хэлэлцээгээр шийдвэрлэх чадвар хангалтгүй
4. Өөрийн үнэ цэнийг ойлгох, өөрийгөө хүндэтгэх ухамсар суугаагүй байгаа зэрэгтэй холбон үзжээ.

Уг зөвлөмжид хүүхэд, залуу үе, гэр бүлийн амьдралд сүүлийн үед гарч буй өөрчлөлтийн талаарх судалгааны үр дүнг дурдаж, эцэг эхчүүд ч, хүүхдүүд ч компьютер дээр ажиллах, телевиз үзэхэд хамаг цагаа зарцуулж, хоорондын яриа гар утсаар дамжих болж, нэг ёсны хоорондоо шууд харьцаагүй салангид тусдаа байх нь өдөр тутмын хэвийн амьдрал мэт ойлгогдох боллоо. Орчин үеийн хүүхдүүдийн үнэт зүйлийг ойлгох ойлголт өөрчлөгдөж, нийгэмших үйл явц болон өөртөө шаардлага тавих зэрэг тал орхигдож, хүүхдүүд цугтаа тоглох, байгальтай харьцах явцад олж авч байсан хүмүүжлийн хүчин зүйлс үгүй болсоор байна. Хамт олны дотор орох үе зөвхөн сургууль, дамжаагаар хязгаарлагдаж, орон нутгийн нийгмээс тусгаарлагдсан байдал нь тэндээс суралцаж болох олон зүйлийг сурах бололцоогүй болгож байна. Мөн сайн мууг ялгаж салгах, бусдын зовлон жаргал, санаа бодлыг зөв ойлгох чадвар зэрэг бусадтай харьцах харьцаан дундаас олж авах боломжтой хүчин зүйлийн нөлөө улам хумигдаж байгаа зэргийг тогтоожээ.

Одоо Японд ёс суртахууны сургалтад нийгмийн амьдралд гарч буй өөрчлөлт, улс нийгмийн хөгжлийн ирээдүйн чиг хандлагыг оновчтой тусгахыг чухалчилж байна. Тухайлбал хүн амын насжилт улам нэмэгдэж, төрөлтийн тоо цөөрч байгаагаас үүдсэн нийгмийн томоохон асуудлууд тулгарч байна. Асаргаа сувилгаа шаардах өндөр настны тоо нэмэгдэж, газар тариалан, үйлчилгээний болон бусад салбарт ажиллах хүчний дутагдал бий болоод байна. Японы Хууль зүйн яамнаас “Хөдөлмөрийн ур чадварын дадлага олгох” статусаар гадаадын ажиллах хүчнийг оруулж, хөдөлмөрийн зах зээл дэх дутагдлыг нөхөх чиг бодлого барьж байна. Ийм нөхцөлд гадаадаас ирж хөдөлмөр эрхлэх иргэдийн тоо олширч, тэдний гэр бүл, хүүхдүүд Японд сурч амьдрах шаардлагын улмаас бага, дунд сургууль олон улсын шинжтэй болох үйл явц нэгэнт эхэлж, хэл, соёл, шашны олон янз байдал бага дунд сургуулийн орчинд ч бий боллоо. Эдгээр бодит байдалд ул суурьтай хандаж, бага, дунд сургуулийн ёс зүйн хичээлийн агуулга хэлбэрийг шинээр авч үзэх шаардлага тулгарч байгааг ч дээрх байгууллагууд санал болгож иржээ.

Япон Улсад урт удаан хугацааны турш тогтвортой хэрэгжиж, эдийн засаг, нийгмийн үсрэнгүй хөгжлийг бүтээн байгуулагч хүч- япон иргэдийг сурган хүмүүжүүлж, төлөвшүүлж ирсэн боловсролын бүхэл тогтолцоон дундаас Ёс зүйн сургалтын туршлагын зарим хэсгийг сонгон товч танилцууллаа.

Манай улсад боловсролын тогтолцооны шинэчлэл хэрэгжүүлэх, сургалтын хөтөлбөр, агуулгыг улам боловсронгуй болгох, ёс зүйтэй, бүтээлч ажилсаг залуу үеийг өсгөн хүмүүжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд, өнөөгийн нөхцөлд Япон улсын боловсролын бодлого, Ёс зүйн сургалтын агуулга, арга туршлагыг судлах, авах гээхийн ухаанаар хандаж, түүнээс суралцах нь ач холбогдолтой байх болно гэдэг үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Япон улсын боловсролын бодлогод түүний дотор бага, дунд боловсролын бодлогод хүүхдэд мэдлэг олгох, зөв хүн болгон төлөвшүүлэх хоёр асуудал эн тэнцүү тавигдаж хэрэгждэг туршлагыг сайтар судлан, өнөөгийн нөхцөлд манай улсад авч хэрэглэж болохоор зохистой туршлагаас оновчтой сонгон авч хэрэгжүүлбэл манай хүүхэд залууст ёс суртахууны зөв төлөвшил олгоход үр дүнгээ өгнө хэмээн найдаж байна.
2. Японд нийгмийн гишүүн хувь хүнийг өсгөн төлөвшүүлэх үндэс суурийг ёс зүйн хичээлээр олгохоор бүх ангид цаг тогтоодог. Энэ хичээлийг орчин үеийн боловсролын тогтолцоо үүссэн тэр цагаас, өөрөөр хэлбэл 140 гаруй



жилийн турш тогтвортой байлгах бодлого барьж, гэр бүл, сургууль, нийгмийн орчинг нэгдмэл байдлаар тусгаж, эцэг эх, сургууль, орон нутгийн холбоог чухалчлан авч үзэж иржээ. Ингэхдээ хүүхдийг сургуулийн орчинд орсон цагаас нь 1. өөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалдаа анхаардаг, эрүүл саруул иргэн байхын чухлыг ойлгуулж, нягт нямбай, ажилсаг, шулуун шударга, хүсэл тэмүүлэлтэй, нээлттэй зан чанарыг эрхэмлэн үздэг болгохын зэрэгцээ, 2. Бусадтай хэрхэн харьцах, 3. Байгаль дэлхий, ариун дагшин зүйлтэй хэрхэн харьцах, 4. Хамт олон, нийгэмтэй хэрхэн харьцах гэх мэтээр хувь хүн, байгаль, нийгмийн амьдралын бүхий л хүрээг орхигдуулалгүй авч үзэж, ёс суртахууны ойлголтыг энгийнээс улам өргөн хүрээнд гүнзгий рүү шилжүүлж, цогц байдлаар эзэмшүүлэх бодлогыг хэрэгжүүлдэг аж. Хичээлийн хөтөлбөр боловсруулахаас эхлээд заах аргын талаар, хичээлийн хэлбэр, сургалтын материал, бусад хичээлүүдтэй холбогдох уялдаа холбоо, эцэг эх, орон нутгийн хүчин зүйл, хамтын ажиллагаа, тусламж дэмжлэгийг авах зэрэг сургалтын хөтөлбөр тусгай зүйлээр нарийвчлан зааж өгдөг аж. Түүнчлэн эх орныхоо соёл, уламжлалд элэгсэг дотно хандах, эх орноо хайрлахын чухлыг, мөн орчин үеийн дэлхий дахины хөгжлийн чиг хандлагад зохицон гадаад хүн, гадаадын соёл, дэлхий дахины олон янз байдлыг сонирхох, хүндэтгэлтэй хандаж сурах асуудлыг Ёс зүйн хичээлээр хамруулан үзэж байгаа зэрэг нь ч манай улсын бага дунд сургуулийн Ёс зүйн хичээлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажилд тусган авч ашиглавал үр дүнгээ өгөх болов уу.

3. Ёс зүйн сургалтын үйл ажиллагаанд гэр бүл, сургууль, нийгмийн хөгжлийн хандлагын талаарх нарийн судалгааг иш үндэс болгодог, өөрөөр хэлбэл улс орны хөгжлийн стратеги, цаашдын төлөв байдлыг нухацтай харгалзан, тусгаж хэрэгжүүлдэг юм байна. Бага дунд ахлах сургууль дахь сургалтын энэ үйл ажиллагаа нь дараагийн шатны сургуулиар дамжин, улмаар жижиг дунд, том үйлдвэр компани дахь хөдөлмөр зохион байгуулалт, бүх төрлийн хууль журам, япон маягийн менежмент, энэ бүхэнтэй уялдан холбогдож, улс орны нийгэм соёлын бүтээн байгуулалтад очиж үр дүнгээ өгдөг бүхэл цикл маш нарийн тогтолцоот үйл ажиллагаа гэдэг нь ойлгомжтой. Чухам ийм бүхэл бүтэн циклийн гол асуудлыг бага дунд сургууль дээр хэрхэн уялдуулан авч үздэг туршлага нь өнөөгийн манай нөхцөлд судлан үзэж, авч ашиглах ёстой асуудал мөн гэж үзэж байна.

## **БАГА СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР<sup>6</sup>** **Ёс зүй (Хэсэгчлэн авав)**

Гуравдугаар бүлэг. **Ёс зүй**

### **I. Зорилго**

Тус хөтөлбөрийн Нэгдүгээр бүлгийн Ерөнхий зүйлийн 1-ийн 2-т дурдсан Ёс зүйн боловсролын зорилгод үндэслэн, илүү сайн сайхан амьдралд баттай суурь болж өгөх ёс суртахууны мэдлэгийг эзэмшүүлэхийн тулд, сурагчдад ёс зүйн үнэ цэнийн тухай ойлголтыг суулгасны үндсэн дээр өөрийгөө хянаж, аливаа зүйлийг олон талаас нь, олон өнцгөөс тунгаан бодох, ирээдүйн аж амьдралынхаа талаар гүн гүнзгий эрэгцүүлэн бодож сургах, ёс зүйн үүднээс дүгнэн бодох чадвар, оюун санаа, хүсэл тэмүүлэл болон биеэ авч явах чадварыг эзэмшүүлэхэд оршино.

### **II. Агуулга**

#### **1 ба 2 дугаар анги**

#### **1. Өөрийн биед хамаарах зүйлс**

- 1) Өөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарал хандуулах, эд юм, мөнгийг эрхэмлэн үзэж, эмх цэгцтэй байх, дур зоргоор авирлахгүй, зөв зүйтэй аж төрөх
- 2) Хийвэл зохих хичээл, ажлыг нягт нямбай, сайн хийдэг байх
- 3) Сайн мууг ялгаж, салгаж чаддаг, зөв зүйтэй гэж үзсэн зүйлээ идэвх чармайлттай хийх
- 4) Худал хэлэхгүй, заль мэх хэрэглэхгүй, даруу төлөв, шулуун шударгаар аж төрөх

#### **2. Бусадтай харьцах талаар**

- 1) Бусдад эерэг сайхан сэтгэл үлдээхүйц мэндчилгээ, үг яриа, үйл хөдлөл эзэмших талаар анхаарч, нээлттэй харьцах
- 2) Ойр орчимд байгаа балчир хүүхэд, өндөр настанд халуун сэтгэлээр хандаж, эелдэг харьцах
- 3) Найз нөхөдтэйгөө эвтэй найртай байж, бие биедээ туслах

---

<sup>6</sup> 小学校学習指導要領（平成 29 年告示）“Бага сургуулийн сургалтын хөтөлбөр Хэйсэйн 29 он”  
[mext.go.jp/component/a\\_menu/education/micro\\_detail/\\_icsFiles/afieldfile/2018/09/05/1384661\\_4\\_3\\_2.pdf](http://mext.go.jp/component/a_menu/education/micro_detail/_icsFiles/afieldfile/2018/09/05/1384661_4_3_2.pdf) 165-172-р тал

- 4) Өдөр тутам дэмжиж тусалдаг хүмүүст баяр талархал илэрхийлэх
3. Байгаль дэлхий, ариун дагшин зүйлтэй харьцах талаар
  - 1) Хүн болсон заяандаа баярлаж, амь амьдралыг хүндэтгэн дээдлэх сэтгэлтэй байх
  - 2) Байгальд ойр дотно байж, амьтан, ургамалд зөв зөөлөн сэтгэлээр хандах
  - 3) Сайн сайхан зүйлийг мэдэрдэг, цэвэр ариун сэтгэлтэй байх
4. Хамт олон, нийгэмтэй харьцах талаар
  - 1) Хэлсэн тохирсоноо биелүүлж, нийтээр хэрэглэх эд зүйлд ариг гамтай, өөриймсөг хандах
  - 2) Ажиллах хөдөлмөрлөхийн үнэ цэнийг мэдэрч, бусдын тусын тулд ажиллах
  - 3) Эцэг эх, эмээ өвөөгөө хүндэтгэн хайрлаж, санаачилгаараа гэр орны ажилд туслах зэргээр гэр бүлдээ тус нэмэр болохын баяр бахдалыг мэдрэх
  - 4) Багшийг хүндэтгэн хайрлах, сургуулийн хамт олонтой дотно сэтгэлээр харьцах, анги сургууль дээр цагийг хөгжүүн зугаатай өнгөрүүлэх
  - 5) Орон нутгийнхаа соёл, аж байдалд дотно сэтгэлээр хандаж, хайрлаж хүндэтгэх

### **3 ба 4 дүгээр анги**

1. Өөрийн биед хамаарах зүйлс
  - 1) Чадах зүйлээ өөрөө хийж сурах, аливаа зүйлийг хийхийн өмнө сайн бодох, хэм хэмжээндээ зүй зохистой амьдрах
  - 2) Зорьсон зүйлдээ шаргуу зүтгэлтэй байж хийж гүйцэтгэх
  - 3) Зөв зүйтэй хэмээн бодсон зүйлээ зоригтой хэрэгжүүлэх
  - 4) Алдаагаа хүлээж засч сурах, шударга, цайлган сэтгэлтэй байж, эрүүл чийрэг аж төрөх
  - 5) Өөрийн онцлогийг мэдэрч, сайн чанараа улам хөгжүүлэх
2. Бусадтай харьцах талаар
  - 1) Ёс жудагтай байхын чухлыг ойлгож, хүн бүхэнд тэгш, чин сэтгэлээс хандах
  - 2) Бусдад халамж анхаарал тавьж, найрсаг дотно сэтгэлээр хандах
  - 3) Найз нөхөдтэйгөө харилцан ойлголцож, бие биедээ итгэж, харилцан туслах
  - 4) Амьдралд түшиг тулгуур болсон хүмүүс, өндөр настанд хүндэтгэх, талархах сэтгэлээр хандах

3. Байгаль дэлхий, ариун дагшин зүйлтэй харьцах талаар
  - 1) Амь амьдралын үнэ цэнийг ухааран дээдэлж, амьд бүхнийг эрхэмлэн үзэх
  - 2) Байгалийн сайхан, түүний гайхамшигт бишрэлтэйгээр хандаж, байгаль, амьтан, ургамлыг эрхэмлэн үзэх
  - 3) Гоё сайхан, эрхэмсэг зүйлийг баярлан дэмжих сэтгэлтэй байх
4. Хамт олон, нийгэмтэй харьцах талаар
  - 1) Амласандаа хүрдэг, нийгмийн дэг журмыг сахидаг, нийтэч, хамт олонч сэтгэлтэй байх
  - 2) Ажил хөдөлмөрийн чухлыг мэдэрч, бусдын төлөө идэвх санаачилгатай ажиллах
  - 3) Эцэг эх, эмээ өвөөгөө хүндэтгэн хайрлаж, гэр бүлээрээ эв эетэй хамтран ажиллаж, сайн сайхан өрх гэрийг бүтээн бий болгох
  - 4) Багш сургуулийн хамт олноо хүндэтгэн хайрлаж, бүгдээр хамтран ажиллаж, бие биеэ дэмжин тусалж, сайхан анги хамт олныг бий болгох
  - 5) Нутаг орныхоо соёл, уламжлалыг дээдэлж, нутаг орноо хайрлах сэтгэлтэй байх
  - 6) Өөрийн эх орны соёл, уламжлалд элэгсэг дотно хандаж, эх орноо хайрлахын зэрэгцээ гадаад хүн, гадаадын соёлыг сонирхдог байх

### **5 ба 6 дугаар анги**

1. Өөрийн биед хамаарах зүйлс
  - 1) Аж амьдралд тогтож хэвшсэн зан заншлын эрхэм чухлыг ухаарч, өнгөрүүлсэн амьдралаа ямагт санаж, журам дүрмийг баримтлан, хэм хэмжээтэй байхад анхаарах
  - 2) Улам өндөр зорилт тавьж, хүсэл тэмүүлэлтэй, зоригтой, шантралгүй хичээн ажиллах
  - 3) Эрх чөлөөг эрхэмлэж, бие даан, хариуцлагыг ухаарч үйл ажиллагаа явуулах
  - 4) Үнэнч шударга, нээлттэй байж, хөгжүүн зугаатай аж төрөх
  - 5) Үнэнийг эрхэмлэж, шинийг эрэлхийлж, аж амьдралаа улам дээшлүүлэх талаар идэвх санаачилгатай байх
  - 6) Өөрийнхөө онцлогийг мэдэрч, дутагдлаа засч, ололттой сайн талаа бататгах талаар идэвх зүтгэл гаргах
2. Бусадтай харьцах талаар

- 1) Хэзээ, хаана байгаагаа бодолцон, дэг жаягийг барьж, чин сэтгэлээр хандах
- 2) Хүн бүхэнд адил тэгшээр халамж анхаарал тавьж, бусдыг ойлгож эелдэг дотноор харилцах
- 3) Харилцан итгэлцэж, бие биеэс суралцан, найз нөхдийн холбоогоо бататган, хөвгүүд охид эв найртай байж, бие биедээ туслах
- 4) Даруу төлөв, уужим сэтгэлтэй байж, бусдын санал, байр суурийг хүндэтгэх
- 5) Өдөр тутмын амьдрал хүмүүсийн харилцан түшиг тулгуур, тус дэм дээр тогтдог гэдгийг ухаарч ойлгох, бие биеэ тусалж дэмжих

### 3. Байгаль дэлхий, ариун дагшин зүйлтэй харьцах талаар

- 1) Амь нас юугаар ч сольшгүй зүйл мөн болохыг ухаарч, өөрийн болон бусдын амь насыг хүндэтгэн эрхэмлэх
- 2) Байгалийн агуу мөн чанарыг ойлгож, байгаль орчныг эрхэмлэн үзэх
- 3) Гоё сайхан зүйлийг баярлан дэмжих сэтгэлтэй байж, хүний хүчин чадлаас давсан зүйлийг бишрэн хүндэтгэж сурах

### 4. Хамт олон, нийгэмтэй харьцах талаар

- 1) Нийтийн төлөө сэтгэлтэй байж, хууль журмыг биелүүлэн, өөрийн болон бусдын эрхийг хүндэтгэн үзэж, өөрийн үүргийг биелүүлэх талаар идэвхи санаачилгатай байх
- 2) Бусадтай харьцахдаа хэнийг ч үл ялгаварлах, туйлшралгүй, шударга, тэгш хандах, зөв ёс суртахуунтай байхад анхаарах
- 4) Ойр байгаа хамт олны дотор орж, өөрийн үүргээ ухамсарлан, хамтран ажиллаж, хариуцсан ажлаа эзний ёсоор гүйцэтгэх
- 5) Ажиллаж хөдөлмөрлөхийн утга учрыг ухааран, нийгэмд үйлчлэхийн баяр жаргалыг ойлгож, нийгэмд тус нэмэртэй үйл хийх
- 6) Эцэг эх, өвөө эмээгээ хүндэтгэн хайрлаж, гэр бүлийнхээ аз жаргалын төлөө сэтгэл гарган, санаачилгаараа тус дэм үзүүлэх
- 7) Багш, сургуулийн хамт олонд гүн хүндэтгэлтэй хандах, нийтээрээ харилцан туслалцаж, хамтран ажиллаж, сургуулийн ахуй орчинг улам сайн сайхан болгох

- 8) Төрөлх нутаг, эх орныхоо соёл, уламжлалыг эрхэмлэн, өмнөх үеийнхний зүтгэл чармайлтыг танин мэдэж, төрөлх нутаг, эх орноо хайрлах сэтгэлтэй байх
- 9) Гадаадын хүн, соёлыг эрхэмлэн хүндэтгэж, япон хүний нэр төрийг өргөж, дэлхийн хүмүүстэй найрамдалтай харилцах

### **III. Хичээлийн төлөвлөгөө боловсруулах, анги тус бүрийн хичээлийн агуулгыг тогтоох тухайд**

1. Сургууль тус бүр Ёс зүйн боловсролын ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлан, өөрийн сургуулийн бүх хичээл, гадаад хэл дээр явагдах үйл ажиллагаа, ерөнхий сургалтын цаг болон тусгай үйл ажиллагааны уялдаа холбоог харгалзан үзсэний үндсэн дээр, ёс зүйн хичээлийн бүтэн жилийн төлөвлөгөөг боловсруулна. Жилийн төлөвлөгөөг боловсруулахад, II хэсэгт дурдсан анги тус бүрийн үе шатанд үзэх ёстой агуулгыг, тухайн хичээлийн жилд бүрэн багтаасан байх хэрэгтэй. Ингэхдээ, хүүхэд болон тухайн сургуулийн бодит байдалд нийцүүлэн, 2 хичээлийн жилээр баримжаалж, ач холбогдол өгөх дарааллаар аль сэдвийг хэдэн цаг үзэхийг тогтоон, нэг сэдвийг хэд хэдэн цагаар заах зэрэг зохицуулалт хийх боломжтой.

2. II хэсэгт дурдсан агуулгыг заахад дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.  
Үүнд

- 1) Сургуулийн захирал болон хичээлийн эрхлэгчийн оролцоо, бусад хичээлийн багш нартай хамтран ажиллах арга хэлбэрийг тооцон үзэж, Ёс зүйн хичээлийн багшийн үйл ажиллагаанд төвлөрсөн байхаар бодож, сургалтын тогтолцоог улам боловсронгуй болгож ажиллах
- 2) Ёс зүйн хичээл нь сургууль дээр явагдах сургалтын бүх үйл ажиллагаагаар дамжин хэрэгжиж буй ёс зүйн боловсрол олгох үйл явцын зангилаа цэгийн үүргийг гүйцэтгэх байр сууринд байхуйц хэмжээнд, төлөвлөгөөтэй, ахиц дэвшилтэйгээр хичээл сургалтыг хэрэгжүүлэх шаардлагатай. Ялангуяа бусад хичээлүүд, гадаад хэл дээрх үйл ажиллагаа, ерөнхий хичээлийн цаг болон тусгай үйл ажиллагааны цагаар хэрэгжүүлэх боломж муутай хичээлийн сэдэвт гол ач холбогдлыг өгч сургалтыг явуулах, сурагчид болон сургуулийн бодит байдалд зохицуулж, хичээлийг гүнзгийрүүлэх, хичээлийн агуулгын

уялдаа холбоог нарийн бодолцож, сургалтыг ахиц дэвшилтэй байдлаар явуулах зэрэгт анхаарах.

- 3) Сурагчид ёс зүйн боловсрол эзэмших явцад, өөрөө өөртөө дүгнэлт хийж, өсөлт хөгжлөө ойлгож мэдрэх, цаашдын зорилго, зорилтоо олж харах боломжийг бүрдүүлэхэд анхаарах.. Ингэхдээ, ёс зүйтэй иргэн болохын ач холбогдлыг сурагчид өөрсдөө бодох, ухаарч ойлгох, хичээл сургалтад эзний ёсоор идэвхтэй оролцдог байх нөхцлийг бий болгох
- 4) Хүүхэд янз янзаар мэдэрч, янз янзаар бодож сэтгэх явцаар дамжуулж, өөрийн бодол эрэгцүүллийг гүнзгийрүүлэх, дүгнэлт шийдвэр гаргах, өөрийгөө илэрхийлэх чадвар суулгах, өөрийн бодол эрэгцүүлэл дээр тулгуурлан, ярилцах, бичих зэрэг хэл ярианы чадварыг дээшлүүлэх
- 5) Хүүхдийн хөгжлийн үе шат болон онцлогт зохицуулан сургалтыг хэрэгжүүлж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх болон ёс зүйн үйл ажиллагаатай холбоотой дадлагын хэлбэрийн хичээл сургалтыг явуулах зэрэг заах аргын хэлбэрт анхаарах. Ингэхдээ тэдгээр үйл ажиллагааны явцад өмнө үзсэн хичээлийн ач холбогдлыг бодож үзэх боломжийг бий болгох. Түүнчилэн тусгай үйл ажиллагааны үеийн төрөл бүрийн практик арга хэмжээн дээр ёс зүйн хичээлд үзсэн агуулгыг турших, ашиглах хэлбэр ч байх боломжтой.
- 6) Хүүхдийн хөгжлийн үе шат болон онцлогт зохицуулан II хэсэгт заасан агуулгад нийцүүлэн мэдээллийн ёс зүйн талаарх сургалтыг улам боловсронгуй болгох. Мөн хүүхдийн хөгжлийн үе шат болон онцлогт тохируулан, жишээ нь нийгмийн тогтвортой хөгжилд тулгамдаж буй өнөөгийн асуудлыг авч үзэх талаар анхаарал хандуулж, ойр тойронд тулгамдаж буй асуудал хүүхдүүдтэй хэрхэн холбогдох тухай хөндөн үзэж, тэдгээрийг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзлэл төрүүлэх. Гэхдээ олон янзын үзэл бодлоор хандах боломжтой асуудлын тухайд зөвхөн нэг талыг барьсан үзэл бодлын байр сууринаас хандаж хичээлийг явуулж болохгүй гэдгийг анхаарах
- 7) Ёс зүйн хичээлийг нээлттэй хэлбэрээр явуулж, хичээлийн дадлага, бүс нутгийн хэрэглэгдэхүүнийг нээж олох, ашиглахад гэр бүл, орон нутгийн оршин суугчид болон салбар тус бүрийн мэргэжлийн хүмүүсийн идэвхтэй оролцоо, тусламж дэмжлэгийг хүлээх зэргээр гэр бүл, орон нутгийнхантай нийтлэг ойлголттой байж, харилцаа холбоотой ажиллах

3. Хичээл сургалтын материалын тухайд дараах зүйлийг анхаарвал зохино.

1) Хүүхдийн өсөлт хөгжлийн үе шат, онцлог, бүс нутгийн бодит нөхцөл байдлыг харгалзан төрөл бүрийн хэрэглэгдэхүүн ашиглахад анхаарал хандуулах. Ялангуяа амь амьдралын үнэ цэнэ, байгаль дэлхий, уламжлал соёл, өвөг дээдсийн тухай домог хууч, спорт, төрөл бүрийн мэдээлэлд хандах зэрэг сэдвээр сурагчдад тодорхой ойлголт өгч асуудлыг дэвшүүлэн, олон талаас нь бодуулах, сэтгэгдэл төрүүлэхүйц төгс төгөлдөр хэрэглэгдэхүүнийг нээж олох, ашиглахад анхаарах

2) Сургалтын материалын тухайд, Боловсролын суурь хууль, Сургуулийн боловсролын хууль болон бусад хууль дүрмийн шаардлагыг хангасан, дараах болзолд нийцсэн хэмээн үзэхүйц материал байх. Үүнд

А. Хүүхдийн өсөлт хөгжлийн шатанд таарсан, тухайн хичээлийн зорилтыг биелүүлэхэд зохистой материал байх

Б. Хүнийг хүндэтгэх үзэл санаанд нийцсэн материал байх бөгөөд зовлон гуниг зэрэг сэтгэлийн хөдөлгөөн, хүмүүсийн хоорондын харилцааг ойлгох зэрэг асуудлыг оролцуулаад хүүхэд гүнзгийгээр бодох, хувь хүний хувьд илүү сайхан амьдрах баяр бахдал, зориг эрмэлзлэл төрүүлэхүйц материал байх

В. Олон янзын үзэл бодлоор хандах боломжтой асуудлын тухайд зөвхөн нэг талыг барьсан үзэл бодлын байр сууринаас хандаж хичээлийг явуулж болохгүй гэдгийг анхаарах

4. Хичээл сургалтын явц болон сурагчдын ёс суртахууны өсөлт хөгжил байдалд байнга ажиглалт тавьж, үр дүнг хичээл сургалтын үйл ажиллагаанд зохистойгоор ашиглахад анхаарах. Харин Ёс зүйн хичээлийн цаг дээр тоон үнэлэлт дүгнэлтийг хэрэглэхгүй.

5. Ёс зүйн сургалтын тухайд анхаарах зүйлс<sup>7</sup>

---

<sup>7</sup> 小学校学習指導要領（平成 29 年告示）“Бага сургуулийн сургалтын хөтөлбөр Хэйсэйн 29 он”  
next.go.jp/component/a\_menu/education/micro\_detail/\_icsFiles/afieldfile/2018/09/05/1384661\_4\_3\_2.pdf  
165-172-р тал



Ёс зүйн боловсролын сургалт хэрэгжүүлэхэд, ёс зүйн боловсролын онцлогийг харгалзан, бүх хичээлийн сургалтад анхаарах нийтлэг зүйлсээс гадна, дараах зүйлийг анхаарна.

1. Сургууль тус бүрд энэхүү хөтөлбөрийн 1-ийн 2-т тодорхойлсон сургалтын зорилгыг харгалзан, ёс зүйн боловсролын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, захирлын удирдлагын дор Ёс зүйн хичээлийг заах багшаар голлон, бүх багш нар хамтран ажиллаж, ёс зүйн боловсрол олгох ажлыг хэрэгжүүлнэ. Ёс зүйн боловсролын ерөнхий төлөвлөгөө боловсруулахад, хүүхэд, сургууль, орон нутгийн бодит байдлыг харгалзан, уг сургуульд хэрэгжүүлэх ёс зүйн сургалтын гол зорилгыг тодорхойлохын хамт, ёс зүйн хичээлийг удирдан явуулах бодлого, энэ хөтөлбөрийн 3 дугаар бүлэг Тусгай хичээл Ёс зүйн 2-т заасан агуулгатай уялдах хичээлүүд, гадаад хэлээрх үйл ажиллагаа, ерөнхий сургалтын цаг, гэр бүл, орон нутгийн нийгэмтэй хэрхэн хамтран ажиллах аргыг тогтооно.
2. Сургууль тус бүрд, сурагчдын хөгжлийн үе шат, онцлогийг тооцон үзэж, хичээлийн агуулгаас алинд нь голлон ач холбогдол өгөхийг төлөвлөнө. Ингэхдээ хичээлийн жил тус бүрийн шатанд хүүхдийн бие даасан сэтгэлгээ, биеэ авч явах байдал, амь амьдралыг эрхэмлэх сэтгэл, бусдыг халамжлах сэтгэлийг төлөвшүүлэхэд анхаарна. Мөн хичээлийн жил тус бүрийн шатанд дараах зүйлсэд анхаарал хандуулж ажиллах
  - 1) 1 ба 2 дугаар ангид мэндчилгээ зэрэг ахуй амьдралын үндсэн хэв заншлыг эзэмшүүлэх, сайн мууг ялгаж салгаж, хийж болохгүй зүйлийг хийхгүй байх, нийгмийн амьдралыг журам дүрмийг баримтлах хүмүүжлийг олгох
  - 2) 3 ба 4 дүгээр ангид сайн мууг ялгаж салгаж чадах, зөв гэж бодсон зүйлээ хийх, ойр тойрны хүмүүстэй хамтран ажиллаж, бие биедээ туслах, хамт олон, нийгмийн журам дүрмийг баримтлах ёсзүйг суулгах
  - 3) 5 ба 6 дугаар ангид бусдын бодол санаа, байр суурийг ойлгож, бие биеэ дэмжих, хууль журмын учир холбогдлыг ойлгож сахиж мөрдөх, хамт олныг бэхжүүлэхэд хүчин зүтгэх, соёл уламжлалыг хүндэтгэн үзэж, түүнийг бий болгон хөгжүүлж ирсэн эх орон, төрөлх нутгаа хайрлах, мөн бусад улс оронд хүндэтгэлтэй хандах
3. Сургуулийн болон ангийн хамт олны харилцаа, ахуй орчинг бүрэлдүүлэхийн хамт, анги хамт олноороо хоногоор явах үйл ажиллагаа,

сайн дурын үйл ажиллагаа, байгальтай танилцах, бүс нутгийн үйл амьдралд оролцох зэрэг биеэр оролцох олон талт үйл ажиллагааг өргөнөөр хэрэгжүүлэх. Мөн ёс зүйн хичээлийн агуулга хүүхдийн өдөр тутмын амьдралд хэрэгждэг байх. Эдгээр үйл ажиллагааны үед хүүхэд бие биеэ шоглохоос урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах талаар анхаарах

4. Сургуулийн ёс зүйн сургалтын ерөнхий төлөвлөгөө болон ёс зүйн боловсролтой холбоотой үйл ажиллагааны мэдээллийг идэвхтэйгээр ил тод болгож, ёс зүйн сургалтыг улам боловсронгуй болгохын тулд гэр бүл, орон нутгийн иргэд оролцоо, дэмжлэгийг авах зэргээр гэр бүл, орон нутгийн байгууллага иргэдтэй нийтлэг ойлголттой байж, нягт хамтран ажиллах

# ЯПОН УЛСЫН НОГООН ХӨГЖЛИЙН ТУРШЛАГА, СУРГАМЖ

(Бодлогын зөвлөмж)

Доктор (Sc.D) Ц.Баатар,  
доктор (Ph.D) Б.Сэржав,  
ЭШДэА, докторант У.Загдцэсэм,  
ЭШДэА, магистр А.Сосорбурам

## Агуулга

1. Япон Улсын хөгжлийн бодлого: Аж үйлдвэржилт
2. Япон Улсын бүс нутгийг хөгжүүлэх бодлого, хот төлөвлөлт
3. Японы хог хаягдлын менежмент
4. Японы байгаль, экологийн боловсролын туршлага
5. Дүгнэлт, санал

Япон Улсад эдийн засаг, нийгмийн хөгжлийг байгаль орчны тогтвортой байдалтай тэнцвэртэй авч үзэж ирсэн туршлагыг эдийн засгийн хөгжлийн үе шатуудад хэрэгжүүлсэн аж үйлдвэржүүлэх бодлого болон бүс нутгийн хөгжлийн бодлого, хот төлөвлөлт, ногоон инновацийн чиг хандлага, хог хаягдлын менежмент, байгаль экологийн боловсролын бодлогын талаар товч танилцуулж, манай улсын хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх, эдийн засгийг хөгжүүлэх, ард түмний аж амьдралыг дээшлүүлэхэд тусган авч хэрэглэж болох туршлагын талаар тодорхой саналыг дэвшүүлэхийг зорив.

### **1. Япон Улсын хөгжлийн бодлого: Аж үйлдвэржилт**

Дайны дараа Японы эдийн засаг богино хугацаанд гайхамшгийг үзүүлсэн гол нууц нь урт, дунд хугацааны стратегийн төлөвлөлт, эдийн засаг дахь төрийн уян хатан зохицуулалт, аж үйлдвэрийн салбарт хэрэгжүүлсэн бүтцийн өөрчлөлт, стратегийн тэргүүлэх салбарын үйлдвэрлэлд үзүүлсэн төрийн дэмжлэгт оршино. Ялангуяа, тус улсын үе үеийн засгийн газраас залгамж чанартай баримтлан хэрэгжүүлсэн экспортод чиглэсэн аж үйлдвэржилтийн бодлого нь Японы өнөөгийн хөгжлийг цогцлооход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм.

Стратегийн тэргүүлэх салбарын үйлдвэрлэл болох эрчим хүч, нүүрс, далайн тээвэр, ган, автомашин, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг тэргүүн зэрэгт хөгжүүлэх зорилт тавьж шинэ технологид тулгуурласан аж үйлдвэрийг дэмжих бодлого хэрэгжүүлэхдээ Сэргээн босголтын хөрөнгө оруулалтын сан, Японы хөгжлийн банкны үйл ажиллагааг дээрх үйлдвэрлэлд хөрөнгө оруулахад

чиглүүлжээ. Тус бодлогын хүрээнд, жишээ нь Сони компанийн транзистор хүлээн авагчийн үйлдвэрлэлд Японы хөгжлийн банкнаас санхүүгийн дэмжлэг үзүүлж, эхний 2 жил бүтээгдэхүүний татвараас чөлөөлж байв. 1951 онд Худалдаа, үйлдвэрийн яам дотоодод үйлдвэрлэх техникийн чанарыг дээшлүүлэх зорилгоор аж үйлдвэрийн машин техник, тоног төхөөрөмжийн импортод улсаас мөнгөн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгож, гадаадын шилдэг техникийн жагсаалт гарган, нэр заагдсан машин техникийг импортоор авах тохиолдолд улсаас үнийн тал хувийг нь төлөх шийдвэр гаргаж байв<sup>8</sup>.

Гэвч ийм арга хэмжээг удаан үргэлжлүүлэх нь гадаад валютын хэмнэлтэд сөрөг нөлөөтэй, мөн дотоодын үйлдвэрүүдийн технологийн түвшинд ахиц гарахгүй байх эрсдэлтэй гэдэг үүднээс Худалдаа, үйлдвэрийн яамнаас дараагийн шатны бодлогод шилжиж, аж үйлдвэрийн өндөр хүчин чадалтай машин техник, тоног төхөөрөмж зохион бүтээж, үйлдвэрлэхэд зориулан улсаас татаас олгох тогтолцоог бий болгож, гаргасан зардлын тал хувийг олгох арга хэмжээ хэрэгжүүлсэн нь Японы аж үйлдвэрийн машин техникийн үйлдвэрлэлийг шинэ шатанд хөгжүүлэхэд ихээхэн нөлөөтэй бодлого болжээ.

Дайны дараах тус улсын эдийн засгийн сэргэлт (1955 он хүртэлх)-ийг түүний дараах эрчимтэй хөгжлийн үе (1955-1973) залган авч, эдийн засгийн өсөлтийг тэргүүн зэрэгт тавих аж үйлдвэрийн бодлого, ЖДҮ-ийн бодлого дэвшигдсэнээр олон тооны хууль журам гарч хэрэгжжээ. Тухайлбал, 1950-аад оны сүүлчээр “Сүлжмэлийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн талаар тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай хууль (纖維工業設備臨時措置法)”, “Машин техникийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх тусгай арга хэмжээний тухай хууль (機械工業振興臨時措置法)”, “Электроникийн үйлдвэрлэл хөгжүүлэх тусгай арга хэмжээний тухай хууль (電子工業振興臨時措置法)”, “ЖДҮ-ийг төрөлжүүлэн хөгжүүлэх тусгай арга хэмжээний тухай хууль (中小企業業種別振興臨時法)”, “ЖДҮ-ийн шинэчлэлийг дэмжих хууль (中小企業近代化促進法)”-иуд гарсны зэрэгцээ 1963 онд “ЖДҮ-ийн суурь хууль (中小企業基本法)” баталж хэрэгжүүлсэн байна.

Тухайлбал, “Машин техникийн үйлдвэр хөгжүүлэх тусгай арга хэмжээний тухай хууль” (機械工業振興臨時措置法(機振法) 1956)-иар дайны дараах сэргээн

---

<sup>8</sup> 大川一司、小浜裕久 著『経済発展論—日本の経験と発展途上国—』東洋経済新報社、1995、p.299-300 (Оокава Казүши, Кохама Хирохиса “Эдийн засгийн хөгжлийн онол-Японы туршлага болон хөгжиж буй орнууд-” 1995 он, 299-300-р тал)

босголтоос эдийн засгийн бие даасан байдалд шилжих үед үндэсний үйлдвэрийг хөгжүүлэх, тухайлан машин техникийн үйлдвэрийн бүтцийг оновчтой болгох зорилгоор техник хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж үйлдвэрлэх зориулалт бүхий машин техникийн, ган хайлш цутгамлын, автомашины эд ангийн зэрэг нийт 45 төрлийн үйлдвэрийн тухайд тэдгээрийн бүтцийг оновчтой болгох суурь төлөвлөгөө, үйлдвэрлэлийн технологийг дээшлүүлэх стандартыг Худалдаа, үйлдвэрийн яамнаас боловсруулж, Японы хөгжлийн банк, ЖДҮ-ийн сангаас онцгой хүүтэйгээр санхүүжилт олгохоор хуульчилжээ. Ийнхүү тус хуулиар автомашины сэлбэг хэрэгсэл, суурь машины үйлдвэрлэлд онцгой анхаарах, автомашины үйлдвэрлэлийг эдийн засгийн тэргүүлэх салбарын хэмжээнд хөгжүүлэх, суурь машины үйлдвэрлэлийн зардлыг 20%-иар бууруулж, бүтээгдэхүүний хүчин чадлыг дэлхийн түвшинд хүргэхийн тулд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг төрөлжүүлэхээр заажээ. Энэ зорилтод нийцэх техник технологи, удирдлагын арга барилтай үйлдвэрийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу сонгон шалгаруулж, Японы хөгжлийн банкнаас жилдээ 6.5%-ийн хүүтэй, 10 жилийн хугацаатай зээл олгох, шаардлагатай нэмэлт техник тоног төхөөрөмж худалдан авахад зориулж гадаад валют олгох, импортыг татвараас чөлөөлөх арга хэмжээ авч явуулжээ<sup>9</sup>.

ЖДҮ-ийн бодлогын хүрээнд аж үйлдвэрийн бүтцийг дээшлүүлэхэд, мөн олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах ирээдүйтэй салбарыг сонгон шалгаруулж, тухайн салбар тус бүрийн ЖДҮ-ийн онцлогт тохируулсан шинэчлэлийн төлөвлөгөө боловсруулж, санхүүжилт, татварын бодлогоор дэмжлэг үзүүлжээ. Эдгээр арга хэмжээ нь эдийн засгийн сэргэлтийн үеийн ган, нүүрс, цахилгаан эрчим хүч, усан онгоцны болон химийн зэрэг тодорхой салбарын үйлдвэрийг хөгжүүлэхэд оновчтой алхам болжээ. 1955 онд аж үйлдвэрийн 55.3%-ийг хөнгөн аж үйлдвэрийн (хүнс, нэхмэл сүлжмэлийн үйлдвэрлэл) салбар, 44.7%-ийг (төмөрлөг, машин, химийн үйлдвэрлэл зэрэг) хүнд аж үйлдвэрийн салбар эзэлж байсан бол 1960 он гэхэд 56.4%-ийг хүнд аж үйлдвэр, 43.6%-ийг хөнгөн аж үйлдвэр эзлэх болжээ<sup>10</sup>. Энэ үеэс Японы экспортын дийлэнх хувийг машин техник эзлэх болж, аж үйлдвэрийн суурь машины болон

<sup>9</sup> 広瀬直弘 『中小企業政策』 日本経済評論社、2006、p.113 (Хиросэ Наохиро “ЖДҮ-ийн бодлого” 2006 он, 113-р тал )

<sup>10</sup> 正村公博 『戦後日本資本主義史』 東京、1984、p.161, (Масамура Кимихиро “Дайны дараах Японы капитализмын түүх” 1984 он, 161-р тал)

нарийн багаж төхөөрөмжийн үйлдвэрлэлийн технологийн төвшин хурдацтай хөгжиж эхэлжээ.

Япон Улсын Засгийн газар гадаад худалдааг чөлөөлөх, эдийн засгийг нээлттэй болгох бодлогыг 1960-аад оноос хэрэгжүүлж техникийн үйлдвэрлэлийн шинэчлэлийг оновчтой зохион байгуулснаар бодлого амжилттай хэрэгжихэд дээр дурдсан хуулиуд чухал үүрэг гүйцэтгэжээ.

Мөн Худалдаа, үйлдвэрийн яамнаас аж үйлдвэржүүлэх бодлогыг улам гүнзгийрүүлэн “Автомашин үйлдвэрлэлийн салбарт баримтлах үндсэн чиг бодлого” нэртэй бодлогын баримт бичгийг 1961 оны 5 дугаар сард гаргаж, гадаад худалдааг чөлөөлөх ажлын хүрээнд аж үйлдвэрийн бүтцийг шинээр зохион байгуулах зорилгоор олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвараар сул хэмээн үзсэн салбарууд, тухайлан суудлын автомашин, сайжруулсан ган, нефть хими гэсэн 3 салбарыг тусгайлан авч үзэх шийдвэр гаргажээ. Суудлын автомашины хувьд 1963 онд импортыг чөлөөлөхөөр төлөвлөж, өрсөлдөх чадварыг бэхжүүлэхийн тулд 1. Олон тоогоор үйлдвэрлэх групп (2 үйлдвэр), 2. Тусгай зориулалтын автомашины групп (дээд зэрэглэлийн болон спортын зориулалтын автомашины 2-3 үйлдвэр), 3. Суудлын жижиг автомашин үйлдвэрлэх групп (2-3 үйлдвэр) болгон эмхлэн зохион байгуулахаар тусгасан нь автомашины үйлдвэрийг нэгтгэн цөөлөх, энэ салбарт шинээр орж ирэх компанид хязгаарлалт хийх бодлогын шинжтэй<sup>11</sup> байжээ.

Гэсэн хэдий ч олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилготой дээрх хуулийн дагуу тухайлсан цөөн үйлдвэрийг өргөтгөж, санхүүгийн дэмжлэг төвлөрүүлэх нь шинээр зах зээлд өрсөлдөх зорилготой компанид хязгаарлалт болно хэмээн эсэргүүцэж байсан хүмүүсийн нэг нь алдарт Хонда компанийг үүсгэн байгуулагч Хонда Сооичиро байжээ. Тэрээр 1950-иад оны үед мотоциклийн үйлдвэрүүдээс Засгийн газарт хандан дотоодын зах зээлээ хамгаалж, импортод хязгаарлалт тавих хүсэлт гаргахад эсрэг санал баримталж, гадаадын сайн мотоцикл Японд орж ирэх нь харин ч японы мотоциклийн чанар дээшлэхэд түлхэц үзүүлэх тул импортыг чөлөөтэй байлгаж, тэндээс суралцах хэрэгтэй хэмээн үзэж байв. Тэгээд ч Хондагийн үйлдвэр мотоциклийн үйлдвэрлэлээ шинэ шатанд гарган хөгжүүлж чадсан төдийгүй, автомашины

---

<sup>11</sup> 「立法と調査」2009.11 No.298 (“Хууль ба судалгаа” сэтгүүл, 2009 он 11 сар, №298) [www.sangiin.go.jp](http://www.sangiin.go.jp)

үйлдвэрлэлд дэвшиж, улмаар орчны бохирдлоос сэргийлэх технологийн түвшин, далайн чанадад үйлдвэрлэл явуулах стратегиэрээ Тоёота, Ниссан зэрэг том корпорацийг ч ардаа орхиж байсан түүхтэй.

Дайны дараах аж үйлдвэржилтийн эхний үед хувийн хэвшлийнхэн дан ганц төрийн дэмжлэгийг хараад суусангүй хүнд үйлдвэрүүдэд хөрөнгө оруулах эх оронч үйлдвэр компаниуд олон байсны нэг нь гангийн үйлдвэрлэлийн Кавасаки сэйтэцү компани бөгөөд 1950-иад оны эхээр өөрийн хөрөнгөөр Сэнба-д анхны гангийн үйлдвэрээ нээсэн нь улс орныхоо хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулжээ.

Нефть химийн үйлдвэрийн салбарт ч хувийн хөрөнгө оруулалтын идэвх санаачилга засгийн газрын тооцоолж байснаас илүү өндөр байсныг Худалдаа, үйлдвэрийн яамны “Этилен 300 мянган тн-ын стандарт” бодлогын хэрэгжилт харуулжээ. Этилен нь 1960-аад онд Японы эдийн засгийн голлох салбар нефть химийн үйлдвэрийн гол түүхий эд байв. Худалдаа үйлдвэрийн яам болон Нефть химийн салбарын хамтын ажиллагааны Зөвлөлөөс тус бодлогыг 1967 онд гаргасан нь уг салбарыг хөл дээр нь баттай босгох, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг нь бэхжүүлэх зорилготой байв. Энэ стандартын шаардлагад этилений үйлдвэр байгуулах тохиолдолд үйлдвэрлэлийн хүчин чадлын хэмжээ жилд 300 мянган тн-оос дээш байх, дагалдах шинэ бүтээгдэхүүний төлөвлөгөө боловсруулсан байх, түүхий эдийн нийлүүлэлт харьяалагдах компаниас бүрэн хийгдэхээр байх, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадавх бүхий компаниудаар үйлдвэрлэлийн төвийг бүрдүүлэх зэрэг нөхцөл тусгаж байжээ. Худалдаа үйлдвэрийн яам энэ стандартыг хангах үйлдвэр хоёр гураваас хэтрэхгүй хэмээн тооцоолж байсан ч бодит байдал дээр 10 гаруй үйлдвэр энэ шаардлагыг бүрэн хангаж байжээ.

Худалдаа, үйлдвэрийн яам болон хувийн хэвшлийн компаниуд нь идэвхтэй хамтран ажиллаж, зарим үед санал зөрөлдөж байсан ч үйлдвэрүүдийн ширүүн өрсөлдөөн, оновчтой хөрөнгө оруулалтын нөхцөлд Японы аж үйлдвэрийн хөгжлийн бодлого амжилттай хэрэгжиж үр дүнд хүрчээ. Японы үйлдвэр компанийхан технологио сайжруулах, тэргүүний технологи импортлоход ихээхэн хүчин чармайлт гаргаж, гадаад худалдааг чөлөөлөхөөс өрсөж, үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөхөд анхаарч, дотоодын төдийгүй далайн чанадын үйлдвэртэй дэлхийн зах зээлд өрсөлдөх стратеги барьж ажиллажээ. Ингэж ажиллах нөхцлийг төрийн оновчтой бодлогоор шуурхай бүрдүүлж өгчээ. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндсэн дээр экспортыг хурдацтай өсгөх, алсдаа импортыг

чөлөөлөх зорилгын дор зах зээлийн нөхцөлд эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн тууштай бодлого хэрэгжүүлж, дараагийн эрчимтэй өсөлтийн үе шатны суурийг баттай тавьж ирсэн Японы хөгжлийн туршлага нь тухайн орны дотоодын зах зээлийн багтаамж, олон улсын эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарах хэдий ч хөгжиж байгаа орнуудын хувьд эдийн засгийн өсөлтөд нь чухал туршлага болох бүрэн боломжтой нь амьдрал дээр нотлогдсон юм.

Улмаар 60-аад оноос хойших эрчимтэй хөгжлийн шатанд капиталын төвлөрөлд тулгуурласан хүнд аж үйлдвэрээс технологийн төвлөрөлд тулгуурласан шинэ үеийн аж үйлдвэр бий болж бүтцийн шинэчлэл амжилттай хэрэгжсэн ажээ. 1970-аад оны дунд үе гэхэд орчин үеийн боловсруулах аж үйлдвэрийн салбарын нэмүү өртгийн өсөлтийн хувь нь эдийн засгийн өсөлтийн хувиас давсан үзүүлэлтэд хүрч, Япон улс эдийн засгийн өндөр хөгжилтэй өрнөдийн орнуудын эгнээнд баттай байр суурь эзлэх болов.

Энэ явцад эдийн засгийн эрчимтэй хөгжлийн тулгуур байж, улмаар олон улсын зах зээлд ноёлох экспортод чиглэсэн аж үйлдвэрийн газруудын шинж аажимдаа мэдээллийн технологийн хөгжил, даяаршил, нийгмийн хувирал дунд зохицон шинэчлэгдэж, шинэ чиглэлээр өөрчлөгдөж ирсэн байна. Японд томоохон супермаркетэд худалдаалж буй бараа бүтээгдэхүүн 5 жил тутамд бараг тал хувь нь цоо шинээр солигддог гэсэн яриа аль 1990-ээд онд гарсан нь японы үйлдвэрүүдийн бүтэц уян хатнаар, үлэмж хурдтайгаар хэрхэн цаг үедээ зохицон тасралтгүй өөрчлөгдөн шинэчлэгдэх чадавхтай байдгийг харуулсан баримт бөгөөд эдүгээ энэ үйл явц жилээр бус улирлаар хэмжигдэж олон улсын зах зээлд хүчтэй өрсөлдөж байна.

Ийнхүү Японы эдийн засгийн гол тулгуур, экспортын аж үйлдвэрийн хөгжлийн шинж чанар нь аж үйлдвэрийн шинэ хувьсгалын эрин үед глобальчлал, мэдээллийн технологи, дижитал эдийн засаг, аж амьдралын олон талт байдлын шинэ нөхцөлд зохицон шинэчлэгдэн өөрчлөгдсөөр байна.

## **2. Япон Улсын бүс нутгийг хөгжүүлэх бодлого, хот төлөвлөлт**

Япон Улсын эдийн засгийн хөгжлийн туршлагад улсынхаа газар нутгийг байгаль, цаг уур, газар зүйн онцлог, засаг захиргааны онцлог, нийгэм, эдийн засгийн нөөцөд нь тулгуурлан бүсчлэн хөгжүүлэх бүс нутгийн бодлогын туршлага чухал байр эзэлдэг.



Ерөнхий сайд Икэдагийн Засгийн газраас 1960 онд “Үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлэх төлөвлөгөө (所得倍増計画)” боловсруулан, 1970 он хүртэл 10 жилийн хугацаанд үндэсний орлогыг 2 дахин өсгөх, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, ард түмний аж амьдралын түвшинг дээшлүүлэх зорилт дэвшүүлжээ. Эдийн засгийн эрчимтэй хөгжлийн шат эхэлж, хотжилт түргэсэн, орлогын ялгаа нэмэгдэх хандлагатай болсон тухайн нөхцөлд Япон Улсын Засгийн газар “Үндэсний хөгжлийн цогцолбор төлөвлөгөө (全国総合開発計画, Зэнсоо)”<sup>12</sup> нэртэй хөгжлийн хөтөлбөрийг 1962 онд батлан, бүс нутгуудыг тэнцвэртэй хөгжүүлэх, хурдан галт тэрэгний замын сүлжээг сайжруулах, баялгийн зөв зохистой хуваарилт явуулах, бүс нутаг хоорондын ялгааг багасгах, том хотуудад төвлөрч эхэлсэн хүнд аж үйлдвэрүүдийг хүн ам сийрэг, хөгжлөөр хоцорч яваа бүс нутгуудад шилжүүлэх замаар орчны бохирдол, хүн амын нягтаршлын асуудлыг шийдвэрлэх бодлого явуулжээ. Энэхүү төлөвлөгөөний үргэлжлэл болгож, улс орноо бүх нутаг дэвсгэрийн хэмжээнд тэнцвэртэй хөгжүүлэх, эдийн засаг, нийгмийн хүрээний өргөн асуудлыг цогцоор шийдвэрлэх зорилт дэвшүүлсэн үндэсний хэмжээний урт хугацааны цогц бодлогыг 1969 онд “Үндэсний хөгжлийн шинэ цогцолбор төлөвлөгөө (新全国総合開発計画, Шинзэнсоо)”, 1977 онд “Үндэсний хөгжлийн гуравдахь удаагийн цогцолбор төлөвлөгөө нь (第三次全国総合開発計画, Санзэнсоо)”, 1987 онд “Үндэсний хөгжлийн дөрөвдэх удаагийн цогцолбор төлөвлөгөө (第四次全国総合開発計画, Ёнзэнсоо)”<sup>13</sup> нэртэйгээр хэрэгжүүлжээ. Анхдугаар цогцолбор төлөвлөгөөний дагуу аж үйлдвэрийн шинэ хотууд, үйлдвэр төвлөрсөн тусгай бүс болон орон нутгийн хотуудад үйлдвэрийн район байгуулах замаар эдийн засгийн бааз газруудыг орон нутагт жигд хөгжүүлэх бодлого явуулжээ. 1969 оны хоёрдахь төлөвлөгөөгөөр бүс нутгийн хөгжлийн ялгааг багасгах, том хотууд дахь төвлөрлийг сааруулах чиглэлээр томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, аж үйлдвэрийн суурийг улам бататгах үйл явцыг үргэлжлүүлсэн байна. Үүний үр дүнд 1970-аад он гэхэд хүн амын шилжилт буурах, аж үйлдвэрийн том төвүүд орон нутагт бэхжих хандлага тогтворжиж, бүс нутаг хоорондын ялгаа аажмаар багасч иржээ. Гэвч хүн ам, үйлдвэр, үйлчилгээний төвлөрөл бүс нутгийн гол хотууд руу чиглэж, дунд зэргийн болон жижиг хот суурингууд, газар тариалангийн болон загасчдын тосгодын үйл

<sup>12</sup> 『数字で見る日本の 100 年』改訂第 4 版、国勢社、2000 年、p. 25 (“Японы 100 жилийг статистикээр харахад” 2000 он, 25-р тал)

<sup>13</sup> Мөн тэнд

ажиллагаа хумигдаж, хүн ам сийрэгжих асуудал шинээр бий болжээ. Ард түмний амьдралын чинээлэг байдал бүрдэж эхэлсэн хэдий ч, 1973 онд нефтийн хямрал нүүрлэж, эдийн засгийн эрчимтэй өсөлтийн хурд сааран улмаар байгаль орчны бохирдол газар авсан зэрэг нь тухайн үеийг хүртэл баримталж, хэрэгжүүлж ирсэн үйлдвэржилтийг эн тэргүүнд тавих төр засгийн бодлогод дүгнэлт өгч, бодит байдлыг эргэн авч үзэхэд хүргэжээ. 1977 онд баталсан гуравдахь удаагийн цогцолбор төлөвлөгөө нөөц баялгийг хэмнэх, хүн байгальтайгаа зохицон амьдрах, түүх, уламжлалт соёлдоо хүндэтгэлтэй хандах, амьдралын орчны чанарыг сайжруулах асуудлыг онцгойлон авч үзжээ.

1980-аад оноос үйлчилгээний салбарын хөгжил, гадаад харилцаа, мэдээллийн урсгалын эрчимжилт үлэмж хурдтай өрнөх болж, нийслэл Токиог чиглэсэн хүн ам, аж үйлдвэрийн төвлөрөл дахин хүчтэй явагдаж, газар нутгийн Номхон далай захалсан аж үйлдвэрийн хотууд дахь бүс нутгийн төвлөрөлд өөрчлөлт гарч, орон нутаг дахь хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн тулгамдсан асуудлын нэг болжээ. Тийм нөхцөлд 1983 онд “Бүс нутгийн өндөр технологийн аж үйлдвэржилтийг дэмжих бодлого (テクノポリス法)”<sup>14</sup> –ыг хэрэгжүүлсэн нь Японы эдийн засгийн хөгжлийг түргэтгэж, тухайн бүс нутагт л үйлдвэрлэгддэг бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргадаг олон улсад өрсөлдөх чадвартай ЖДҮ-үүд Японы бүс нутгуудаас төрөн гарахад нөлөөлжээ. Улмаар 1987 онд дөрөвдэх удаагийн цогцолбор төлөвлөгөөг баталж, орон нутаг дахь төрөл бүрийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, гол хотууд хоорондын харилцаа холбоог сайжруулах замаар орон нутгийг хөгжүүлэх, олон төвүүдэд тулгуурласан эдийн засаг, нийгмийн хөгжлийг хэрэгжүүлэх зорилт тавьжээ. Энэ үеийг залган 1980-аад оны сүүлчээс хөөсөн эдийн засгийн нуралт эхэлж, улмаар 90-ээд оны урт хугацааны эдийн засгийн зогсонги байдал үргэлжилсэн нь бүс нутгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж, орон нутгийн хүн ам томоохон хотууд руу шилжих болов. 1998 онд Ерөнхий сайд Хашимотогийн Засгийн газраас үндэсний хөгжлийн тав дахь удаагийн цогцолбор төлөвлөгөө болох “Японы нийт нутаг дэвсгэрийн XXI зууны Гранд дизайн (21 世紀の国土のグランドデザイン)”-ийг батлан гаргаж, 2015 он хүртэл хэрэгжүүлсэн энэ төлөвлөгөөнд улсын нийт нутаг дэвсгэрийг 4 том бүсээр төвлөрүүлэн олон тэнхлэгт эдийн засгийн бүтцийг хөгжүүлэх аргаар бүс нутгийн олон субъект, оршин суугчдын тал бүрийн оролцоо,

---

<sup>14</sup> 専修大学都市政策研究センター年報 第1号 (追補版) 2005年8月 (Сэншүү их сургуулийн Хотын бодлогын судалгааны төвийн жилийн тайлан, Дугаар 1, 2005 оны 8 сар)

бүс нутгууд хоорондын хамтын ажиллагаанд тулгуурласан XXI зууны хөгжлийн загварыг бий болгох зорилт дэвшүүлжээ. 2021 онд Ерөнхий сайд Кишида Фүмиогийн Засгийн газраас “Шинэ өсөлтийн стратеги”-ийг хэрэгжүүлэхийг зорьж “Япон маягийн шинэ капитализм” байгуулах хөгжлийн үзэл баримтлалыг дэвшүүлж, энэхүү шинэ капитализмыг байгуулахад бүс нутгийн оролцоог чухалчлан авч үзэж, дижитал технологийг ажиглан бүс нутгийн онцлогийг тодотгож, хүн амын өсөлт буурах, насжилт, ажиллах хүчний хомсдол зэрэг аж үйлдвэржилтэд тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэж, хөдөө орон нутгаас эхлэн нийт нутаг дэвсгэрийг хамарсан өсөлтийг бий болгож тогтвортой эдийн засаг бүхий нийгмийг цогцлооно хэмээн мэдэгдэв<sup>15</sup>.

Мөн хүнд аж үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас орчны бохирдолд нэрвэгдсэн бүс нутгийг экологийн цэвэр орчин болгож сайжруулан, ногоон хот болгон олон улсад үлгэрлэж буй туршлага ч Японд байна. Жишээ нь тухайн үед Кита Кюүшюү хот нь төмөрлөгийн үйлдвэр хөгжүүлж, нүүрс коксжуулан агаар, хөрс, далайг хордуулж, хүн амын эрүүл мэнд эрсдэлд учирсан хүрэн хот байсан аж. Хотын захиргаа энэ байдлыг оршин суугчдад ил тод, нээлттэй мэдээлж, түүнээс гарах арга замыг судлан тодорхойлж, экологийн сургалт явуулах, эрүүл ахуй, ариун цэврийн нөхцлийг сайжруулах, хог хаягдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх, бүтээгдэхүүнийг дахин ашиглах, нийгмийн хөгжлийн төлөвлөлтийн чанарыг ахиулахаас эхлээд хүрээлэн буй орчны олон талын менежмент хэрэгжүүлсний үр дүнд экологийн асуудал болон эдийн засгийн хөгжил гэсэн 2 хүчин зүйлийг хоёуланг эерэг үзүүлэлтэд хүргэж, 2006 онд “Азийн ногоон хот”, 2008 онд “Дэлхийн ногоон хот” болжээ. Кита Кюүшюү хотын хэрэгжүүлсэн бодлогыг анх удаа OECD-гээс 1985 онд нийтэлсэн Байгаль орчны тайланд “хүрэн хотыг ногоон хот болгосон” гэж дүгнэжээ. ESCAP (アジア太平洋経済社会委員会)-ийн 2000 оны чуулган Ази тивийн экологийн асуудлыг шийдвэрлэхэд Японы орон нутгийн засаг захиргаанаас хэрэгжүүлсэн бодлогын туршлага ач холбогдолтой хэмээн үзэж, “Ногоон экологийн төлөөх Кита Кюүшюүгийн санаачилга (グリーンな環境のための北九州市イニシアティブ)” хэмээх баримт бичиг гаргаж, мөн Иоханесбургийн Төрийн тэргүүн нарын чуулга уулзалт Кита Кюүшюү хотын туршлагыг үнэлж, ялангуяа 1968 оноос хойш эдийн засгийн хөгжлийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ экологийн асуудлыг амжилттай шийдвэрлэсэн

---

<sup>15</sup> 成長戦略 | 首相官邸ホームページ (kantei.go.jp) (Өсөлтийн стратеги, Япон Улсын Ерөнхий сайдын албан ёсны пэйж хуудас)

туршлага нь өнөөгийн Азийн хөгжиж буй орнуудад тус болно гэдгийг цохон тэмдэглэжээ<sup>16</sup>.

Кита Кюүшюү хот эко хотын туршлагаа дэлхийн бусад хотуудтай хуваалцах зорилгоор 2 чиглэлийн сүлжээ бий болгож, нэгд, Хятадын Далянь болон Өмнөд Солонгосын Инчон хоттой найрамдалт харилцаа тогтоон ажиллажээ. Кита Кюүшюүгийн хөрш Шимоносэки хот Өмнөд Солонгосын Инчон, Пусан, Хятадын Циндао хоттой найрамдалт хотын харилцаа тогтоож, эдгээр хотууд бүс нутгийн хэмжээнд эко бизнесийн хамтын ажиллагаа хөгжүүлжээ. Хоёрт, Азийн эко хотуудын төлөө сүлжээ байгуулж, дээрх 6 хот энэ сүлжээнд хамтран ажиллаж байна. Эдгээр хот нь бүгд үйлдвэр төвлөрсөн хотууд бөгөөд экологийн нөхцлөө сайжруулах чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, хамтын хүчин чармайлт гаргаж, зохих үр дүнд хүрч байгаа ажээ.

### **3. Японы хог хаягдлын менежмент**

Япон нь дайны дараах эдийн засгийн эрчимтэй хөгжлийн явцад бий болсон байгаль орчны бохирдол, түүнээс үүдэн ард иргэдийн эрүүл мэндэд учруулсан ноцтой хор холбогдлыг даван туулах талаар оновчтой бодлого хэрэгжүүлэн амжилтад хүрч, түүний туршлагыг аж үйлдвэржсэн зарим орнууд нэвтрүүлэн ашиглаж ирсэн түүхтэй. Япон Улсад эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэхэд байгаль орчны хамгааллыг чухалчлан үзэж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалж ирсэн туршлагаас Японд хог хаягдлын менежментийг хэрхэн хэрэгжүүлдэг, хууль эрх зүйн орчныг хэрхэн бүрдүүлдэг туршлага сургамж нь манай улсад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой байх болно.

Япон Улсад 1990-ээд оноос байгалийн баялгийг ашиглах явдлыг багасгаж, байгаль орчинд үзүүлэх ачааллыг аль болох бууруулах үзэл санаанд тулгуурласан “Тогтвортой хөгжих нийгэм байгуулах суурь хууль” хэрэгжүүлж эхлэн, энэ хуулинд “3R” зарчмыг тусгасан байдаг. Эдгээр нь Reduce (хог хаягдлын хэмжээг багасгах), Reuse (дахин ашиглах), Recycle (дахин боловсруулж ашиглах) гэсэн 3 ухагдахуун юм. Үүн дээр Refuse (хэрэггүй зүйлсийг худалдаж авахгүй байх), Repair (засаж хэрэглэх) гэсэн хоёр зүйлийг нэмж 5R гэх нь ч бий.

Дээрх хуулийг ажил хэрэг болгох хүрээнд Засгийн газраас “Тогтвортой хөгжих нийгэм байгуулах суурь хөтөлбөр” боловсруулан, үе шаттайгаар

---

<sup>16</sup> [www.ryukoku.ac.jp/gs\\_npo/letter/images/letter06\\_08.pdf](http://www.ryukoku.ac.jp/gs_npo/letter/images/letter06_08.pdf)

шинэчлэн хэрэгжүүлж ирсэн нь чухал үр дүнд хүрчээ. 2003 онд батлагдсан анхдугаар Хөтөлбөрөөр эд материалыг ариг гамтай хэрэглэх амьдралын хэв маяг, байгаль орчноо хамгаалах зорилго бүхий үйлдвэрлэл үйлчилгээг санал болгожээ. 2008 онд шинэчилсэн хоёрдахь Хөтөлбөрөөр нүүрс төрөгч бага ялгаруулдаг нийгэм, байгальтайгаа хамт орших нийгэм байгуулах зорилго дэвшүүлж ажиллажээ. 2013 онд гуравдахь удаагийн Хөтөлбөр боловсрогдож, түүнд бодлогын 4 зорилтыг чухалчилж авч үзжээ. Үүнд нэгд, Recycle-тай харьцуулахад хэрэгжилт нь сул байгаа Reduce, Reuse хоёрын хэрэгжилтийг сайжруулах; хоёрт, ашигтай төмөрлөгийг түүж ялгах; гуравт, сэтгэл амар, аюулгүй амьдрах нөхцлийг сайжруулах; дөрөвт, 3R зарчмын хүрээнд олон улсын хэмжээнд хамтран ажиллах бодлогыг зорилт болгожээ.

“Тогтвортой хөгжих нийгэм байгуулах суурь хөтөлбөр”-ийн үр дүнд 2000 оноос хойш айл гэр, үйлдвэрээс гарах хог хаягдлын хэмжээ багассаар ирсэн байна. Мөн хөрсөнд булах хогны хэмжээ буурч, хог хаягдлыг дахин боловсруулах хувь өсч, шатаах зуухнаас ялгарах хорт бодис диоксины хэмжээ ч буурсан байна. Ялангуяа хог шатаах газраас ялгарах хорт бодисыг бууруулах чиглэлээр засгийн газар, эрдэмтэд, үйлдвэрлэгчдийн хамтын ажиллагаа шинэ шатанд гарч, судалгаа шинжилгээний үр дүнд технологийн хөгжилд томоохон ахиц дэвшил бий болжээ.

Японы хог хаягдлын менежментийн чиглэлээрх хуулиуд нь “Байгаль орчны суурь хууль”-д тулгуурласан байдаг. Өнөөгийн байдлаар дээр өгүүлсэн “Тогтвортой хөгжих нийгэм байгуулах суурь хууль”-ийг оролцуулаад нийт 14 хууль хэрэгжиж байна. Үүнд

- Тогтвортой хөгжих нийгэм байгуулах суурь хууль (2000). Энэ хуулиар байгалийн баялагт аривч хямгачаар хандан, түүнийг ашиглах явдлыг бууруулж, байгаль орчинд үзүүлэх ачааллыг багасгасан тогтвортой хөгжих нийгмийг цогцлоох тухай заажээ. Мөн төрийн болон олон нийтийн байгууллага, үйлдвэрлэл эрхлэгчид, иргэдийн үүргийг тодорхойлж, 3R зарчмыг анх удаа хуульчлан тусгажээ.

- Хог хаягдлын боловсруулалт, цэвэрлэгээний тухай хууль (1970). Хог хаягдлын хэмжээг бууруулж, зохистой аргаар боловсруулах замаар иргэдийн амьдрах орчныг хамгаалах, нийгмийн эрүүл ахуйг сайжруулах зорилтыг тусгав.

- Нөөц баялгийг үр ашигтай хэрэглэх тухай хууль (1991). Энэ хуулиар 3R зарчмыг хэрэгжүүлэх шаардлагатай үйлдвэрийн төрөл, бараа бүтээгдэхүүний

төрлийг тогтоожээ. Энд 10 төрлийн үйлдвэр, 69 төрлийн бараа бүтээгдэхүүнийг багтаасан байна.

- Сав, баглаа боодлыг дахин боловсруулах тухай хууль (1995)-иар иргэд, хот, дүүрэг, тосгод, үйлдвэрлэгчдийн хамтын ажиллагааны чиг үүргийг тодорхойлж, ган лааз, хөнгөн цагаан лааз, шилэн лонх, цаасан хайрцаг, цаасан уут, ундааны хуванцар сав болон бусад төрлийн хуванцар савны дахин боловсруулалтыг хуульчилсан.

- Гэр ахуйн цахилгаан барааг дахин боловсруулах тухай хууль (1998)-иар эйр кондиционер, телевизор, хөргөгч, хөлдөөгч, угаалгын машин, хувцас хатаагч зэрэг цахилгаан барааны дахин боловсруулалтыг хуульчилж, цахилгаан бараа худалдаалагчид иргэдээс хуучин барааг авч үйлдвэрлэгчид нь дамжуулах, үйлдвэрлэгчид барааг дахин боловсруулах, иргэд хуучин бараагаа хаях үедээ мөнгө төлөх үүрэг хариуцлагыг тус тус хуульчлав.

- Барилгын материал дахин боловсруулах тухай хууль (2000). Бетон, төмөр бетон, модон материал, асфальт зэрэг барилгын материалыг дахин боловсруулж, дахин ашиглах заалтуудыг энэ хуульд тусгасан байна.


- Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах тухай хууль (2000). Хүнс үйлдвэрлэлийн явцад гарсан хаягдал, нийтийн хоолны боловсруулаагүй үлдэгдэл, зарагдаагүй лангуун дээр үлдсэн бараа, хоолны үлдэгдэл зэргийг дахин ашиглах тухай хуульчилж, хүнсний хаягдлыг бордоо, мал амьтны тэжээлд ашиглах тухай заасан.

- Автомашин дахин боловсруулах тухай хууль (2002). Автомашины боловсруулахад хүндрэлтэй 3 төрлийн эд ангийг (*shredder dust, chlorofluorocarbon, air bag*) автомашин үйлдвэрлэгч компани эргүүлэн авч, дахин боловсруулахыг хуульчилжээ. Хэрэглээнээс гарсан автомашиныг дахин боловсруулж, зохих устгал хийхийг заасан. Мөн эдгээрийн зардлыг автомашин эзэмшигч төлөх үүрэгтэйг заав.

- Бага оврын гэр ахуйн цахилгаан барааг дахин боловсруулах тухай хууль (2012). Компьютер, гар утас, дижитал камер, цаг, үсний сэнс зэргийг дахин боловсруулах тухай тусгаж, эдгээр нь төмөр, хөнгөн цагаан, зэс, үнэт металл зэрэг төмөрлөгийг ихээр агуулж байдаг тул хэрэглэгч, үйлдвэрлэгч, хот дүүрэг, борлуулагчид хамтран дахин боловсруулалт, дахин ашиглалтын ажлыг хийхийг хуульчилсан байна.

Эдгээрээс гадна “Газар тариалан, ой мод, загас агнуурын салбар дахь биотүлшний тухай хууль”, “Биомассыг ашиглах тухай суурь хууль”, “Ногоон худалдан авалтын тухай хууль”, “PCB хаягдлыг зохистой аргаар боловсруулах тухай хууль”, “Үйлдвэрийн хог хаягдлаас шалтгаалах хор хохирлыг арилгах тухай хууль”, “Бохир ус цэвэрлэх төхөөрөмжийн тухай хууль”-ийг хэрэгжүүлж байна.

Хог ангилах, боловсруулах тухайд ердийн хог хаягдал, үйлдвэрийн хог хаягдал гэсэн 2 том хэсэгт хуваагдах айл өрх, оффис, ресторанаас гарах хог болон бохир ус мөн “Хог хаягдал боловсруулалт, цэвэрлэгээний тухай хууль”-иар батлагдсан, голдуу үйлдвэрээс гарах 20 төрлийн хог хаягдлыг дараах байдлаар ангилж боловсруулдаг.



Шатаах хогонд гал тогооноос гарах хог хаягдал, резинэн эд зүйлс, дахин боловсруулах боломжгүй цаас, даавуун эд зүйлс, хуванцар эд зүйлс, модны мөчир, өвс, хөөсөнцөрийг хамруулдаг.

Шатаахгүй хогонд төмөр эдлэл (хоолны сав, данх, хайч, шүхэр, зай тэжээл г.м.), бага оврын цахилгаан хэрэгсэл (телефон утас, индүү, үсний сэнс г.м.), шил шаазан эдлэл (аяга таваг, ваар, гэрлийн шил г.м.)-ийг оруулж, хаях байршил, өдөр, цаг, хийх сав уутыг ч тодорхой тогтоосон байдаг.

Том хогонд гэрийн тавилга, унадаг дугуй, хөнжил гэсэн том зүйлсийг хамруулдаг. Хэмжээний хувьд төмөр эдлэл, цахилгаан бараа 30 см-ээс том, бусад зүйлс 50 см-ээс том байвал том хогонд тооцогдоно. Хаях үед хогны төрлөөс шалтгаалан 200 иэн, 500 иэн, 1000 иэн, 1500 иэн гэсэн 4 төрлийн үнийг төлнө.

Тусгай хяналттай ердийн хог хаягдалд тэсэрч дэлбэрдэг, халдварладаг, хортой, хүний эрүүл мэнд, амьдрах орчинд хор хохирол учруулах аюултай зүйлс, жишээ нь хуучин эйр кондиционер, телевизор, богино долгионы зуух зэргийг оруулдаг.

Үйлдвэрийн явцад гарсан хог хаягдлын дотроос хуулинд заагдсан 20 төрлийн хог хаягдалд шатсан эд зүйл, лаг, хуучин тос, хуучин хүчил, хуучин шүлт, хуучин хуванцар эд зүйл, цаасны хаягдал, модны хаягдал, хаягдал утас, амьтан ургамлын үлдэгдэл, амьтны гаралтай хатуу хог, хаягдал резин, төмрийн хаягдал, шилний хаягдал, хаягдал бетон болон шавар ваарны хагархай, шаар шавхдас, барилгын нуранги, амьтны ялгадас, амьтны сэг зэм, тоос тортог, импортоор орж ирсэн хог хаягдлыг хамруулдаг.

Тусгай хяналттай үйлдвэрийн хог хаягдалд тэсэрдэг, дэлбэрдэг, халдварладаг, хортой, хүний эрүүл мэнд, амьдрах орчинд хор хохирол учруулах аюултай зүйлүүд орно.

Хог боловсруулах байгууламж нь дотроо шатаах байгууламж, баялаг болгох байгууламж, бордоо үйлдвэрлэх байгууламж, тэжээл үйлдвэрлэх байгууламж, метан хий гаргаж авах байгууламжтай. Боловсруулах байгууламжид орсон хогны тодорхой хэсгийг дахин ашигладаг байна.

Ердийн хог хаягдлын боловсруулалтын тухайд шатаах хогийг шатаах зууханд шатааж, гарсан үнсний ихэнхийг нь булах байгууламжид булж устгадаг. Зарим хотууд шатаах зуухнаас гарсан үнсийг зам, барилгын материал болгон ашигладаг. Мөн хог шатахдаа 800 хэмийн дулаан ялгаруулдаг учир зарим хотод энэ дулааныг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, сауны ус халаах, нийгмийн халамжийн байгууллагуудыг халуун ус, дулаанаар хангадаг ажээ. Бас цөөн тооны хотууд хүнсний хаягдлаас бордоо, малын тэжээл, метан гарган авч, бусад хогоор түлш хийдэг байна.



Шатаахгүй хогийг боловсруулах байгууламжид оруулан буталж, төмөр, хөнгөн цагаан зэрэг хэрэгтэй материалыг нь ялгаж, дахин боловсруулдаг.

Үйлдвэрийн хог хаягдлын боловсруулалтын тухайд хамгийн их хог гаргадаг салбар нь эрчим хүч, газ, дулаан хангамж, ус суваг, газар тариалан, модны аж ахуй, барилгын салбарууд байна. Эдгээр салбараас гарах хог хаягдал нийт хогны 70 орчим хувийг эзэлж байна. Ердийн хог хаягдлыг устгах, дахин боловсруулах ажлыг хот, дүүрэг, тосгод хариуцаж хийдэг бол үйлдвэрийн хог хаягдлын хувьд үйлдвэрлэгч компаниуд өөрсдөө хариуцаж устгал хийдэг.

Хог хаягдал боловсруулах зардлын тухайд ердийн хог хаягдлыг хот, дүүрэг, тосгод тус тусын нутаг дэвсгэр дээр боловсруулах үүрэгтэй байдаг. Канагава мужийн 1 сая хүнтэй Кавасаки хотын жишээгээр үзвэл, хотын нийт төсөв 618 тэрбум иэн байна. Харин хог хаягдалд зориулах хөрөнгө нь 22.3 тэрбум иэн байна. Энэ нь нийт төсвийн 3.6% юм. Хог хаягдалд зориулах хөрөнгөнөөс хогны байгууламж барих, сайжруулахад 7.3 тэрбум иэн зарцуулж, хог боловсруулах ажил болон техникийн засварт 14.4 тэрбум иэн зарцуулдаг ажээ.<sup>17</sup>

Дашрамд дурдахад **Фукушимагийн атомын станц 2011 онд 9 магнитудын хүчтэй газар хөдлөлт, цунамигийн гамшгийн улмаас осолдож, реакторууд нь ажиллагаагүй болж, түлшний савыг хөргөх зорилгоор ус шахаж, цацраг идэвх бүхий их хэмжээний хаягдал ус бий болсон нь тус улсын хог хаягдлын менежмент хүнд сорилттой тулгарсан.** Улмаар НҮБ-ын харьяа Олон Улсын Атомын Эрчим Хүчний Агентлаг хаягдал усны байгаль орчинд үзүүлэх нөлөөг “өчүүхэн бага” гэж дүгнэж, далайд асгах Японы эрх баригчдын төлөвлөгөө олон улсын стандартад бүрэн нийцэж буйг баталснаар Номхон далайд хаягдал усыг асгаж эхэлсэн нь хөрш БНСУ, БНХАУ, ОХУ-ын зүгээс хүчтэй эсэргүүцэлтэй тулгараад байгаа ч түүнийг намжаах зорилгоор АНУ тэр орчмоос олборлосон далайн бүтээгдэхүүнийг импортлон Японыг хамгаалж байна.

Манай улсын хувьд хог хаягдал тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хэрэгжүүлэх, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Ногоон хөгжлийн бодлогод

---

<sup>17</sup> 『日本の廃棄物処理の歴史と現状』 (Японы хог хаягдал боловсруулалтын түүх, орчин үеийн байдал), 2014 он

тусгагдсан хог хаягдлын менежментийг сайжруулж, хог хаягдлыг бууруулах, хүн амын амьдрах тав тухтай эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээрх зорилтууд түүнчлэн 2012 онд батлагдсан Хог хаягдлын тухай хууль, Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Япон Улсын туршлагыг судлан, өөрийн орны онцлогийг харгалзсаны үндсэн дээр авч нэвтрүүлэх нь үр дүнгээ өгнө хэмээн үзэж байна. Нөгөө талаар Улаанбаатар хотын хувьд 2006-2010 онд Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Нарангийн энгэрт ахуйн хог хаягдлыг булах төвлөрсөн цэг байгуулж, хог тээвэрлэх автомашины парк шинэчлэлийг хийсэн. Хог хаягдлыг зориулалтын уутанд хийлгэж хэвшүүлэх, нийтийн эдэлбэр газрын цэвэрлэгээг өргөжүүлэх, барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах зэрэг олон ажлыг өрнүүлж байгаа нь энэ салбарт Япон улстай явуулж буй хамтын ажиллагааг өргөжүүлэх, Японы туршлагыг нэвтрүүлж, хог хаягдлын нэгдсэн менежментийн тогтолцоо төлөвшүүлэх үндсэн суурь болж өгнө хэмээн үзэж байна.

Тиймээс Улаанбаатар хотод хог хаягдлын менежментийг сайжруулж, амьдралын эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд Япон Улсын хог хаягдлын менежмент, бодлогоос суралцаж, туршлагыг нь нэвтрүүлэх, ялангуяа 3R зарчимд тулгуурлан иргэдийн сэтгэлгээг өөрчилж, ухамсрыг дээшлүүлсэн туршлага, төр засаг, эрдэмтэд, үйлдвэрлэгчид хамтран судалгаа шинжилгээ хийж, техник технологио хөгжүүлсэн туршлага зэргээс суралцах нь ач холбогдлоо өгнө хэмээн үзнэ. Нөгөө талаар Жайкагийн шугамаар нийслэлийн хог хаягдлыг бууруулах чиглэлээр боловсруулсан төсөл хөтөлбөрт тусгасан заавар зөвлөмжийг бид ажил хэрэг болгож хэрэгжүүлж, Японы туршлагыг нутагшуулж, манайд төрдөх стандарт болгож чадвал нийслэл маань ногоон хот болох боломж бий.

#### **4. Японы байгаль, экологийн боловсролын туршлага**

Япон улс 1970-аад оноос байгаль орчны боловсролд анхаарал төвлөрүүлж иржээ. 1960-аад оны эдийн засгийн өндөр өсөлтийн нөлөөгөөр Японд байгаль орчны бохирдлын асуудал үүсч, хурцадмал байдалд орсон. Байгаль орчны бохирдлоос шалтгаалан минамата өвчин, итай итай өвчин гарч, нийгмийн том асуудлыг үүсгэсэн юм. Эдгээр өвчин иргэдийн эрүүл мэндэд заналхийлснээс болж, байгаль орчны бохирдлын тухай олон нийтийн хөдөлгөөн газар авсан нь

төр засгийн байгууллага, үйлдвэр компаниуд асуудлыг шийдэхийн төлөө хамтын үйл ажиллагаагаа явуулахад хүргэжээ. Сургуулийн сургалтанд ч байгаль орчин, хүний эрүүл мэндийн харилцан хамаарлын талаар тусган, хичээлийн цаг гаргадаг болжээ.

“Боловсролын суурь хууль”-ийн I бүлгийн 4-р заалтад “Амьд амьтдыг хайрладаг, байгалийг хайрладаг, байгаль орчныг хамгаалахад хувь нэмэр оруулдаг хүмүүжлийг олгох”<sup>18</sup> гэж заасан байна.

Мөн “Сургуулийн боловсролын тухай хууль”-ийн II бүлгийн 2-р заалтад “Сургуулийн гадна болон дотор экологийн дадлагын хичээлийг явуулж, амьд амьтан болон байгалийг хайрлах үзэл санааг төлөвшүүлж, байгаль орчныг хамгаалахад хувь нэмэр оруулах хүмүүжлийг олгох”<sup>19</sup> гэж заажээ.

“Хүрээлэн буй орчны суурь хууль”-ийн 25-р зүйлд “Төрийн байгууллага нь байгаль орчныг хамгаалах талаар сургалт, мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагааг боловсронгуй болгох, үйлдвэрлэл эрхлэгчид, иргэд байгаль орчныг хамгаалах талаар ойлголтоо гүнзгийрүүлэх, иргэдэд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны ач холбогдолыг ойлгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх”<sup>20</sup> тухай заажээ. Энэхүү “Хүрээлэн буй орчны суурь хууль”-ийн 25-р зүйлд үндэслэн, “Байгаль орчныг хамгаалах сонирхлыг дээшлүүлэх, байгаль орчны боловсролыг урагшлуулах тухай хууль” батлагдаж, цаашид хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг нарийвчлан тодорхойлжээ. “Байгаль орчныг хамгаалах сонирхлыг дээшлүүлэх, байгаль орчны боловсролыг урагшлуулах тухай хууль”-ийн зорилго нь байгаль орчны боловсролыг урагшлуулахад шаардлагатай бүх төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, зөвхөн сургуульд ч биш, засаг захиргааны байгууллага, үйлдвэр компаниудын үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны боловсролыг олгох явдал<sup>21</sup> гэдгийг заажээ.

Байгаль орчны боловсролтой холбоотой ажлуудыг Японд олон яамд хамтарч хэрэгжүүлдэг. БШУЯ, Байгаль орчны яам, Газар, дэд бүтэц, зам тээвэр,

---

<sup>18</sup> 教育基本法、第一章、第二条 (“Боловсролын суурь хууль” Нэгдүгээр бүлэг, 2-р зүйл )

<sup>19</sup> 学校教育法、第二章、第二十一条 (“Сургуулийн боловсролын хууль” Хоёрдугаар бүлэг, 21-р зүйл)

<sup>20</sup> 環境基本法、第五節、第二十五条 (“Хүрээлэн буй орчны суурь хууль” Тавдугаар бүлэг, 25-р зүйл)

<sup>21</sup> 環境の保全のための意欲の増進及び環境教育の推進に関する法律 (“Байгаль орчныг хамгаалах сонирхолыг дээшлүүлэх, байгаль орчны боловсролыг урагшлуулах тухай хууль”)

аялал жуулчлалын яам, Газар тариалан ой мод, усны яам, Эдийн засаг үйлдвэрийн яамдад байгаль орчны боловсролын асуудал төвлөрдөг ажээ.

БШУЯ нь байгаль орчны боловсролын талаар дараах ажлуудыг хэрэгжүүлдэг. Тухайлбал, боловсролын агуулгыг сайжруулах, боловсронгуй болгох, байгаль орчны боловсролтой холбоотой дадлагын ажлыг чанартай зохион байгуулах, түгээн дэлгэрүүлэх, эко сургууль байгуулах, түүнд дэмжлэг үзүүлэх, байгаль орчны сургалтыг боловсронгуй болгох, багш нарын заах аргыг сайжруулах, тогтвортой хөгжлийн боловсролыг урагшлуулах, хүүхэд багачуудын экологийн туршилтын ажлыг дэмжих чиглэлд үйл ажиллагаагаа төвлөрүүлдэг ажээ.<sup>22</sup>

Харин Байгаль орчны яамны үндсэн чиглэл нь байгаль орчны асуудал нь өдөр тутмын эдийн засгийн үйл ажиллагаа болон ахуй амьдралаас шалтгаалдаг тул иргэдийн амьдралын хэв маягийг байгаль орчинд хор хохирол багатай байлгах, ард иргэдэд байгаль орчны тухай суурь мэдлэг эзэмшиж, байгаль орчныг хамгаалах хүсэл эрмэлзэлтэй болоход нь дэмжлэг үзүүлэх, байгаль орчныг хамгаалах тухай мэдээлэл сурталчилгааны ажлыг боловсронгуй болгоход чиглэгддэг. Мөн Байгаль орчны яам нь үндэсний парк зэрэг байгалийн паркад ирэх зочдыг хүлээн авах төв, байгаль ажиглалтын төхөөрөмжийг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Сургуулийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны боловсрол олгохдоо “Сургуулийн боловсролын хууль”-ийг баримтлан “Сургалтын удирдамж”-ийг боловсруулж хичээл тус бүрийн зорилт, агуулгыг тодорхойлсоны дараа сургалтад мөрдөн хэрэгжүүлдэг байна. Мөн “Байгаль орчны боловсролын удирдамж”-ийг бага, дунд, ахлах ангийн түвшин тус бүрээр боловсруулан дагаж мөрддөг ажээ.

Японд байгаль орчин гэсэн тусгай хичээл байдаггүй, харин нийт хичээл дээр байгаль орчны боловсрол олгох зарчмыг баримталдаг. Байгаль орчны боловсролыг шинжлэх ухааны мэдлэг олгох хичээлүүдээс гадна иргэний

---

<sup>22</sup> 「一人ひとりのライフスタイルの変革につながる環境教育・学習の推進」、文部科学省、平成26年（“Хүн нэг бүрийн амьдралын хэв маягийг өөрчлөх байгаль орчны боловсрол сургалтыг дэмжих нь” Боловсрол, шинжлэх ухааны яам, Хэйсэйгийн 26 он）

боловсролын цаг, ёс зүйн цаг, тусгай үйл ажиллагааны цагууд дээр олгодог. Өөрөөр хэлбэл,

- байгаль орчны тухай мэдлэгийг нийгэм судлал, байгалийн шинжлэл, хөдөлмөрийн хичээл гэх мэтийн хичээлүүдээс гадна иргэний боловсролын цаг дээр олгож,

- дадлага туршлагыг иргэний боловсролын цаг, тусгай үйл ажиллагааны цагууд дээр хийлгэж,

- байгалиа хайрлах хүмүүжил, сэтгэлийг ёс зүйн цагаар төлөвшүүлдэг.

Японы сургуулиудад олгох байгаль орчны боловсролын зорилгыг “Манай улсын байгаль орчны боловсролыг ганц хичээлээр заахгүй, олон янзын хичээлийн агуулгыг хооронд нь холбож заах бөгөөд сурагч судлагдахуун, объектоо олон талаас нь бүхэлд нь ойлгож чаддаг байх ёстой. Мөн байгаль орчны талаарх баялаг мэдрэмжид тулгуурлан, байгаль орчны асуудлыг шийдэхэд шаардлагатай оновчтой дүгнэлт, өөрийн шийдвэрийг бие даан гаргаж чадах чадварыг төлөвшүүлэх нь чухал. Энэ боловсрол нь насан туршийн боловсролын суурь нь болох ёстой”<sup>23</sup> хэмээн “Байгаль орчны боловсролын удирдамж”-д тодорхойлжээ.

“Сургалтын удирдамж”-д “Байгаль орчныг хамгаалахад хувь нэмэр оруулж, ирээдүйг нээх бие даасан япон хүнийг хүмүүжүүлэхийн тулд түүний суурь болох ёс зүйг төлөвшүүлэх ёстой”<sup>24</sup> гэж заасан байна. Энэ удирдамжийн агуулгаас харвал, бага ангид нийгэм судлал, байгалийн шинжлэл, амьдралын орчин, хөдөлмөр, биеийн тамир, ёс зүй, иргэний боловсролын цаг, тусгай үйл ажиллагааны цаг дээр байгаль орчны боловсролыг олгодог. Дунд ангид нийгэм судлал, байгалийн шинжлэл, биеийн тамир, хөдөлмөр, ёс зүй, иргэний боловсролын цаг, тусгай үйл ажиллагааны цаг дээр байгаль орчны боловсролын ойлголтыг төлөвшүүлдэг. Ахлах ангид түүх, газар зүй, иргэний эрх, байгалийн шинжлэл, биеийн тамир, хөдөлмөр, иргэний боловсролын цаг, тусгай үйл ажиллагааны цаг дээр байгаль орчны боловсролыг олгодог байна. Эдгээр шат бүрт энгийнээс гүнзгийрэх зарчмаар сургалтыг хэрэгжүүлдэг.

<sup>23</sup> 環境教育指導資料、文部科学省、1991年（“Байгаль орчны боловсролын удирдамж” Боловсрол, шинжлэх ухааны яам, 1991 он）

<sup>24</sup> 学習指導要領、総則（“Сургалтын удирдамж” Ерөнхий зүйл）

Шинжлэх ухааны мэдлэг олгох хичээлүүд дээр ч сурагчдын хөгжлийн үе шатанд тохируулан байгаль орчны сэдвийг тухайн хичээлтэй холбон хөндөж, байгаль орчны талаар зохих мэдлэг төлөвшүүлэх чиглэлийг баримталж сургалтыг хэрэгжүүлдэг ажээ. Жишээлбэл,

1. Бага ангийн 3, 4-р ангийн нийгэм судлалын хичээл дээр “Хог хаягдлын боловсруулалт өөрсдийн ахуй амьдрал, үйлдвэрлэлтэй холбогдох нь” сэдвийн хүрээнд орон нутгийнхаа хог хаягдал боловсруулах аргыг судалж, хог боловсруулалтын гүйцэтгэх үүрэг, утга учрыг бодож, хог хаягдлыг баялаг гэдэг талаас нь ойлгож ашигладаг болгох дадал хэвшил олгоход анхаардаг.

2. Дунд ангийн нийгэм судлалын хичээлээр “Дэлхий, байгалийн баялаг, эрчим хүчний асуудал” сэдвийн хүрээнд байгалийн баялгийг хэмнэх, эрчим хүч хэмнэх, дахин ашиглахын чухлыг ойлгуулж, өөрсдийн амьдралын дадал зуршилдаа дүгнэлт хийж, энэ сэдвээр гүнзгийрүүлэн бодох сэдэл санааг төрүүлэхэд анхаардаг.

3. Ахлах ангийн хөдөлмөрийн хичээл дээр байгаль орчны асуудалд хамаарах эд зүйл, үйлчилгээг сонгох, худалдан авах, хэрэглэх явдал, мөн өөрийн амьдралын хэв маягийг нэг бүрчлэн тунгаан дүгнэж, амьдрах хэв маяг, ойлголтоо өөрчлөн, байгаль орчинд ачаалал багатай амьдрахыг зорьж, байгаль орчинтой зохицсон амьдралын хэв маягийг бий болгоход хувь нэмэр оруулах мэдлэг хүмүүжил олгоход анхаардаг гэх мэт.

Японд байгаль орчны боловсрол олгох программыг боловсронгуй болгох, түүнийг хэрэгжүүлэх, мэдээллээр хангахад ач холбогдол өгч, анхаарал хандуулж иржээ. Байгалийг ажиглах, амьд организмыг судлах, хог түүх зэргээр жинхэнэ байгальтай харилцах үйл ажиллагаагаар дамжуулан орон нутгаа судлах программууд байдаг ба тэдгээрийн сэдэв, судалгааны арга нь янз бүр байна. Байгаль орчны боловсролын программын тухай 2004 онд Байгаль орчны яамнаас CD-ROM-д оруулсан “Байгаль орчны сургалт – удирдагчдад зориулсан программын түүвэр –” гаргажээ. Үүнд ус, хог хаягдал, агаар, ургамал, хоол хүнс, эрчим хүч, бүс нутгийн сэдвээр программ зохиох гарын авлага, олон төрлийн үйл ажиллагааны жишээ орсон байна. Орон нутагт хэрэгжиж байгаа программуудыг үзвэл, өөр өөр агуулгатай байх ба байгууллага бүр орон нутгийнхаа байгаль орчин, барилга байгууламжийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлдэг нь ойлгогдож байна. Мөн тэдгээр байгууллагуудын ажилтнууд байгаль орчны боловсролын

программ хэрэгжүүлэх, интернет ашиглан мэдээллээр хангахад анхаарч ажилладаг нь ч харагдаж байна. Фүкүока мужид сургуулийн хичээлийн программд тусгагдсан далай тэнгистэй холбоотой хичээлийн агуулга, аргыг судлан, далайн аквариумд хэрэгжүүлж болох бие даасан программ, сургалтын материалыг гаргаж, жирийн иргэд болон орон нутгийнхаа сургуулийн сурагчдад байгаль орчны боловсролыг тасралтгүй олгоход ашиглаж байна. Интернет ашиглан мэдээллээр хангаж буй жишээ гэвэл, байгалийн ухааны судалгааны баг болон амьтны экологийн судалгааны багууд газар газрын амьтдын үйл хөдлөлийн дүрсийг Web сайтад оруулан, хэн ч үзэж ашиглах боломжтой байдлаар сургалтын материал бэлтгэдэг байна.

## **5. Дүгнэлт, санал**

Япон Улсын хурдацтай хөгжлийн туршлагыг судлан оновчтой туршлагыг өөрийн орны онцлогт тохируулан, судалгаанд үндэслэн урт, дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх явцад нутагшуулан авч ашиглах нь хөгжилд түлхэц үзүүлэх чухал хүчин зүйл байх нь маргаангүй. Энэ үүднээс Япон Улсад эдийн засаг, нийгмийн урт, дунд хугацааны хөгжлийг чиглүүлэн удирдаж ирсэн бодлого, төлөвлөлт, төрийн зохицуулалт болон байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийн олон үзүүлэлтээр дэлхийд тэргүүлэх орны эгнээнд хүрсэн туршлага, сургамж нь манай улсын хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой хүчин зүйлийн нэг хэмээн үзэж байна.

Япон Улсад төрийн бодлогын залгамж шинж, нэгдмэл цогц байх зарчим чанд үйлчилдэг, бодлого боловсруулах, төлөвлөх үйл явцыг цаг хугацааны дэс дараалалтай, экологийн хүчин зүйлтэй нягт уялдуулан удирдан зохион байгуулдаг, түүнийг нийгмийн бүхий л салбарт нарийн эмх цэгцтэй, үе шаттайгаар хэрэгжүүлдэг, нэгэнт тогтоосон хууль, журмыг иргэд нь аж амьдралдаа тууштай мөрдөн хэвшүүлдэг зэрэг туршлага тодруулан хэлбэл, орчин үеийн нийгэмд ногоон хөгжил хэмээн томъёолж буй эдийн засаг, нийгэм, байгаль экологийн тэнцвэртэй байдлыг хангасан, хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийг хөгжүүлсэн туршлагыг бид бодлого, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнтэй холбоотой дараах хэдэн саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хөгжлийн бодлогын тухайд:
  - Хөгжлийн талаар тууштай залгамж шинжтэй төрийн бодлого хэрэгжүүлэх,

- Тодорхой салбарыг төрийн бодлогоор дэмжин тухайн салбарын бараа бүтээгдэхүүнийг экспортын стандарт шаардлага хангахуйц болтол өсгөн хөгжүүлэх,
2. Бүс нутгийг хөгжүүлэх бодлого, хот төлөвлөлтийн тухайд:
- Хүн амын нутагшилт суурьшлын ерөнхий төлөвлөлтөнд бүс нутгийн онцлог, хүн ам, дэд бүтэц, эрдэс баялаг, хөрш орны хил орчмын үс нутгийн хөгжлийн онцлог зэрэг хүчин зүйлүүдийг тооцсон, үр ашигтай үйлдвэр байгуулах замаар ажлын байрыг бий болгож, нийслэлийн хүн амын нягтралыг сааруулах бодлогыг хэрэгжүүлж, тухайн бүс нутгийн онцлог бүхий хөгжлийг дэмжин дэд хотуудыг хөгжүүлэх,
  - Бүс нутгийн дэд бүтцийг хөгжүүлэхдээ алслагдсан бүс хөрш орны хил орчмын дэд бүтэцтэй хэрхэн уялдаж, хөгжих боломж нөхцлийг судалгааны үндэслэлтэй тодорхойлох,
  - Бүс нутгийн хүн амын нийгмийн хэрэгцээг бүрэн хангахуйц дэд бүтцийг бүтээн байгуулахын хамт чанартай төрийн үйлчилгээг үзүүлснээр хот хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах,
3. Хог хаягдлын менежментийн тухайд:
- Уул уурхай, үйлдвэрийн гаралтай химийн хортой бодисын ашиглалт хэрэглээнд төрөөс хатуу хяналтыг цаг алдалгүй тавьж мөрдүүлэх,
  - Импортоор орж ирж буй бараа бүтээгдэхүүн болон дотоодод үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүний байгаль орчинд үзүүлэх эерэг сөрөг байдалд үнэлгээ хийж, дахин боловсруулж болдог эсэхэд анхаарах, байгальд хоргүй задардаг эсэхэд хяналт тавих,
  - Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь нэн яаралтай ангилж, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах,
4. Байгаль, экологийн боловсролын тухайд:
- Залуу, хойч үеийн байгаль экологийн боловсролд анхаарч, цэцэрлэг, сургуулийн хичээлийн агуулга, сургалтын программд тусгаж амьдралын зөв хэв маягт эртнээс сурган хэвшүүлэх,
  - Иргэд, аж ахуйн нэгжийг оршин суугаа орон нутгийнхаа хог хаягдал боловсруулах аргыг судалж, хог хаягдлыг баялаг гэдэг талаас нь ойлгож ашигладаг болгох дадал хэвшил олгоход анхаарах, сургалт сурталчилгаа, энэ талын мэдлэг мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга тасралтгүй түгээн дэлгэрүүлэх, торгох, урамшуулах зэрэг эдийн засгийн



аргыг хүчтэй оновчтой ашиглах зэрэг цогц арга хэмжээг тууштай хэрэгжүүлж, нийгмийн хяналтыг бүх шатанд тавьж хэвшүүлж хэрэгжүүлэх.

### Ашигласан материал

1. 大川一司、小浜裕久 著『経済発展論—日本の経験と発展途上国—』東洋経済新報社、1995、(Оокава Казүши, Кохама Хирохиса “Эдийн засгийн хөгжлийн онол-Японы туршлага болон хөгжиж буй орнууд-” 1995 он)
2. 広瀬直弘『中小企業政策』日本経済評論社、2006、(Хиросэ Наохиро “ЖДҮ-ийн бодлого” 2006 он)
3. 正村公博『戦後日本資本主義史』東京、1984、(Масамура Кимихиро “Дайны дараах Японы капитализмын түүх” 1984 он)
4. 「立法と調査」2009.11、No.298 (“Хууль ба судалгаа” сэтгүүл, 2009 он 11 сар, №298) [www.sangiin.go.jp](http://www.sangiin.go.jp)
5. 『数字で見る日本の 100 年』改訂第 4 版、国勢社、2000 年、(“Японы 100 жилийг статистикээр харахад” 2000 он)
6. 専修大学都市政策研究センター年報 第 1 号 (追補版) 2005 年 8 月 (Сэншүү их сургуулийн Хотын бодлогын судалгааны төвийн жилийн тайлан, Дугаар 1, 2005 оны 8 сар)
7. 成長戦略 | 首相官邸ホームページ (kantei.go.jp) (Өсөлтийн стратеги, Япон Улсын Ерөнхий сайдын албан ёсны пэйж хуудас)
8. 『日本の廃棄物処理の歴史と現状』2014 年、(Японы хог хаягдал боловсруулалтын түүх, орчин үеийн байдал), 2014 он
9. 環境教育指導資料、文部科学省、1991 年 (“Байгаль орчны боловсролын удирдамж” Боловсрол, шинжлэх ухааны яам, 1991 он)
10. 学習指導要領、総則 (“Сургалтын удирдамж” Ерөнхий зүйл)
11. Ред. Ц.Баатар “Японы ногоон хөгжлийн туршлага” УБ., 2017 он